



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС “ЦАХИМ МОНГОЛ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦ, ҮР ДҮН



Цахим эрин зуунд ирээдүй хойч үеэ дэлхийн түвшинд өрсөлдөхүйц амьдрах үндэс суурь тавигдаж буй түүхэн чухал үед бүх шатанд хариуцлагыг нэмэгдүүлэх, цахим зорилтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна

Гүйцэтгэлийн аудитын тайлан |YAГ-ХБТГ-2023/21-ШТА-ГА| 2023 оны 12 дугаар сар

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Их Хуралд хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хүлээх хариуцлага, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аудитын үйл ажиллагаа, үр дүн нь иргэдийн эрх ашигт нийцсэн байх зарчмыг удирдлага болгон улс, нийтийн хөрөнгийн захиран зарцуулалт, үр дүнг хянаж, үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд шалгагдагч болон аудитад хамрагдагч этгээдийн зарцуулсан төсвийн хөрөнгийн үр ашигтай байдлын хариуцлагыг үнэлснээр улс, орон нутгийн төсөвт 41.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага 2023 оны жилийн зорилтоо “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах жил” болгон тодорхойлж үйл ажиллагаагаа явуулж байна.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС “ЦАХИМ МОНГОЛ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦ, ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

## АГУУЛГА

---

Товчилсон үгийн тайлбар	6
Хүснэгт, дүрслэлийн жагсаалт	8
Төрийн аудитын стандартын мэдэгдэл	10
Хураангуй	12
Зөвлөмж	18

### БҮЛЭГ 1

Хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч салбар хоорондын уялдаа болон хүний нөөцийн дутагдлыг нөхөх бодлого оновчгүй байна	22
--	----

<b>Үндсэн мэдээлэл</b>	23
------------------------	----

Харилцаа холбооны болон бусад салбарын хуулийн уялдааг хангах, салбар дундын зохицуулалт, нийтийн өгөгдөл, мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай	23
---	----

Улсын хөгжлийн урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан цахим шилжилтийн үеийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зангидаж, үнэлэх ажил сул байна	26
--	----

Төрийн албанд ажиллаж буй МХХТ-ийн салбарын хүний нөөцийн бодлогын хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна	31
---	----

“Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөл” ажиллахгүй байна	38
--	----

<b>Дүгнэлт</b>	41
----------------	----

<b>Хавсралт</b>	43
-----------------	----



## БҮЛЭГ 2

Цахим Монгол зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бодит тооцоо судалгаанд үндэслэж оновчтой төлөвлөөгүйгээс арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна

### Үндсэн мэдээлэл

“Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ бодлогын зорилттой нийцэж байгаа боловч хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна

Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нээлттэй, ил тод зарлан мэдээлсэн боловч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг баримтлан ажиллаагүй байна

“Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, явц удаашралтай байна

Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна

### Дүгнэлт

### Хавсралт

50

51

53

57

62

67

72

74

## БҮЛЭГ 3

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа тулгарч буй аюул, эрсдэлээс хоцорч байна

82

### Үндсэн мэдээлэл

83

Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа ч хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

83

Суурь дэд бүтцийн хөгжүүлэлтийг найдвартай судалгаа мэдээлэлд тулгуурлан нэгдсэн бодлого, чиглэлээр удирдан зохицуулах ажиллагаа хангалтгүй байна

86

Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч үр дүнгүй байна

87

### Дүгнэлт

89

### Хавсралт

90

Холбогдох байгууллагын санал

116

“Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг шийдвэрлэсэн байдал

117

Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал

120

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АЖХТ	Аялал жуулчлалын хөгжлийн төв
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БтХ	Барилгын тухай хууль
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодез зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГтХ	Газрын тухай хууль
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗХХА	Захиргааны хэм хэмжээний акт
КАБтХ	Кибер аюулгүй байдлын тухай хууль
МАБ	Мэдээллийн аюулгүй байдал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НМИТБтХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТАЦНС	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТҮМТ	Төрийн үйлчилгээ, мэдээлэл технологи
ТБОНӨХБАҮХАтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

ТӨБЭГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ҮАМАТ	Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮИТ	Үндэсний итгэмжлэлийн төв
ҮДТ	Үндэсний дата төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХНУМТ	Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо
ХЭДТ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
ХХтХ	Харилцаа холбооны тухай хууль
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХХМХтХ	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
ХБТТУтХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХБТГ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХЗХ	Харилцаа холбооны Зохицуулах хороо
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЦХХХ	Цахим хөгжил, харилцаа холбоо
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ЦГҮтХ	Цахим гарын үсгийн тухай хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭММСП	Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ШтХ	Шүүхийн тухай хууль
ШСАА	Шадар сайдын ажлын алба

## ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

### БҮЛЭГ 1

Хүснэгт 1.1	Захиргааны хэм хэмжээний акт боловсруулсан байдал	23
Хүснэгт 1.2	МХХТ-ийн салбарын тооцохгүй байгаа үзүүлэлт	30
Хүснэгт 1.3	Яамдын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт	32
Хүснэгт 1.4	МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт	33
Хүснэгт 1.5	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогод тусгасан МХХТ-ийн салбарын хүний нөөцтэй холбогдох арга хэмжээ	33
Хүснэгт 1.6	ЦХХХЯ-ны МХХТ-ийн салбарт баримтлах хүний нөөцийн бодлогын хэрэгжилт	35
Хүснэгт 1.7	Төрийн албанд ажиллаж байгаа МХХТ-ийн чиглэлийн албан хаагчдын тоо, ангилал	36
Дүрслэл 1.1	Монгол Улсын цахим хөгжлийн төлөвшил	30
Дүрслэл 1.2	Цахим засаглалын хөгжлийн индексийн хугацаан цуваа	30
Дүрслэл 1.3	Яамдын хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, төлөвлөгөө	31
Дүрслэл 1.4	Төрийн үйлчилгээний албанд ажиллаж буй МХХТ-ийн хүний нөөцийн ажилласан жил	36
Дүрслэл 1.5	Цахим оролцооны индекс	39
Хавсралт 1.1	Хууль тогтоомжийн дагуу батлагдаагүй хэм хэмжээний акт	43
Хавсралт 1.2	Зарим төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн мэдээлэл	45
Хавсралт 1.3	МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт	46

### БҮЛЭГ 2

Хүснэгт 2.1	“Цахим Монгол” зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хөрөнгийн хэмжээ	51
Хүснэгт 2.2	Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл нь гэрээ, ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хэрэгжсэн байдал	63
Дүрслэл 2.1	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөв, ангилал	52
Дүрслэл 2.2	Худалдан авах ажиллагааны төрөл	52
Дүрслэл 2.3	Төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал	53



Дүрслэл 2.4	Дүрс архивлан хадгалах (PACS) систем нэгдсэн тогтолцоо	58
Дүрслэл 2.5	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдал	63
Дүрслэл 2.6	Арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байдал	66
Дүрслэл 2.7	Арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөт байдал	68
Дүрслэл 2.8	Арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал	69
Дүрслэл 2.9	Мэдээллийн сангийн үнэн зөв, бодитой байдалд хяналт хэрэгжүүлсэн байдал	71
Хавсралт 2.1	“Цахим Монгол” зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний нийцэл	74
Хавсралт 2.2	“Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээлэл	75
Хавсралт 2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн арга хэмжээний худалан авах ажиллагаа	76
Хавсралт 2.4	Олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн арга хэмжээний худалдан авах ажиллагаа	76
Хавсралт 2.5	Аудитад хамрагдаагүй худалдан авах ажиллагааны жагсаалт	77
Хавсралт 2.6	Цаг хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээний жагсаалт	80
<b>БҮЛЭГ 3</b>		
Хүснэгт 3.1	Хуулийн зүйл заалт болон захиргааны хэм хэмжээний актын нэр зөрүүтэй журам	85
Дүрслэл 3.1	Монгол улсын кибер аюулгүй байдлийн индекс, эрэмбэ	83
Дүрслэл 3.2	Улсын хэмжээнд 2018-2022 онд бүртгэгдсэн цахим гэмт хэрэг	87
Дүрслэл 3.3	Улсын хэмжээнд 2018-2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэгт цахим гэмт хэргийн эзлэх хувь	88
Дүрслэл 3.4	Улсын хэмжээнд 2018-2022 онд бүртгэгдсэн цахим гэмт хэрэг	88
Дүрслэл 3.5	Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол	88
Хавсралт 3.1	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны шалгуур болгож ашигласан эрх зүйн акт, баримт бичиг	90
Хавсралт 3.2	Мэдээллийн технологийн ерөнхий хяналтын эрсдэлийн үнэлгээ	91
Хавсралт 3.3	Түүвэрт хамрагдсан байгууллагуудаас авсан судалгааны нэгтгэл	109

# ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

## АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний 1.3.6, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийг үндэслэн гүйцэтгэв.

## АУДИТЫН КОД

ҮАГ-ХБТГ-2023/21-ШТА-ГА

## АУДИТЫН ЗОРИЛТ

Монгол Улсын Засгийн газраас “Сахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнгийн байдалд аудит хийж, дүнг УИХ-ын Төсвийн болон Инновац, сахим бодлогын Байнгын хороо, Засгийн газар болон шалгагдагч байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргуулахад чиглэгдэв.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Сахим монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй дараах асуудлаар дүгнэлт, зөвлөмж өгөхийг зорив. Үүнд:

- Зорилтыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдсэн эсэх;
- Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл үр нөлөөтэй эсэх;
- Зорилтыг хэрэгжүүлэхэд мэдээллийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал хангагдсан эсэх.

## ХАМАРСАН ХҮРЭЭ

Аудит нь асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох ЦХХХЯ, түүний шууд харьяалж байгаа чиглэл, дэд бүтэц, төрийн үйлчилгээ хариуцсан нэгж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Сахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 86 арга хэмжээг хариуцсан ЗГХЭГ, ЭМЯ, ХЗДХЯ, БХБЯ, ХНХЯ, БОАЖЯ, ТАЗ, ТЕГ, Сангийн яам болон холбогдох бусад байгууллага (ҮИТ, СХЗГ, ТӨБЗГ, ШСАА) хамрагдав.

## АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитад АДБОУС, Монгол Улсын төрийн аудит MNS 6817:2020 стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, бусад заавар, аргачлал, гарын авлага, удирдамжийг мөрдөж ажиллав.

Мөн кибер аюулгүй байдлыг хангасан эсэх үнэлгээг АДБОУБ-аас гаргасан Мэдээллийн технологийн аудитын стандарт, удирдамжийг ашиглав.

Аудитад “Сахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэхэд мөрдөж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, түүнийг дагалдан гарсан дүрэм, журам, заавар, аргачлал, төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрэх үр дүнг шалгуур болгов. Үүнд:

### Бодлогын баримт бичгүүд:

- “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого;
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол “Шинэ сэргэлтийн бодлого”;
- Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”;
- ЦХХХ-ны сайдын 2022 оны А/24 дүгээр тушаал “Сахим Үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027);
- Бусад холбогдох баримт бичгүүд.

**Хууль, тогтоомж:**

- Харилцаа холбооны тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Бусад холбогдох хууль тогтоомж.

**АУДИТЫН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг удирдаж, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын менежер П.Цэнгүүн аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлж, менежер Ж.Батсайхан, Л.Эрдэнэчулуун, ахлах шинжээч Ж.Дэмчигсүрэн, С.Дарьмаа, шинжээч А.Алтангэрэл, Ц.Ариунтуяа, Г.Очирваань, Б.Хонгорзул, Э.Ган-Эрдэнэ, Мэдээллийн технологийн төвийн захирал А.Уянга-Эрдэнэ, шинжээч Б.Жавхлантагөлдөр, Ц.Анударь, Б.Оюунтуяа нар гүйцэтгэв.

**АУДИТЫН  
ХЯЗГААРЛАЛТ**

Аудитыг төрийн аудитын стандарт, тавигдах бусад шаардлага, арга зүйн дагуу гүйцэтгэж аудитын зорилтын дагуу илрүүлсэн асуудал бүрийг энэхүү тайланд тусгав.

Бид “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний явц, гүйцэтгэлд иж бүрэн хяналт шалгалт, үнэлгээ хийхийн тулд хүчин чармайлт гарган ажилласан хэдий ч зарим шалгагдагч этгээд найдвартай бөгөөд хүчин төгөлдөр баримт бичиг, мэдээ тайланг ирүүлээгүй, Төрийн болон албаны нууцын тухай хуулиар тогтоосон хууль эрх зүйн хязгаарлалт, ялангуяа төлөвлөсөн арга хэмжээг нууцын зэрэглэлд хамааруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой судалгааг иж бүрэн, хангалттай, үнэн зөв, бодитой, цаг хугацаанд нь гаргаж ирүүлээгүйгээс аудитын дүнд материаллаг бус хэмжээгээр нөлөөлж болзошгүй юм.

Хуулийн хязгаарлалтаас үүдэлтэйгээр хэрэглээний программ хангамжийн хяналтыг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай хандалт, мэдээллийг олж авахад тулгарсан саад бэрхшээлийн улмаас энэхүү тайланд танилцуулсан илрүүлэлт, дүгнэлтүүд нь зөвхөн хууль эрх зүйн хязгаарлалтын хүрээнд хянагдсан мэдээллийн технологийн аудитын ерөнхий хяналтын үр дүнд үндэслэсэн гэдгийг тэмдэглэж байна.

Бидний аудитын дүн, дүгнэлт нь хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлээр дэмжигдэж байгаа болно.

“Цахим Монгол” зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлсэн 86 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг бүрэн хамруулсан. Нийт 45 арга хэмжээний хүрээнд 144 худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас 24 арга хэмжээний 105 худалдан авах ажиллагааг хянан үзсэн.

Аудитын үр нөлөөт байдлыг хангах, шаардлагатай мэдээллийг олж авахад зарим хууль эрх зүйн зохицуулалт хязгаарлалт үүсгэж байна.

# ХУРААНГУЙ



ҮАГ-аас Монгол Улсын Засгийн газрын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн энэхүү аудит нь төрийн байгууллагуудын МХХТ-ийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэлийн явцад оршиж байгаа ололт болон сул байдлыг чухалчлан тэмдэглэж үр дүнгийн байдлыг тодорхойлох, цаашид цахим шилжилтийн үеийн суурь нөхцөлийг бэхжүүлэх, илэрсэн сөрөг үр дагаврыг арилгаж, эрсдэлийг бууруулахад чиглүүлэх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахад чиглэв.

### **“МХХТ-ийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч салбар хоорондын уялдаа болон хүний нөөцийн дутагдлыг нөхөх бодлого хангалтгүй байна”**

1. МХХТ-ийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд НМИТБтХ, КАБтХ, ХХМХтХ, ЦГҮтХ-ийг баталж, холбогдох захиргааны хэм хэмжээний 31 актыг гаргасан нь цахим хөгжлийг хурдасгахад түлхэц болсон байна. Гэвч төрийн байгууллага, эдийн засаг, нийгмийн салбарууд хоорондын хуулийн уялдаа, зохицуулалт, өгөгдлийн эдийн засгийг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

2. ХХМХтХ, НМИТБтХ-иар хүний хувийн мэдээлэл, иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хэдий ч өгөгдөл үйлдвэрлэгчийн үйлдвэрлэж буй өгөгдөл, мэдээллийг нэгтгэн удирдах зохицуулалт байхгүй байна. НМИТБтХ-д заасан өгөгдөл, мэдээллийн дэд бүтэцтэй холбогдох төлөвлөгөө, нийтлэг журам, баримтлах чиглэл батлагдаагүй,

мөн НМИТБтХ-иар суурь төрөлжсөн сан, нийтийн мэдээллийн системүүдийн нэгдмэл байдал, уялдаа холбоог хангахтай холбоотой харилцааг зохицуулсан хэдий ч хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

3. Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж буй цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, улмаар цахим эдийн засгийг хөгжүүлж, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажил хугацааны хувьд хоцрогдолтой байна.

4. Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогод цахим шилжилтийн үеийн зорилт, арга хэмжээ тусгагдсан байгаа ч үндэсний өгөгдлийг удирдах нэгдсэн бодлогогүй, гүйцэтгэлийг хэмжих үйл явц бүрэн төлөвшөөгүй байна. Монгол улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан МХХТ-ийн салбарын зорилго, зорилт, арга хэмжээ нь “ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, “Цахим үндэстэн” баримтлах чиглэл зэрэг салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсон байна.

5. Өгөгдлийн эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэл, удирдамж болох үндэсний стандартад нийцсэн бодлого, стратегигүй байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна.

6. МХХТ-ийн салбарын бодлогын хэрэгжилтийг хянах зарим үзүүлэлтийг тооцохгүй байгаа нь салбарын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийг хэмжих үйл явц төлөвшихөд саад болж байна.

7. Монгол Улсын цахим засаглалын хөгжлийн индекс 2016 оноос хойш тогтвортой өсөхөд цахим үйлчилгээний индексийн өөрчлөлт голлон нөлөөлсөн байна.

8. Төрийн байгууллагуудын МХХТ-ийн салбарт баримталж буй хүний нөөцийн бодлого оновчгүй, хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогод төрийн албанд ажиллах МХХТ-ийн чиглэлийн хүний нөөцийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлогын зорилт, арга хэмжээ тусгагдаагүй байна. Төрийн албанд ажиллах мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлогыг Засгийн газрын 213 дугаар тогтоолоор баталсан боловч хэрэгжүүлэх арга зам, ойлголт нэг мөр болоогүй байна.

9. Төрийн захиргааны байгууллагууд нь хүний нөөцийг сургах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах бодлогыг баталсан хэдий ч хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөл илэрсэн. Хүний нөөцийн бодлогын баримт бичигт хяналт хийж, цаашид сайжруулах санал, зөвлөмж боловсруулах үүргийг ТАЗ хүлээсэн хэдий ч энэ үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа нь төрийн албанд ажиллах МХХТ-ийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгаа хангагдахгүй байхад нөлөөлөх юм.

10. Төрийн байгууллагын хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлыг бүрэн тодорхойлох, олон улс, бүс нутаг, үндэсний болон салбар, байгууллагын хөгжлийн чиг хандлагатай уялдуулсан төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн, цогц бодлогын шийдлийг боловсруулах шаардлагатай нь аудитын явцад илэрч байна.

11. Салбар бүрийн хөгжлийн бодлого нь МХХТ-ийн салбартай холбогдох зорилт, арга хэмжээгээр дэмжигдсэн энэ цаг үед салбар дундын уялдаа, нэгдмэл байдлыг хангах асуудал чухал ач холбогдолтой тул ЦХХХЯ нь салбар дундын зохицуулалтыг хангах асуудалд онцгой анхаарал тавьж, тусгайлсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

12. Төрийн албан хаагчийн цахим үр чадварыг бүрэн үнэлж, шинжлэх, чадамжид суурилсан бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

13. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг үнэлэх ажил хангалтгүй, хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бүс Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал хангалтгүй

байна. Мөн зөвлөл нь “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу мэдээлэлд үнэлгээ хийхгүй байна.

14. Цахим шилжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах зорилгоор ЦХХХ-ны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг баталж, аймаг бүрд зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан нь үр өгөөжтэй арга хэмжээ болсон байна.



**“Зорилтын хүрээнд дэвшүүлсэн арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл оновчгүй, хариуцан хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хариуцлага, зохион байгуулалт хангалтгүйгээс хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлсөн, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй асуудал илэрч байна”**

15. “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл оновчгүй, хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлээгүйгээс хэрэгжилтэд нөлөөлсөн байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр баталсан 86 арга хэмжээнээс санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлоогүй 11, харин 75 арга хэмжээнд 763.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөвлөжээ.

16. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллээс үзэхэд санхүүжилт хэтэрсэн 3, эх үүсвэрийг баталсан боловч санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүй 8, хууль тогтоомжийн дагуу төсвийн санал хүргүүлсэн

боловч батлагдаагүй 26, төсвийн төсөлд санал хүргүүлээгүй 25 арга хэмжээ байна.

**17.** Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нээлттэй, ил тод зарлан мэдээлсэн боловч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг баримтлаагүй, бараа, ажил үйлчилгээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хангалтгүй боловсруулсан ЭМЯ-ны 2, ХЗДХЯ-ны 1, Сангийн яам болон Төрийн албаны зөвлөлийн хамтран хэрэгжүүлж буй 1, ЦХХХЯ-ны 1 арга хэмжээ байна.

**18.** Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй БОАЖЯ-ны 1, Сангийн яам болон Төрийн албаны зөвлөлийн 1, ХНХЯ-ны 3, ХЗДХЯ-ны 1 арга хэмжээ байна.

**19.** Зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх”, “Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ”, “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах”, “Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлэх” зэрэг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг хянах явцад худалдан авах ажиллагааны зохион байгуулалт болон санхүүгийн эх үүсвэрийн зарцуулалт нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай байдлын зарчмыг хангаагүй, хэрэгжилт хангалтгүй байсан.

**20.** Дээр дурдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 21.8 тэрбум төгрөгийн төсвийг төлөвлөсөн боловч 29.7 тэрбум төгрөгийг баталж, 14.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**21.** Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл удаашралтай байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 38 арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичигт заасан цаг хугацаанд хэрэгжсэн бол 48 нь төлөвлөгөөт хугацаанд хэрэгжээгүйгээс ЦХХХЯ-ны 21, ЗГХЭГ-ын 7, ХЗДХЯ-ны 6, БХБЯ-ны 5, ЭМЯ-ны 5, ТӨБЗГ-ын 2, СХЗГ-ын 1, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 1 арга хэмжээ байна.

**22.** Худалдан авах ажиллагааны 20 арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон бол 4 арга хэмжээ нь ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

**23.** Арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцооны үйлчлэл хангалтгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй ажиллаагүйгээс 28 арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна.

**24.** Цахим шилжилтийн хүрээнд төрийн байгууллагууд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нөөцийг хэрхэн арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байгаад болон төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд дотоод хяналт иж бүрэн хийгдэхгүй, хяналт сул байна. Зорилтын хүрээний 44 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн, 7 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн, 35 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

**25.** Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, систем дэх мэдээллийн үнэн зөв, найдвартай, нууцлал, аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

**26.** ТЕЗ-д төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ залилангийн эрсдэлийг удирдахын тулд зохистой арга хэмжээг авах нь зүйтэй. Цахим зорилтын хүрээний төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан залилангийн эсрэг хариу арга хэмжээ авахгүй байх нь төрийн байгууллагын нэр хүнд, чигч шударга байдал, мэргэжлийн байдалд сөргөөр нөлөөлж, иргэд, олон нийтийн итгэлийг алдахад хүргэж болно.

**27.** Цаашид “Цахим Монгол” зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын дэвшүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөлтийн үед эрсдэлийг хэрэв үнэлсэн бол эрсдэл бүхий гол хэсгүүд, үе шатны ажлууд, эрсдэлийн түвшин, тэдгээр эрсдэлийг удирдах боломж байсныг харгалзан одоо дуусаагүй болон хэрэгжилт удаашралтай, үр дүн хангалтгүй, санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай зогсонги арга хэмжээний хэрэгжилтэд анхаарч залилангийн эрсдэлийг удирдаж ажиллах нь зүйтэй байна.

Тогтолцоо буюу дэвшүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц	Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн түвшин			Эрсдэлийг удирдах буюу бууруулах хариу арга хэмжээ /Өртгийн хувьд үр ашигтай/
		БАГА	ДУНД	ИХ	

**28.** Цахим зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалт, үр дүнгийн байдлын өнөөгийн сургамжид үндэслэн залилангийн эрсдэлийг үнэлэх, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй боловсруулан хэрэгжүүлэх, үргэлжлэн хэрэгжиж буй арга хэмжээний явц, үр дүнг хянах үр нөлөөтэй тогтолцоо, горим бүрдүүлэх асуудлыг судалж нэвтрүүлэх нь юу юунаас чухал болохыг онцлон тэмдэглэж байна.

**29.** Томоохон зорилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй чухалчлан авч үзэх асуудал нь холбогдох төрийн бүхий л байгууллагуудын аливаа нөөцийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах боломжийг үл харгалзаж байгаа явдал бөгөөд улсын төсвийн эх үүсвэрээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл, түүний баталгаажуулалт, мөн төсвийн урсгал зардлын хяналтыг сайжруулж, суурь судалгаанд түшиглэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг хамруулсан мэдээллийн баазыг бий болгох асуудал юм.

**30.** Цаашид үндэсний зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд цогц шийдэлгүйгээр салбар бүрийн “хэт ашиг сонирхолд хөтлөгдсөн, өндөр зардалтай арга хэмжээ”-г хэрэгжүүлэхгүй байхад анхаарч үүний эсрэг нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн үр ашигтай төлөвлөлтөд нийцсэн арга хэмжээг нэгдмэл удирдлагыг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг ЦХХХЯ болон Сангийн яаманд санал болгож байна.

**“Эрх зүйн орчин, хөгжих нөхцөл бүрдсэн ч кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа тулгарч буй аюул, эрсдэлээс хоцорч байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байна”**

**31.** Кибер аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаа төлөвшөөгүй, аюулгүй байдлын чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна. МУЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрмийн 3.1-д “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.” гэж заасан боловч Кибер аюулгүй байдлын зөвлөл нь өнөөг хүртэл нэг ч удаа хуралдаагүй, албан ёсоор асуудал шийдвэрлээгүй байна.

**32.** МУЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор баталсан “Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах ажиллагааг журамлах, хэрэгжилтийг хангаж

ажиллах үүрэг хариуцлага сул байгаа нь ЦХХХЯ болон холбогдох байгууллага, албан тушаалтнууд баталсан бодлого, журам, хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл түгээх, харилцан мэдээлэл солилцох, уялдуулан зохицуулах, зохион байгуулах албан үүргээ хангалтгүй биелүүлж байгаатай холбоотой байна гэж үзэв.

**33.** Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг дүрэм журмын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээний дүнд үндэслэн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг төрийн байгууллага, салбарын хэмжээнд зохион байгуулах нь нэн шаардлагатай байгаа бөгөөд аудитын явцад илэрсэн нөхцөл байдлын “нөлөөлөл”, “тохиолдох магадлал”, “эрсдэлийн түвшин”-ийг үнэлсэн байдлыг харгалзан үзэж холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байгааг тэмдэглэж байна.

**34.** Цахим Монгол зорилтын хүрээнд төлөвлөсөн 86 арга хэмжээний хүрээнд мэдээллийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлын “Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа”, “Эрсдэлийн удирдлага”, “Мэдээлэл технологийн үйлчилгээний удирдлага” гэсэн хүрээнд 13 бүлэг асуудал, 28 асуумжаар 9 байгууллагыг түүвэрт хамруулахад хүлээх үүрэг хариуцлагын зохих шаардлага бүрэн хангагдаагүй, нийтлэг сул талууд илэрсэн нь цахим хөгжлийн суурь нөхцөл хангагдахгүйд хүрэх эрсдэлтэй байна.

Шалгуур үзүүлэлтүүд (бүлэглэсэн)	Эрсдэлийн дундаж үнэлгээ
Төслийн удирдлага ба хяналт	4.1
Чанарын баталгаажуулалт ба туршилт	3.3
Үйлчилгээний удирдлага	3.7
Өгөгдлийн удирдлага	4.5
Дахин сэргээлтийн нөөц	4.0
Бодлого, журам, стратеги	4.3
Үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох, чиглүүлэх, хянах	4.3
Тохиргооны удирдлага	4.3
Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн удирдлага	4.0
Нийлүүлэлтийн удирдлага	5.0
Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зохицуулалт	4.3
Хөрөнгийн удирдлага	4.7
Хүний нөөцийн аюулгүй байдал	5.0

Эрсдэлийн зэрэг	Өндөр	Дунд	Бага
Эрсдэлийн үнэлгээ	4.0-5.0	2.0-3.99	1.0-1.99



**35.** Дээрх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- ТЕЗ болон харьяа байгууллагууд хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэх;
- ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад мөрдөгдөх эрсдэлийн удирдлагын журам батлах;
- ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд эрсдэлийн нөлөөллийг тодорхойлох хугацаат шинжилгээ хийх;
- Байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн бүртгэл хөтлөх;
- Гэмтэл саатлын дараах үйл ажиллагааг нөхөн сэргээх бодлого, төлөвлөгөө батлах;
- Эрсдэлийн үнэлгээний дагуу эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, түүний дагуу туршилт, сургуулилыг зохион байгуулж, хяналт-шинжилгээ хийн, үр нөлөөг үнэлэх зэрэг кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**36.** Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил дэвшил нь иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд үлэмж эерэг өөрчлөлтийг авчирч буйн зэрэгцээ мэдээллийн технологийн ололт амжилтыг ашиглан иргэд, аж ахуйн нэгжийн өгөгдөл, хүний хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй олж авах, залилах замаар эд хөрөнгө, нэр хүндэд нь хохирол учруулах цахим гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж байна.

**37.** Тухайлбал, улсын хэмжээнд 2022 оны байдлаарх цахим гэмт хэргийн тоог 2018 онтой харьцуулахад 13 дахин өсөж, бодит хохирлын дүн 78.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тиймээс бүх шатанд цахим хэрэглээний хариуцлага, мэдээллийн технологийн эрсдэлийн мэдлэгийг нэмэгдүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

**38.** Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах нь чухал бөгөөд суурь дэд бүтцийн хөгжүүлэлтийг бодит судалгаа, мэдээлэлд тулгуурлан төлөвлөх, гүйцэтгэлийг хянах нэгдсэн бодлого, чиглэлээр удирдан зохицуулах ажиллагааг сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

**Аудитын шийдэл:** Бид аудитын дүнд үндэслэн УИХ-ын Инновац, цахим бодлогын Байнгын хороонд 2 асуудлыг толилуулж, хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнгийн байдал, цуглуулсан нотлох зүйлс, тэдгээрийн үнэлгээ, нөхцөл байдлын судалгаа, хийсэн дүн шинжилгээ, аудитын дүн,

дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх 49 зөвлөмжийг 10 шалгагдагч болон холбогдох байгууллага, албан тушаалтанд өгч, 2 арга хэмжээг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 1 албан шаардлага өгч, 3 албан хаагчид сахилгын шийтгэл ноогдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн аялал жуулчлалын салбарын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг цаашид нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзэн эрсдэл бүхий асуудалд чиглэсэн аудитыг гүйцэтгэх нь зүйтэй гэж үзэв.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягтаар нийт 104 асуудлыг ТАЗ, ЦХХХЯ, ХЗДХЯ, ХНХЯ, БОАЖЯ, ЭМЯ-ны холбогдох албан тушаалтанд танилцуулж, тухайн байгууллагын санал тайлбарыг хүлээн авсны үндсэн дээр шийдвэр гарган ажилласан болно.

“Цахим Монгол” зорилтын хүрээнд асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох ЦХХХЯ-нд тайлангийн төслийг хүргүүлж санал авсан бөгөөд нийт 34 санал ирүүлснээс 13 асуудлыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийсэн ба 21 саналыг нь нотлох зүйлээр дэмжигдээгүй тул хүлээн авах боломжгүй байсан.

Аудитын мөрөөр хяналт тавих үе шат буюу шалгагдагч болон холбогдох бусад байгууллагад өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг 2024 онд үнэлж, дүгнэнэ.

Энэхүү аудитыг гүйцэтгэхэд хамтран ажилласан шалгагдагч болон хамрагдагч байгууллагууд болох ЦХХХЯ ба төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан холбогдох яамд, төрийн байгууллагуудад талархал илэрхийлье.



## ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Төрийн аудитын байгууллагаас дараах зөвлөмжийг өгч байна.**

**Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын Байнгын хороонд толилуулах нь:**

- Монгол Улсын хөгжлийн бодлого тогтвортой байх “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн үзэл баримтлалыг хадгалсан цахим засаглалыг дэмжихэд улс төрийн дээд түвшний хүчтэй манлайлал чухал нөлөөтэй тул байгууллага, салбар хооронд цахим засаглал, цахим шилжилтийг нэгдмэл удирдлагаар зохицуулах, уялдааг хангасан чиг үүргийг төрийн захиргааны төв болон тусгай чиг үүргийн байгууллагын удирдах түвшний албан тушаалтны чиг үүрэгт тусгайлан оруулах асуудлаар чиглэл өгөх;
- “Цахим Монгол” зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөт байдлыг асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, тэдгээр хоорондын үйл ажиллагааг нэгтгэсэн байдлаар мэдээлэл сонсох, үр дүнг хянан үзэж шийдвэр гарган, хэрэгжилтийг хангуулах.

**Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн даргад:**

1. Технологийн болон зохион байгуулалтын боломж нөхцөлийг бодит тооцоо судалгаа, мэдээлэлд үндэслэлгүйгээр цахим гарын үсгийн талаар шийдвэр гаргасан нь цахим гарын үсгийг ашиглах боломжгүй болгож, хөрөнгө нөөцийн хохирол учруулж байгаад хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
2. Цахим шилжилт, мэдээллийн нууцлалын үндсэн нөхцөл болох цахим гарын үсэгт шилжих талаар тавьсан зорилт арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнд хараат бус хяналт үнэлгээ хийлгэн, хариу арга хэмжээ авах;

3. Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд тулгамдсан асуудлыг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах замаар Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс тодорхой шийдэл, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах;
4. “Цахим Монгол” зорилтын хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн хангалтгүй холбогдох байгууллагын албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

**Төрийн албаны зөвлөлийн даргад:**

1. Цахим шилжилтийг хурдацтай хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиглэлээрх хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг бодитой тодорхойлж, хөгжлийн чиг хандлагатай уялдсан цогц бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
2. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиглэлээрх хүний нөөцөд аудит хийж, үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх;
3. ХНУМТ системийн хөгжүүлэлтийг хийхдээ ТБОНӨХБАҮХАтХ-ийг мөрдөж ажиллах;
4. ХНУМТ системийн хөгжүүлэлттэй холбоотой зайлшгүй өөрчлөлт хийх тохиолдолд зохих хууль дүрэм, журамд холбогдох өөрчлөлтийг оруулах;
5. ХНУМТ системтэй холбоотой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ үр өгөөж, үр ашгийг тооцож, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, төсвийн үр ашигтай зарцуулалтад анхаарах, хяналтын тогтолцоог сайжруулах, хариуцсан ажилтны

ажил үүрэг болон нэгж хоорондын харилцан уялдааг хангахуйц байдлаар албан тушаалын тодорхойлолтыг оновчтой болгож, тэдгээрийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах;

6. Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ системийн серверт хандах эрхийг олгох, системийн хөгжүүлэлтэд хөндлөнгийн болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, уг системд бүртгэлтэй мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, хүчин төгөлдөр байдалд нарийвчилсан хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, гарсан зөрчлүүдийг арилгуулж, мэдээллийн өөрчлөлт баяжилтыг нотолгоонд суурилсан зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг байх, системийн ашиглалтад хяналт тавих горим тогтолцоог бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### Үндэсний статистикийн хорооны даргад:

1. Төрийн нэгдсэн өгөгдлийн сангийн загвар, хамрах хүрээг бүрэн тодорхойлж, баталсан аргачлалын дагуу статистикийн тухай хуульд заасан албан ёсны статистикийн мэдээллийг тооцож, ашиглах үзэл баримтлал, стратеги (замын зураглал)-ийг боловсруулах;
2. МХХТ-ийн салбарын бодлогын хэрэгжилтийг хэмжих, үнэлэх ажилд ахиц гаргах хүрээнд салбарын үзүүлэлтийг тооцох арга зүй, ангилал, мэдээллийн эх үүсвэрийг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж ажиллах.

#### Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Цахим засаглалын тогтвортой хөгжлийг хангахад улс төрийн дээд түвшний манлайлал чухал нөлөөтэй тул салбарын цахим засаглал, шилжилтийг нэгдмэл удирдлагаар зохицуулах, салбар хоорондын уялдааг хангах чиг үүргийг дэд сайдын чиг үүрэгт тусгах талаар судалж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд баталсан цахим засаглал, хөгжлийн чиглэлээрх нийтлэг болон салбар бүрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн, төрийн байгууллагууд хоорондын уялдааг хангах, үнэлэх ажлын зохион байгуулалт, түүний хяналтын үр нөлөөг сайжруулж арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;
3. Төрийн байгууллагуудын дотоод хяналтын тогтолцооны үйлчлэл, үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг үнэлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх.

#### Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дэд даргад:

1. Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай

хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж шинэчлэн сайжруулах арга хэмжээ авах, харилцаа холбооны салбарын дэд бүтэц, түүнд тавих хяналт, хариуцлагын асуудлыг холбогдох хууль, эрх зүйн актаар нарийвчлан зохицуулж, хууль хоорондын уялдааг хангах;

2. Өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах, түүнээс бий болох үр өгөөж, боломж, ач холбогдлыг Засгийн газрын бүх түвшинд болон иргэд, олон нийтэд таниулан сурталчлах;
3. НМИТБТХ-ийн 27.8, 29 дүгээр зүйлд заасан “мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр ЦХХХЯ-нд бүртгүүлэх”, “мэдээлэл хариуцагч систем хөгжүүлэхийн өмнө салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дүгнэлт, зөвлөмж авах” тухай зохицуулалтын хэрэгжилтэд анхаарч, үйлчлэлийг сайжруулах, хуулийн зохицуулалтуудыг “заавал” биелэгдэх шинжтэй болгон нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг судалж, санал боловсруулан хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Төрийн албан хаагчдын МХХТ-ийн үр чадварыг бүрэн үнэлж, тодорхойлох, түүний үр дүнд үндэслэн цогц бодлого боловсруулах, Төрийн албаны зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Төрийн байгууллага, хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн бий болгож байгаа өгөгдлийг удирдах, засаглалыг хөгжүүлэх замаар өгөгдлийн эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал үр нөлөө бүхий стратегийг үндэсний стандартад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
6. МХХТ-ийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, түүний хэрэгжилтийг хянаж, удирдахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болгоход анхаарал хандуулах, энэ хүрээнд оролцогч талуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, салбарын бодлогын судалгаа, шинжилгээний ажлын нэгдсэн төлөвлөлтийг хийх, хөгжүүлэх;
7. Бүх нийтийн цахим үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тайлагнах, хариуцсан байгууллагуудын хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны нэгдмэл, уялдаа холбоог хангах;
8. Салбарын хуулиудад тусгагдсан ч батлагдаагүй бодлогын баримт бичгүүд, эрх зүйн хэм хэмжээний актыг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулах;
9. Мэдээллийн технологийн хүрээнд төрийн байгууллагуудын боловсруулж буй ажлын даалгавар, гэрээний төсөлд мэргэжлийн

зөвлөгөө, арга зүйгээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

10. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажлын санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
11. Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу боловсруулж батлуулах ёстой бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, аргачлалыг эцэслэн баталгаажуулж дуусгах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, уялдуулан зохион байгуулах;
12. Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрөөс баримталж буй бодлого, стратеги, хууль тогтоомж, дүрэм, журам, аргачлал зэрэг эрх зүйн акт, баримтын талаар сургалт, мэдээлэл бэлтгэж, холбоотой талуудад түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
13. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой тулгамдсан асуудлуудыг эрэмбэлж, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлэх;
14. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн хөрөнгө, хүний нөөцийг бодитой тооцоолж, нөөцийн дутагдлыг шийдвэрлэх замаар Кибер аюулгүй байдлын талаарх бодлого, стратеги, дүрэм, журмын хэрэгжилтийг зохицуулах, хянах үүрэг бүхий бүтцийн нэгжийг бүрэн хүчин чадлаар ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
15. Мэдээллийн технологийн салбарт шаардлагатай байгаа хөрөнгө, санхүүгийн нөөцийн хэмжээ, тэдгээрийн эх үүсвэрийг тодорхой болгож, санхүүжилт, гүйцэтгэлийг нэгдсэн удирдлага, хяналтаар хангаж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
16. Төрийн байгууллагуудын боловсруулж, хөгжүүлсэн систем, программ хангамжуудыг биет бус хөрөнгөд тооцон бүртгэх чиглэл зааварчилгаа гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;
17. Техник хангамж, программ хангамжийн худалдан авах ажиллагааны онцлог, нөхцөл байдлыг харгалзан худалдан авах ажиллагааг зохион байгуулах тусгай бодлого, аргачлалыг холбогдох салбарын яамтай хамтран боловсруулж баталгаажуулах;
18. Цахим гэмт хэргийг илрүүлэхтэй холбоотой тоон ул бэхжүүлэх шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг шинэчлэх, албан хаагчдыг сургах, холбогдох байгууллагатай мэдээлэл, туршлага солилцох асуудлыг холбогдох байгууллагуудын оролцоог хангах замаар салбарын хэмжээнд тодорхой бодлого, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

19. Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг дүрэм, журмын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээний дүнд үндэслэн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах. /Хавсралт 3.2-ыг үзнэ үү/

#### Сангийн сайдад:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авах;
2. “Цахим Монгол” зорилтыг хангах суурь дэд бүтэцтэй холбоотой төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллах;
3. Цахим зорилтын хүрээнд улсын төсөв болон гадаад эх үүсвэрээр салбар бүрд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, төвлөрсөн арга хэмжээний бүртгэл, мэдээллийг нэгтгэн тайлагнах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### Хууль зүй, дотоод хэргийн сайдад:

1. НМИТБТХ-д заасны дагуу ХЗДХЯ-ны дэргэд ажиллах “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бүс зөвлөл”-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, Зөвлөлийн үйл ажиллагаа нь хүлээлтэд хүрэхгүй, олон нийтийн хандалт, хүсэлтэд нийцэхгүй байгаад анхаарч холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн үр дүнг олон нийтэд мэдээлэх.

#### Эрүүл мэндийн сайдад:

1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн болон мэргэшсэн байгууллагын дүгнэлт гаргуулан үр нөлөөг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд программ, систем шинээр үүсгэх, хөгжүүлэхдээ одоо ашиглаж буй систем, програмуудтай уялдуулан зохицуулахад анхаарч, салбарын нэгдсэн өгөгдөл, мэдээллийн сан бүрдүүлж, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад:**

1. Үйлчлүүлэгч төвтэй аргачлал буюу хөдөлмөр эрхлэх чанарын үнэлгээний модулийн батлагдсан санхүүжилтийн зардлын төрлийг тодорхой болгож арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг сайжруулах.

**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад:**

1. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2-т заасны дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулсан тухай бүр хавтаст хэрэг бүрдүүлж, түүний иж бүрдлийг ханган архивын нэгж болгон хадгалах.

**“Шахим Монгол” зорилтын хүрээнд төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж буй Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:**


1. НМИТБТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасан мэдээлэл хариуцагч мэдээллийн цахим санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр бүртгүүлэх, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргуулах, мөн хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллах;
2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллан, сайжруулах зөвлөмж, чиглэл өгч, түүний хэрэгжилтийг тогтмол үнэлж байх;
3. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй томоохон хэмжээний мэдээллийн технологийн төслүүдийн хэрэгжилтэд тогтмол хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх;
4. Төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн систем, программ хангамжуудын уялдаа холбоо, нэгдмэл байдал, санхүүжилт, явц, хэрэгжилтэд тавих нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
5. Шаардлагатай байгаа төсөв, санхүүжилтийн хэмжээг бодитой тооцох, тэдгээрийн эх үүсвэрийг тодорхой болгож шийдвэрлүүлэх, санхүүжилт, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангаж ажиллах;
6. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТБОНӨХБАҮХАТХ-ийн заалтууд болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын зүйл заалтуудыг дагаж мөрдөх, тооцоо судалгаанд үндэслэж цаашид гарах урсгал зардлыг болон гарч болох

эрсдэлийг тодорхойлж хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

7. Системийн өгөгдлийн санд “Аудитын лог” эрх үүсгэж, холбогдох аудит, хяналт шалгалт хийх эрх бүхий этгээдэд системийн гол үйлдлүүдийн түүх, хийсэн өөрчлөлтүүдийг олж илрүүлэх, таньж мэдэх, судлах, дүн шинжилгээ хийх, цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан мэдээлэл, баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэх.

# БҮЛЭГ 1

**Хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч салбар хоорондын уялдаа болон хүний нөөцийн дутагдлыг нөхөх бодлого оновчгүй байна**



## Үндсэн мэдээлэл

Төрийн үйл ажиллагааны цахим бодлогын хүрээнд 2005 онд “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш үе шаттайгаар ээлжит хөтөлбөрүүдийг баталж ирсэн байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны баримт бичиг, мөн 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Цахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх суурь баримт бичиг болж байна.

Засгийн газраас 2022 онд дэлхийн хөгжингүй улс, орнуудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн бүтцэд “Цахим хөгжил, харилцаа холбооны яам”-ыг байгуулснаар цахим шилжилтийн хүрээний бодлого, төлөвлөлтийн арга хэмжээг нэгтгэн зангидах үндсэн чиг үүргийг хүлээж байна.

УИХ-аас 2021 онд МХХТ-ийн салбарын гол зангилаа бүхий багц 4 хуулийг баталсны дээр ЦХХХ-ны сайдын 2022 оны А/24 дүгээр тушаалаар “Цахим Үндэстэн” баримтлах чиглэлийг батлан хэрэгжүүлж эхэлжээ.



Хүснэгт 1.1 Захиргааны хэм хэмжээний акт боловсруулсан байдал (тоо)

Хуулийн нэр	Батлагдсан он	Батлагдвал зохих хэм хэмжээний акт	Батлаагүй	Хариуцах субъект	Батлах субъект
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	2021	21	5	ЦХХХЯ	Засгийн газар, СХЗГ
Кибер аюулгүй байдлын тухай хууль	2021	10	2	ТЕГ, ЦХХХЯ	Засгийн газар, ЦХХХЯ
Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	2021	4	2	ЦХХХЯ	ЦХХХЯ
Цахим гарын үсгийн тухай хууль	2021	8	5	ЦХХХЯ	ЦХХХЯ, СХЗГ
Нийт	-	43	13	-	-

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, ЦХХХЯ-ны ирүүлсэн мэдээлэл

## Харилцаа холбооны болон бусад салбарын хуулийн уялдааг хангах, салбар дундын зохицуулалт, нийтийн өгөгдөл, мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай

### “Харилцаа холбооны болон бусад салбарын хуулийн уялдаа, үүрэг хариулагыг харгалзсан нэмэлт, өөрчлөлт хэрэгтэй”

1.1 Цахим хөгжлийг дэмжсэн салбарын хурдацтай хөгжил, эрх зүйн шинэчлэлийн хэтийн чиг хандлагад нийцүүлэн салбарын хууль, бодлогын цоо шинэ орчныг бий болгож, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын дагуу 2021 оноос эрх зүйн шинэчлэл эрчимжиж ирсэн нь бодлогын зорилттой нийцэж байна.

- Радио долгионы тухай хууль (1999 он);
- Харилцаа холбооны тухай хууль (2001 он);
- Шуудангийн тухай хууль (2003 он);
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019 он);
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021 он);
- Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021 он);
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021 он);
- Цахим гарын үсгийн тухай хууль (2021 он) зэрэг хуулийн шинэчилсэн найруулга болон багц хууль батлагджээ.

1.2 МХХТ-ийн салбарын хууль тогтоомжийн хүрээнд нийт 74 захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлэхээс өнөөгийн байдлаар 51 хэм хэмжээний актыг батлан мөрдөж байна. Тухайлбал, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд баталсан цахим хөгжлийн багц хуулийн /НМИТБтХ, КАБтХ, ХХМХтХ, ЦГҮтХ/ дагуу нийт 43 захиргааны хэм хэмжээний акт батлан хэрэгжүүлэхээс 31-ийг баталсан байна. /Хавсралт 1.1-ийг үзнэ үү/

**1.3** Харилцаа холбооны салбарын гол хууль болох “Харилцаа холбооны тухай хууль”-ийг 2001 онд шинэчлэн баталсан бөгөөд үүнээс хойш 20 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Цаашид МХХТ-ийн салбарын хөгжлийг тодорхойлоход салбарын хуулиуд шаардлагад нийцэж байгаа эсэх, улмаар шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор хуулийн фирмээр Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэж байна.

**1.4** Радио долгионы тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш үе үеийн Засгийн газрын бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөн боловч тус хуульд нэмэлт өөрчлөлт оролгүй явсаар 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Улмаар зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан 2023 оны 01 дүгээр сард өөрчлөлт оржээ.

**1.5** Цаашид радио давтамжийн ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэхэд анхаарч, Радио давтамжийн тухай хууль бодитой хэрэгжиж байгаа эсэхэд үр дагаврын үнэлгээ хийх цаг хугацааны болон практик хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

**1.6** Шуудангийн тухай хууль 2003 онд батлагдсан бөгөөд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөндөгдөж буй асуудал нь “хаягжилтын асуудал” байна. Тодруулбал, хаягжилтын зөрүүтэй, тодорхойгүй байдлаас шалтгаалан шуудангийн илгээмжийг үйлчлүүлэгчид түргэн, шуурхай хүргэх боломжгүй тохиолдлууд цөөнгүй гарч байна.

**1.7** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2 дахь зорилтод “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд “Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно” гэсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 2022 онд хаягжилтын асуудлыг цэгцлэх зорилгоор ЦХХХЯ, БХБЯ-тай хамтарч ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

**1.8** Түүнчлэн, ШТХ-ийн 8 дугаар зүйл<sup>1</sup>-д бүх шатны Засаг дарга хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай зохицуулсан. Уг заалтын дагуу шуудангийн 1 ШТХ-ийн 8.1.1. хүн амд шуудан, хэвлэл хүргэх ажлыг зохион байгуулах, цаг үеийн болон байнгын саад бэрхшээл бүхий газарт байрладаг үйлчлүүлэгчид шуудангийн илгээмж хүргэхэд үйлчлэгчид дэмжлэг үзүүлэх

илгээмж хүлээн авагчийн оршин суугаа хаягийн талаарх мэдээллийг тодруулахаар шуудангийн байгууллагаас холбогдох Засаг даргад ханддаг боловч оршин суугаа газрын хаягийн мэдээлэл нь ХХМХТХ-д заасан “хүний хувийн мэдээлэл”-д хамаарах тул энэ талаар мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдал үүсдэг байна.

**1.9** ЦХХХЯ-наас “бичгээр” буюу “цаасан хэлбэрээр” гэсэн агуулга бүхий хуулийн зүйл заалтыг судалж, улмаар 120 хуульд “цахимаар” гэсэн нөхцөлийг нэмж тусгахаар төслийг боловсруулж, Инновац, цахим бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж байна. Харин Эрүүл мэндийн тухай хуульд, магадалгааны нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээнд ашиглаж байгаа программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмуудыг батлах, Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай хуульд цахим баримт бичгийг эх хувь байж болох тухай зэрэг цахим шилжилттэй холбоотой агуулга, зарчмын томоохон нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

**1.10** МХХТ-ийн салбарт мөрдөж байгаа болон салбар дундын иж бүрэн шийдэл, зохицуулалтын нэгдмэл байдалд хүрч чадаагүй, цаашид нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих хөрөнгө оруулалт, дэд бүтэц, бүтээн байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэлд тавигдах шаардлагыг хангуулан хянахтай холбоотой дараах асуудал хөндөгдөж байна.

**1.11** Тухайлбал, Харилцаа холбооны салбарын суурь дэд бүтэц, түүнд тавих хяналт, хариуцлагын асуудлыг хууль, эрх зүйн актаар нарийвчлан зохицуулах, ялангуяа ХХТХ, БТХ, ГТХ-иудыг уялдуулах шаардлагатай байна. Үүнд:

- Барилгын дотор холбоо дохиолол, гадна шугам сүлжээнд хяналт тавих эрх зүйн зохицуулалт байхгүй;
- Хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн харилцаа холбооны зориулалт бүхий шугамаас дараагийн барилгад техникийн нөхцөл өгөх зохицуулалтгүй /худаг сувагчлал ашиглалтгүй, холбооны шугамын оруулгыг барилгын цонх, хаалгаар хийдэг/ орон нутагт шинэ хороолол төлөвлөж, дэд бүтцийг байгуулахдаа холбооны шугам сүлжээг орхигдуулдаг, зураг төсөлд хяналт хийгддэггүй;
- Хувийн хөрөнгө оруулалттай дунд төвөгшилтэй барилга байгууламжийн угсралтын ажлын мэдээлэл байхгүйгээс хяналтаас гадуур орхигддог, үүрэн холбооны операторууд орон нутагт сүлжээ байгуулах, өргөтгөх гэх мэт ажилд тавигдах хяналт сул.



**1.12** ЦХХХЯ-ны зохион байгуулалтын бүтэц дэх Салбарын хяналтын газар болон Харилцаа холбооны зохицуулах хороонд ажиллах улсын байцаагчийн хяналтын чиг үүргийн хүрээ, эрх хэмжээний асуудлыг зааглаж, зохицуулалтыг тодорхой болгон хууль, эрх зүйн хэм хэмжээний актад тусгах шаардлагатай байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬ	
Зохицуулах хороонд харилцаа холбооны улсын байцаагч ажиллана. <b>[8.7]</b>	Зохицуулах хороо болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажиллах улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу олгоно. <b>[30.4]</b>
ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ	
Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг эрхлэх асуудлынх нь хүрээнд хамаарах төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно. <b>[9.4]</b>	

**“Нийтийн өгөгдлийн дэд бүтцийн хууль эрх зүйн иж бүрэн орчин хангалтгүй байна”**

**1.13** ХХМХТХ-иар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж, НМИТБТХ-иар иргэний мэдээлэл авах эрхийн эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн гэх боловч төр, хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, шинжлэх ухааны байгууллага, олон улсын байгууллагын үйлдвэрлэж буй өгөгдөл, мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл хэлбэрээр олон нийтэд түгээж, эдийн засгийн эргэлтэд оруулахад мэдээлэл хариуцагч төрийн байгууллагуудын идэвх санаачилга дутагдаж байна.

**1.14** НМИТБТХ-ийн 27.8<sup>2</sup>, 29.1<sup>3</sup> дүгээр зүйлд суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, нийтийн мэдээллийн системүүдийн нэгдмэл байдал, уялдаа холбоог хангахтай холбоотой харилцааг зохицуулсан нь сайшаалтай хэдий ч практикт хяналт тавих хуулийн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

**1.15** НМИТБТХ-д заасан дараах баримт бичиг, эрх зүйн хэм хэмжээний актыг батлаагүй бөгөөд төсөл боловсруулах явц хангалтгүй байна. Үүнд:

**2** НМИТБТХуулийн 27.8 дахь заалт. Мэдээлэл хариуцагч суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

**3** НМИТБТХуулийн 29.1 дэх заалт. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулна

- Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт [НМИТБТХ-ийн 28.1];
- Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журам [НМИТБТХ-ийн 28.3];
- Нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл хөгжүүлэхэд төрөөс баримтлах чиглэл [НМИТБТХ-ийн 32.1.10].

**“Хөгжлийг дэмжихэд салбар дундын асуудлыг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг сайжруулж манлайлыг бий болгох хэрэгтэй”**

**1.16** Салбар бүрийн МХХТ-той холбогдох арга хэмжээг нэгтгэн зангидсан бодлогогүй, хөрөнгө оруулалтын их хэмжээний давхардалтай байгаа нь төсвийн үр ашиггүй байдлыг бий болгож буй томоохон хүчин зүйл бөгөөд салбар хоорондын уялдаа холбооны асуудлыг үндэсний хэмжээнд авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

**1.17** ХХТХ-д 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх салбар хоорондын үйл ажиллагаа”-г буюу тодруулбал, ХХТХ-ийн 6-д Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх тухай заасан ба салбаруудын хэрэгжүүлж байгаа МХХТ-ийн төсөл хөтөлбөрүүдийг нэгдмэл бодлогоор хангах, төлөвлөлтөд хяналт тавих, чиглүүлэх бүрэн эрх, чиг үүргийг ЦХХХЯ хариуцан хэрэгжүүлэхээр байна.

**1.18** Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 19 дүгээр захирамжаар төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, цахим эдийн засгийг хөгжүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий ЦХХХ-ны сайдаар ахлуулсан бусад 15 яамдын ТНБД нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн ажлын явц, үр дүнг Засгийн газарт 2023 оны 07 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг даалгасан боловч тайлагнаагүй байна. ЦХХХЯ нь дээрх ажлын хэсгийн ажлын үр дүнгийн талаарх танилцуулгыг 01/2212 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т 2023 оны 10-р сард хүргүүлсэн байна.

**1.19** Өмнө дурдсан НМИТБТХ-ийн 27.8, 29.1 дэх зохицуулалтууд нь салбар дундын нэгдмэл байдлыг хангахтай холбоотой чухал зохицуулалтууд боловч хэрэгжилт сул, өөрөөр хэлбэл мэдээлэл хариуцагчид, өндөр үнийн дүн бүхий, чанаргүй, олон тооны систем хөгжүүлдэг явдал хяналтгүй хэвээр байна. Түүнчлэн төрийн байгууллагуудын

улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн МХХТ-ийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн нэгдсэн мэдээлэл, бүртгэл байхгүй байна. Тухайлбал,

- НМИТБТХ-ийн 29.1 дэх заалт: мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, аюулгүй, найдвартай байдлын шийдэл, бусад шаардлагатай асуудлаар ЦХХХ-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт, зөвлөмж гаргуулах тухай зохицуулсан.
- Мөн хуулийн 29.3-т “Энэ хуулийн 29.1, 29.2\*-т заасан үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан бөгөөд тус журмыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ЦХХХ сайдын А/18 дугаар тушаалаар баталсан.
- Уг журмын 1.2-т Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан мэдээлэл хариуцагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2, 18.5.1, 18.5.3, 18.5.4, 18.5.5, 18.5.6-д заасан нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд систем үүсгэхэд зөвлөмж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө, мөн 3.6-д энэ журмын 3.3-т заасан зөвлөмж, дүгнэлтийн нэгдсэн тайланг хагас жил тутамд Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ гэж тус тус заасан байна.

**1.20** ЦХХХЯ-наас НМИТБТХ-ийн 29.1 дүгээр зүйлийг үндэслэн дүгнэлт, зөвлөмж гаргасан гэх боловч нотлох зүйл /тоо, мэдээлэл/ олдоогүй, мөн ЦХХХ-ны сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталсан зөвлөмж, дүгнэлт гаргах журамд заасан нэгдсэн тайланг гаргаагүй байна.

**1.21** Цахим хөгжлийг хурдасгахад ЦХХХЯ нь голлох үүрэг хүлээж байгаа хэдий ч салбар бүрийн үүрэг, идэвх оролцоо, хүсэл эрмэлзэл идэвхжил илүү чухал байна.

\* 29.2. Энэ хуулийн 34.1.2-т заасан стратеги төлөвлөгөө болон нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь энэ хуулийн 28.1-д заасан ерөнхий төлөвлөлт, энэ хуулийн 32.1.10-т заасан баримтлах чиглэлтэй нийцсэн байна.

## Улсын хөгжлийн урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан цахим шилжилтийн үеийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зангидаж, үнэлэх ажил сул байна

Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтот арга хэмжээг “Цахим Монгол” зорилтын хүрээнд дэвшүүлсэн байна


**1.22** МУЗГ-аас төрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг 2005 онд анх баталснаас хойш төрийн үйлчилгээг цахим болгох, цахим засаглалыг төлөвшүүлэх хүрээнд үе шаттай хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж ирсэн байна<sup>4</sup>.

**1.23** Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Шинэ сэргэлтийн бодлого”, богино хугацааны бодлогын баримт бичиг болох “Улсын хөгжлийн жилийн 2022, 2023 оны төлөвлөгөө” зэрэгт тусгагдсан МХХТ-ийн салбарын зорилго, зорилт, арга хэмжээний агуулга нь “ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, “Цахим үндэстэн” баримтлах чиглэл зэрэг салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсон байна.

**1.24** Тус салбарын бодлогын хүрээ нь “хатуу, зөөлөн дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, инновац үйлдвэрлэл, салбаруудыг мэдээлэл, харилцаа холбоо, технологиор дэмжих” гэсэн үндсэн чиглэлүүдийг хамарч байна.

**1.25 Алсын хараа:** Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг баталсан. Тус баримт бичигт “Цахим Монгол” /иргэн, төр, хувийн хэвшил/ агуулгын хүрээг гаргаж, “Хүний хөгжлийг

<sup>4</sup> Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор 2019-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг хүчингүй болгож, түүнд тусгагдсан зорилго, зорилтыг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудад тусган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.



дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна. Зорилтыг хэрэгжүүлэх эхний үе шат буюу 2021-2030 онд “Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх”-ээр заасан бөгөөд 5 чиглэлээр хүрэх үр дүнг нэгтгэн тодорхойлж, 23 арга хэмжээг, мөн бусад зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд цахим хөгжил, мэдээлэл, харилцаа холбоо, технологид түшиглэсэн арга хэмжээг тусгасан.

**1.26 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр:** Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”<sup>5</sup>, МҮЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”<sup>6</sup>-г тус тус баталсан.

**1.27 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-**

<sup>5</sup> ХБТТУХ-ийн 4.1.8. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг,

<sup>6</sup> ХБТТУХ-ийн 4.1.9. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг,

д “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ агуулгын хүрээнд “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дээрх зорилгыг хэрэгжүүлэх 10 зорилт, 65 арга хэмжээг төлөвлөсөн байна.

**1.28** Дээрх хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээнүүд нь “Цахим Монгол” тухайлсан зорилтын хүрээг хамарч байгаа бол бусад зорилтын хүрээнд “Цахим Монгол”-ын арга хэмжээний хүрээнд гэж тодотгон, уялдуулж төлөвлөсөн 5 зорилт, 21 арга хэмжээг төлөвлөсөн буюу нийт 86 арга хэмжээ байна. Бусад зорилтын хүрээнд “Цахим Монгол” арга хэмжээтэй уялдуулан төлөвлөсөн дараах 4 салбарын арга хэмжээ байна. Үүнд:

- Эрүүл мэнд;
- Барилга, хот байгуулалт;
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал;
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбар багтаж байна.

**1.29** Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1-д “Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх,

эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” зорилгын хүрээнд 14 зорилт дэвшүүлсэн. Эдгээр зорилтын нэг нь 2.1.6 буюу “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ гэсэн зорилт бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх 8 арга хэмжээг тусгасан байна.

**1.30** Арга хэмжээний төлөвлөгөөнд батлагдсан нийт арга хэмжээнээс гадна “цахим”, “мэдээллийн систем”, “блокчейн”, “хиймэл оюун ухаан”, “мэдээллийн аюулгүй байдал”, “өгөгдөл” гэсэн МХХТ-ийн салбарыг түшиглэсэн бусад салбарын зорилтуудад хамаарч буй 180 гаруй арга хэмжээ багтсан байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР [4.1]	
АГУУЛГА	"Цахим Монгол"-төрийн шуурхай үйлчилгээ
ЗОРИЛГО	"Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	
Хөтөлбөрийн 4.1 дэх зорилгыг хэрэгжүүлэх "Цахим Монгол" тухайлсан 10 зорилт, 65 арга хэмжээ	"Цахим Монгол" арга хэмжээг дэмжсэн бусад салбарын 5 зорилт, 21 арга хэмжээ
Бусад салбарын зорилтуудад хамаарах "цахим", "мэдээллийн систем", "блокчейн", "хиймэл оюун ухаан", "мэдээллийн аюулгүй байдал", "өгөгдөл" гэсэн үг орсон 180 гаруй арга хэмжээ	

**1.31** Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогод тусгасан цахим засаглал, цахим хөгжлийн тухайлсан зорилт, арга хэмжээ болон бусад салбарын хөгжлийн бодлогыг дэмжсэн цахим хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтүүдийг нэгтгэн, салбар хоорондын уялдааг хангах, үнэлэх, хянах ажил хийгдэхгүй байна.

**ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө нь “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах” журмын шаардлагыг хангахгүй байна**

**1.32** МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг шинэчлэн баталсан. Тус журмын 2.7.5-д “стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох” гэж заасан боловч ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 оны үйл ажиллагааны стратегид тусгасан 53 арга хэмжээнээс 41 нь санхүүжилтийн эх үүсвэргүй, 12 нь санхүүжилтийн мөнгөн дүн тодорхойгүй байна.

**1.33** Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг нарийн тооцоо, судалгаанд үндэслэн тодорхойлох нь бодлого, төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэхэд шууд нөлөөлөх хүчин зүйл тул боловсруулалтад анхаарах нь зүйтэй байна.

**“Үндэсний өгөгдлийн системийг удирдах нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүй байна”**

**1.34** “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дугаар зорилтын 1 дүгээр үе шат, хүрэх үр дүнгийн 2 дахь заалтад “Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө”, тус зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3.5 дахь заалтад “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно” гэж, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1-д “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэдэд цахим гарын үсэг олгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

**1.35** Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны 454 дүгээр тэмдэглэлээр “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан байгуулах, мэдээллийн

нэгдсэн тогтолцоог бий болгох асуудлаар ҮСХ, ЗГХЭГ, ЦХХХЯ хамтран холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, ЦХХХ-ны сайд нарт даалгажээ.

**1.36** Уг асуудлын хүрээнд “Монгол Улсын өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл” баримт бичгийн төслийг ҮСХ, ЦХХХЯ хамтран боловсруулсан хэдий ч их өгөгдлийн ашиглалт, мэдээлэл солилцоо, эргэлтэд оруулах горим тогтолцоог дэмжсэн бодлогын цогц шийдлийг хараахан бүрэн тодорхойлж чадаагүй байна.

**1.37** ЦХХХ-ны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэлд өгөгдлийн талаар тодорхой тусгасан чиглэл, стратегийн арга хэмжээ байхгүй байна.

**1.38** МУЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 164 дүгээр тогтоолын хавсралтаар төрөлжсөн бүртгэлийн жагсаалтыг баталсан. Уг тогтоол ёсоор Улсын бүртгэлийн тухай хуулийн 5.2<sup>7</sup>-т зааснаас бусад хуульд заасан бүртгэлийг хөтөлж, сан үүсгэхийг холбогдох байгууллагуудад, уг бүртгэл хөтөлөх үйл ажиллагааг цахимжуулах ажлыг ЦХХХЯ-нд даалгасан байна. Гэвч энэ тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнг хянаж удирдах байгууллагыг тодорхойлж батлаагүй байна. Төрөлжсөн бүртгэлийн жагсаалтад 152 мэдээллийн сан байхаар баталсан ба одоогоор эдгээр бүртгэл, мэдээллийн сангаас бий болсон болон бий болгох шаардлагатай бүртгэлийн талаарх нэгдсэн тоо, мэдээлэл ЦХХХЯ-нд байхгүй байна. ҮСХ-ны 2022 онд хийсэн төрийн байгууллагуудын өгөгдлийн сангуудын нөхцөл байдлын судалгааны үр дүнгээр 38 төрийн байгууллага 75 өгөгдлийн санг ашиглаж байгаа ба энэ нь аль хэдийн бий болсон бүртгэл, мэдээллийн сангийн хүрээг хамарч байна. Иймд ЦХХХЯ нь хуульд заасан төрөлжсөн бүртгэл хөтөлөх үйл ажиллагааг цахимжуулах чиглэлд нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай байна.

**1.39** Мэдээллийн технологийн засаглалын үндэсний “Мэдээллийн технологи MNS ISO/IEC 38506:2023”, “Өгөгдлийн засаглал MNS ISO/IEC 38505-1:2023”, “Өгөгдлийн удирдлагын MNS ISO/TR 38505-2:2023” стандартуудыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдөж байна. Эдгээр стандартуудыг салбараас үл хамааран бүх төрлийн байгууллага, түүний дотор хувийн хэвшил, нийтийн болон төрийн байгууллага, ашгийн бус зэрэг байгууллагын

<sup>7</sup> Улсын бүртгэлийн тухай хуулийн 5.2 дахь заалт: Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ. Улсын бүртгэлийн хуулийн 5.3 дахь заалт: Энэ хуулийн 5.2-т зааснаас бусад хуульд заасан бүртгэл нь төрөлжсөн бүртгэлд хамаарах бөгөөд төрөлжсөн бүртгэлийн жагсаалтыг Засгийн газар батална.

түвшинд ашиглаж болно. Одоогоор үндэсний өгөгдлийн засаглал, удирдлагад удирдамж болохоор энэ стандартад нийцүүлэн боловсруулсан бодлого, стратеги хараахан боловсруулаагүй байна.

Стандартын нэр	Хэрэглээ
Мэдээллийн технологи MNS ISO/IEC 38506:2023 стандарт	Энэ стандарт нь мэдээллийн технологийн агууламжтай хөрөнгө оруулалтын засаглалын талаар баримтлах удирдамжийг тогтооно.
Өгөгдлийн засаглал MNS ISO/IEC 38505-1:2023 стандарт	Энэ стандарт нь мэдээллийн системийн тусламжтай үүсгэж, цуглуулж, хадгалж, эсвэл хянаж байгаа өгөгдлийн одоогийн болон ирээдүйн ашиглалтын засаглалыг зохицуулах ба өгөгдлийн талаарх удирдлагын үйл ажиллагаа болон шийдвэрт нөлөөлнө.
Өгөгдлийн удирдлагын MNS ISO/TR 38505-2:2023 стандарт	Энэ стандарт нь ISO/IEC 38505-1 стандартад заасан өгөгдлийн удирдлагын зохицуулалтыг хэрэгжүүлэхэд байгууллагын эрх барих субъект болон гүйцэтгэх удирдлагын баримтлах удирдамжийг тодорхойлно. Энэ стандарт нь байгууллагын эрх барих субъект ба гүйцэтгэх түвшний удирдлагын баг хооронд харилцан мэдээлэл солилцох, байгууллагын хэмжээнд өгөгдөл ашиглах үйл ажиллагааг байгууллагын стратегийн чиглэлтэй нийцүүлэх зохицуулалтыг тодорхойлно. Өгөгдөлд тулгуурласан үйл ажиллагаа явуулах, стратеги, бодлого боловсруулах, үнэлгээ хийх, чиглэл өгөхөд шаардлагатай мэдээллийг тодорхойлох; Өгөгдөл, түүний ашиглалтын гүйцэтгэлд хяналт тавихад ашиглах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

### “МХХТ-ийн салбарын бодлогыг хэмжих үйл явц бүрэн төлөвшиж чадаагүй байна”

**1.40** Монгол Улсын МХХТ-ын салбарын бодлогын хэрэгжилтийг 8 багц 92 үзүүлэлтээр хэмжихээр аргачлалыг<sup>8</sup> баталсан хэдий ч одоогоор 33 үзүүлэлтийг бэлэн тооцож, 17 үзүүлэлтийг тодорхой давтамжтайгаар тооцохгүй, 42 үзүүлэлтийг огт тооцож гаргаагүй байгаа нь салбарын бодлогын гүйцэтгэлийг хянаж, үнэлэх, удирдах үйл ажиллагааг хязгаарлаж доголдоход хүргэж байна.

<sup>8</sup> ҮСХ-ны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/225 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.

**Хүснэгт 1.2** МХХТ-ийн салбарын тооцохгүй байгаа үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо	Хариуцах байгууллага
Өрх, хүн амын хүртээмж, ашиглалтын үзүүлэлт	17	ҮСХ, ЦХХХЯ
Нийт импортод МХХТ-ийн бүтээгдэхүүний импорт, экспортын эзлэх хувь	2	ҮСХ, ГЕГ
ААНБ-ын хэрэглээний үзүүлэлт	5	ЦХХХЯ, ХХЗХ
Их өгөгдлийн үзүүлэлт	9	ЦХХХЯ, ХХЗХ
Боловсролын салбарын үзүүлэлт	9	БШУЯ
Цахим засаглалын үзүүлэлт	17	ЦХХХЯ, ЦЕГ, АТҮТ
Нийт	59	-


**1.41** ЦХХХЯ-ны Судалгаа, шинжилгээний хэлтэс нь “салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг хөгжүүлэх бодлого”, “статистик мэдээ гаргаж, мэдээллийн сан байгуулах” үндсэн чиг үүрэгтэй<sup>9</sup>. ЦХХХЯ-ны ТНБД-ын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр баталсан “Судалгаа, шинжилгээний хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд одоо тооцож чадахгүй байгаа 42 үзүүлэлтийг гаргахтай холбогдсон арга хэмжээг тусгаагүй байна.

**1.42** Иймд ЦХХХЯ нь салбарын бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэхэд шаардлагатай эдгээр үзүүлэлтийг тооцож гаргахад манлайлал үзүүлэх, оролцогч талуудыг чиглүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, зохицуулалт хийх зэрэг тодорхой ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.


**1.43** Түүнчлэн, МХХТ-ийн салбарын бодлого боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг гаргахад чиглэсэн бодлогын судалгаа, шинжилгээний

ажлын стратеги, хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын нэгдсэн бүртгэл, мэдээлэл байхгүй байна.

**1.44** Олон улсын түвшинд Засгийн газруудын цахим төлөвшлийг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр 2 жилд 1 удаа хэмжиж байна. Манай улсын цахим засаглалын хөгжлийн түвшин 2022 онд дэлхийн 193 оноос 74 дүгээрт эрэмбэлэгдэн 2020 оноос 18 байраар урагшилж, цахим засаглалын хөгжлийн түвшин өндөр орнуудын бүлэгт хамаарч байна<sup>10</sup>. НҮБ-ын Цахим засаглалын 2022 оны судалгааны үр дүнгээр хүмүүн капиталын индекс 0.8391, харилцаа холбооны дэд бүтцийн индекс 0.6973, цахим үйлчилгээний индекс 0.6263 болсноор цахим засаглалын хөгжлийн индекс 0.721-д хүрчээ.



**1.45** Цахим засаглалын хөгжлийн индекс 2016 оноос хойш тогтвортой өсөхөд цахим үйлчилгээний индексийн өөрчлөлт голлон нөлөөлсөн байна.





<sup>9</sup> Засгийн газрын 2022 оны 13 дугаар тогтоолын хавсралт: Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр.

<sup>10</sup> UN, E-Government Survey 2022

## Төрийн албанд ажиллаж буй МХХТ-ийн салбарын хүний нөөцийн бодлогын хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна

**1.46** Төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөцийн бодлого, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, санхүүжилт, үнэлгээний шалгуур тодорхой бус байгаагаас төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа бүрэн хангагдахгүй байна. Улмаар төрийн албанд ажиллаж буй МХХТ-ийн чиглэлийн хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдахгүйд хүрч байна.

**1.47** Төрийн жинхэнэ албанд<sup>11</sup> хамаарах байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг ТАТХ-ийн 55.3 дахь зүйлээр зохицуулагддаг бол төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагчийн нийгмийн баталгаа нь тухайн салбарын хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулагдаж байна.




**1.48** Одоогоор ерөнхий чиг үүргийн 4, чиглэлийн 12, нийт 16 яам үйл ажиллагаа явуулж байна. Үүний 14 нь албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тусгай хөтөлбөртэй бол Батлан хамгаалах яам “албан хаагчдыг

<sup>11</sup> ТАТХ-ийн 6.2 дахь заалт 5: Энэ хуулийн 6.1.2 (төрийн захиргааны алба), 6.1.3 (төрийн тусгай алба)-т заасан албыг төрийн жинхэнэ алба гэнэ.

мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө”-г, Соёлын яам “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө”-г 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар тус тус баталжээ. Эдгээрээс 13 яамны хөтөлбөр, төлөвлөгөө нь шинэчлэн найруулсан ТАТХ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс буюу 2020 оноос хойш, 3 нь 2020 оноос өмнө батлагдсан байна.

/Хавсралт 1.2-ыг үзнэ үү/



**1.49** Тусгайлсан хөтөлбөртэй 14 яамны 3 нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй, 11 нь төлөвлөгөөгүй ба хөтөлбөрийг баталсан шийдвэрт “хөтөлбөрийг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх”, “жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах” зэргээр хэрэгжилтийг хангахаар нэр төдий томьёолсон байна.

**1.50** Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй 3 яамны 1 нь үр дүнг хянах шалгуур үзүүлэлттэй, 2 нь шалгуур үзүүлэлт байхгүй байна. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй 11 яамны 2 нь үр дүнг хянах шалгуур үзүүлэлттэй байхад, 9 нь шалгуур үзүүлэлтгүй байна.

**Хүснэгт 1.3** Яамдын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт (тоо)

Үзүүлэлт	Бүгд	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй			Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй		
		Бүгд	ШҮ-тэй	ШҮ-гүй	Бүгд	ШҮ-тэй	ШҮ-гүй
Тусгайлсан хөтөлбөртэй	14	3	1	2	11	2	9
Тусгайлсан хөтөлбөргүй/ төлөвлөгөөтэй	2	2	2	-	-	-	-
Нийт	16	5	3	2	11	2	9

Тайлбар: ШҮ-шалгуур үзүүлэлт

**1.51** Тусгайлсан хөтөлбөртэй 14 яамны 5 нь хөтөлбөрөө 5 жилд, 4 нь 4 жилд, 3 нь 3 жилд, 1 нь 10 жилд хэрэгжүүлэхээр баталсан бол үлдсэн 1 нь хэрэгжүүлэх хугацаагаа тодорхойлоогүй байгаа нь гүйцэтгэл хангагдахгүй, үнэлж дүгнэх боломжгүйд хүргэхээр байна.

**1.52** ТАЗ нь “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах” чиг үүрэгтэй<sup>12</sup>. Энэ бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн захиргаа, төрийн тусгай албаны байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг бүрэн хийгээгүй байна.

**“Төрийн албанд ажиллах МХХТ-ийн салбарын хүний нөөцийн ажиллах нөхцөлийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх арга зам оновчгүй байна”**

**1.53** Төрийн өгөгдлийн сангууд, түүний бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангах, улмаар төрийн байгууллагуудад мэдээллийн шинэ технологийн (их өгөгдлийн технологи, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан г.м) мэдлэг, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх сорилт тулгарч байна.

**1.54** МУЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тогтоолоор “Төрийн албанд ажиллах мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”, “Мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан ажиллуулах төрийн байгууллагын жагсаалт, мэдээллийн технологийн чиглэлээр ажиллах ажилтны орон тооны дээд хязгаар”-ыг тус тус баталжээ.

<sup>12</sup> ТАТХ-ийн 66.1.8 дахь заалт

**1.55** Уг тогтоолд мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, нөхцөл, шалгуур, төрийн байгууллагуудын одоо байгаа орон тооны хүрээнд зохицуулалт хийх эсэхийг тодорхой заагаагүй байна. Түүнчлэн, энэ тогтоолд “мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар”-тай хүнийг сонгон шалгаруулах үйл явцыг орхигдуулсан байна. МУЗГ-ын энэхүү тогтоол нь төрийн албанд ажиллах мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг оновчтой бүрдүүлэх, тогтоон барих, тогтвор суурьшилтай ажиллахад тодорхой ахиц гарахгүй байх эрсдэлтэй байна.

**1.56** Уг тогтоолд 73 байгууллагын 161 албан тушаалд нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий хүнийг ажиллуулахаар баталсан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор ТАЗ-өөс холбогдох мэдээллийг авсан болно. /Хавсралт 1.3-ыг үзнэ үү/

**1.57** Судалгааны үр дүнгээр тогтоол хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд 7 байгууллага 14 ажилтныг авч ажиллуулжээ. Эдгээр 14 ажилтны 12 нь гүйцэтгэх албан тушаалд 4.0 сая төгрөгийн, 2 нь туслах албан тушаалд 2.9 сая төгрөгийн цалинтай ажиллаж байна.

**1.58** Эдгээрээс 10 ажилтан “компьютер”, “мэдээллийн систем”-ийн бакалаврын зэрэг эзэмшсэн, харин Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 1 ажилтан нь газрын инженерийн мэргэжилтэй байна. Оюуны өмчийн газар, УБЕГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн тус бүр нэг ажилтны мэргэжлийн нэрийг хүний нөөцийн мэдээллийн систем, програмдаа бүртгэж оруулаагүй, түүнд нь ТАЗ хяналт хийгээгүй байна.

**1.59** Магистрын боловсролын зэрэгтэй 6 ажилтан байгаагийн 1 нь мэдээллийн системийн мэргэжилтэй байна. Харин үлдсэн 5 ажилтны магистрын боловсролын зэргийн мэргэжил нь “бизнесийн удирдлага” (Оюуны өмчийн газар, УБЕГ), “боловсрол судлал” (Оюуны өмчийн газар), “Мал аж ахуйн өргөн мэргэжил”-ийн\* (ГЗБГЗЗГ) гэсэн чиглэлийнх байна. Хөдөлмөр эрхлэлтийн түүхийг харвал 10 нь одоогийн байгууллагадаа ажиллаж байсан, 3 нь дээрх тогтоолын дагуу төрийн албанд шинээр томилогдсон ажилтан байна.

\* ТАЗ-ийн ХНУМТ системд оруулснаар



**Хүснэгт 1.4** МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт (тоо, дүн)

№	Байгууллагын нэр, албан тушаал	Хүний тоо	Ангилал, зэрэглэл		Нэг хүнд ногдох цалин (төгрөг)	Нэмэгдэл (төгрөг)		Цалин хөлс, нэмэгдэл (төгрөг)
			ТҮМТ-1-1	ТҮМТ-2-1		Хоол	Унаа	
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	2	2					
	Орон зайн веб үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженер	1	1		4,001,400	13,000	2,000	4,016,400
	Салбарын программ хангамж хөгжүүлэлт хариуцсан инженер	1	1		4,001,400	13,000	2,000	4,016,400
2	Оюуны өмчийн газар	2	2					
	Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн	1	1		4,001,400	10,000	2,000	4,013,400
	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	1	1		4,001,400	10,000	2,000	4,013,400
3	Төрийн албаны зөвлөл	2	2					
	Мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн	2	2		4,001,400	20,000	3,000	4,024,400
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар	4	3	1				
	Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн программист	3	3		4,001,400			4,001,400
	Мэдээллийн сүлжээ, техник ашиглалтын хэлтсийн сүлжээний инженер	1		1	2,948,400			2,948,400
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	1	1					
	Нийгмийн халамжийн программ хангамж хариуцсан программист	1	1		4,001,400	19,000	1,000	4,021,400
6	Цахим хөгжил харилцаа холбооны яам	2	2					
	Мэдээлэл технологийн ажилтан	2	2		4,001,400	14,000	1,000	4,016,400
7	Шүүхийн сахилгын хороо	1		1				
	Эрхлэгч, сүлжээний	1		1	2,948,400	17,000	3,000	2,968,400
	Нийт	14	12	2	-	-	-	-

Эх сурвалж: ТАЗ-ийн ХНУМТ систем, Сангийн яамны мэдээлэл

**“МХХТ-ийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг дэмжсэн арга хэмжээ бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олоогүй байна”**

**1.60** Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг сургах, бүрдүүлэх, бүртгэлийг сайжруулах зэрэг чиглэлээр нийт 60 арга хэмжээ төлөвлөсний 41 нь хүний нөөцийг чадавхжуулах, 6 нь хүний нөөцийн бодлого боловсруулахтай холбоотой арга хэмжээ байна.

**1.61** МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна”, Сангийн яамны стратеги төлөвлөгөөнд “Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системд тулгуурлан салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог илрүүлэх замаар орон

тоог дахин хуваарилах, бууруулах зэргээр цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгож, зардлын өсөлтийг тогтворжуулна” гэж тусгаснаас өөрөөр төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг дэмжсэн арга хэмжээг төлөвлөөгүй байна.

**Хүснэгт 1.5** Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогод тусгасан МХХТ-ийн салбарын хүний нөөцтэй холбогдох арга хэмжээ

№	Арга хэмжээний агуулга	Арга хэмжээний тоо
1	Хууль, эрх зүйн орчныг сайжруулах	1
2	Хүний нөөцийг бүрдүүлэх	3
3	Хүний нөөцийг чадавхжуулах	41
4	Хүний нөөцийн бодлого боловсруулах	6
5	Хүний нөөцийн бүртгэлийг сайжруулах	4
6	Хүний нөөцийн удирдлага	1
7	Цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах	2
8	Бусад	2
	Нийт	60



### “МХХТ-ийн хүний нөөцийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн тусгайлсан бодлогогүй байна”

**1.62** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал” хамаарч байна.

**1.63** МХХТ-ийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж, баримт бичгийг боловсруулах арга хэмжээг ЦХХХЯ-ны стратеги төлөвлөгөө, ЦХХХЯ-ны 2022, 2023 оны төлөвлөгөөнд тус тус тусган хэрэгжүүлж байна.

**1.64** МХХТ-ийн салбарын хувьд дараах хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийг мөрдөж байна. Үүнд:

- ХХМТГ-ын даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хүний нөөцийн бодлого”;
- ЦХХХЯ-ны ТНБД-ын 2022 оны 12 дугаар сарын 06-ны А/129 дугаар тушаалаар баталсан “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”;
- ЦХХХЯ-ны харьяа “И-Монгол академи” УТУГ-ын Сургалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө.



**1.65** ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн “Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 5.1.5-д “Мэдээллийн технологи, инновацын судалгаа, шинжилгээний чиглэлийн хүний нөөцийг хөгжүүлэх, нарийн мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж оруулсан байна.

**1.66** Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 5.1.5 дахь арга хэмжээ нь зөвхөн мэдээллийн технологийн хүний нөөцийн хөгжлийг хангахад чиглэж байгаа нь МХХТ-ийн салбарын хүний нөөцийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгцээг бүрэн хамарч чадахгүй байна.

### Хүснэгт 1.6 ЦХХХЯ-ны МХХТ-ийн салбарт баримтлах хүний нөөцийн бодлогын хэрэгжилт

№	Баримт бичгийн нэр	Төлөвлөсөн арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Явц, үр дүн
1	ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөө (2022-2024 он)	1.1.14: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бодлогын чиглэл боловсруулах	Баримтлах бодлогын чиглэлийн тоо	Хэрэгжилт 100% <sup>13</sup>
2	ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	4.1: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын чиглэлийн төсөл боловсруулах	Баримтлах бодлогын чиглэлийн тоо	Хэрэгжилт 100% <sup>14</sup>
3	ЦХХХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	15: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг батлах	Батлуулсан баримт бичгийн тоо	МХХТ-ын салбарын хүний нөөцийн нөхцөл байдлын судалгааг хийж, бэлтгэл ажлыг хангаж байгаа <sup>15</sup> .

Эх сурвалж: ЦХХХ-ны сайдын эрхлэх хүрээний стратегийн 2022 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайлан, ЦХХХЯ-ны 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайлан

### “Цахим хөгжил, харилцаа холбооны бодлого, төлөвлөлт, удирдлагын уялдааг хангасан салбар хоорондын зохицуулалт шаардлагатай байна”

**1.67** Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын зорилтод амжилттай хүрэхэд асуудал хариуцсан болон үүрэг хүлээж буй төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийн хуваарилалт нь давхардал, хийдэлгүй байх нь чухал ач холбогдолтой. Салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги, салбар яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийн хуваарилалтаас харахад нийт 16 яамны стратеги төлөвлөгөөний зорилтын 33.1 хувь, арга хэмжээний 23.6 хувь нь цахим хөгжлийг дэмжсэн зорилт, арга хэмжээ байна.

**1.68** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3-т Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын чиг үүрэгт төрийн албаны хүний нөөцийн асуудал, төрийн захиргааны төв байгууллагын шуурхай удирдлага, салбар хоорондын бодлого, зохицуулалтын уялдааг хангаж ажиллах тухай заасан. ЗГХЭГ нь салбар бүрийн бодлого, зохицуулалтын уялдааг хангах, үүнээс онцгойлон цахим хөгжил, харилцаа холбооны

<sup>13</sup> Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 5.1.5-д “Мэдээллийн технологи, инновацын судалгаа, шинжилгээний чиглэлийн хүний нөөцийг хөгжүүлэх, нарийн мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ” оруулж оруулж, батлуулсан учир хэрэгжилт 100% гэж ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайланд дурдсан.

<sup>14</sup> Цахим үндэстэн баримтлах чиглэлийн 5.1.5-д “Мэдээллийн технологи, инновацын судалгаа, шинжилгээний чиглэлийн хүний нөөцийг хөгжүүлэх, нарийн мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ” оруулж оруулж, батлуулсан учир хэрэгжилт 100% гэж ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайланд дурдсан.

<sup>15</sup> ЦХХХЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайлан

бодлого, төлөвлөлт, удирдлага, зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлэн ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

**1.69** МУЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар “ЦХХХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг баталсан. Энэ тогтоолын дагуу ЦХХХЯ нь үйл ажиллагааны тэргүүлэх 8 чиглэл, стратегийн 8 зорилтыг хэрэгжүүлж, 6 газар (7 хэлтэс)-ын зохион байгуулалттай ажиллаж байна.

**1.70** ЦХХХЯ-ны тэргүүлэх чиглэлийн нэг нь “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах” юм. Уг тэргүүлэх чиглэлийг үйл ажиллагааны стратегийн зорилтод буулгахдаа “... зохицуулах” гэсэн үгээр томьёолж, зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэгт дараах байдалаар томьёолсон. Үүнд:

- Бодлого, төлөвлөлтийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэгт “Харилцаа холбоо, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудан, сансрын технологи, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл, тоон контент, үндэсний кибер аюулгүй байдал, мэдээлэл, харилцаа холбооны хүний нөөц, бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, хөгжлийн хөтөлбөрийн хувилбар боловсруулах, радио давтамжийн нөөцийг үр ашигтай төлөвлөх, салбарын стандартчиллыг хөгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах, олон улсын байгууллагад Монгол Улсыг төлөөлөх үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ”;
- Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэгт “Нийгэм, эдийн засгийн хөгжлийг мэдээллийн технологиор

дэмжих, төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа, холбоог төлөвлөж, зохион байгуулах, цахим засаглалын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мэдээллийн технологи, программ хангамжийн хөгжил, төрийн үйлчилгээнд инновац нэвтрүүлж нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, тоон хуваагдлыг бууруулах, салбарын болон салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн бүртгэл хөтөлх чиг үүргийг хэрэгжүүлнэ”.

**1.71** ЦХХХЯ-ны зөвхөн Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах зохион байгуулалтын бүтцэд 2 албан хаагч салбар болон салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээн ажиллаж байна. Үүнээс гадна ЦХХХЯ-ны бүтцэд Цахим засаглалын хэлтэс, И-Монгол академи УТҮГ-т салбар дундын зохицуулалтын газар ажиллаж байна.

**1.72** Салбар бүрийн хөгжлийн бодлого нь МХХТ-ийн салбартай холбогдох зорилт, арга хэмжээгээр дэмжигдэх энэ цаг үед салбар дундын уялдаа, нэгдмэл байдлыг хангах асуудал чухал ач холбогдолтой байна.

**1.73** ЦХХХЯ-ны зохион байгуулалтын бүтцийн орон тооны хязгаар 90 албан хаагч боловч 2023 оны 09 дүгээр сарын 25-ны байдлаар 76 албан хаагч ажиллаж 14 албан хаагчийн дутагдалтай ажиллаж байна.

**1.74** Хүний нөөцийн дутагдалтай байдал нь одоо ажиллаж байгаа ажилтнуудад чиг үүргийн давхардал үүсгэж, ачаалал нэмэгдэх, улмаар ажлын гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагаа доголдох эрсдэлийг бий болгож байна.

**“ТАЗ-ийн мэдээлэл бодит цагийн хэрэгцээг хангахгүй байна”**

**1.75** ТАЗ-ийн тархаасан 2022 оны статистик мэдээллээр 225.2 мянган төрийн албан хаагчид ажиллаж байна. Эдгээрийн 152.3 (67.6%) мянга нь төрийн үйлчилгээний албанд, 47.2 (20.9%) мянга нь төрийн тусгай албанд, 22.0 (9.8%) мянга нь төрийн захиргааны албанд, 3.7 (1.7%) мянга нь төрийн улс төрийн албанд ажиллаж байна.

**1.76** Төрийн албанд МХХТ-ийн чиглэлээр 625 хүн ажиллаж байгаагийн 355 (56.8%) нь төрийн


үйлчилгээний, 201 (32.2%) нь төрийн захиргааны, 69 (11.0%) нь төрийн тусгай албанд тус тус ажиллаж байна.

**Хүснэгт 1.7** Төрийн албанд ажиллаж байгаа МХХТ-ийн чиглэлийн албан хаагчдын тоо, ангилал

№	Төрийн албаны ангилал	Гүйцэтгэх	Туслах	Удирдах	Нийт
1	Төрийн захиргааны алба	171	3	27	201
2	Төрийн тусгай алба	58	6	5	69
3	Төрийн үйлчилгээний алба	331	12	12	355
Нийт		560	21	44	625

Эх сурвалж: ТАЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын мэдээлэл

**1.77** Төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа мэдээллийн технологийн албан хаагчдын 46 нь 1 хүртэлх, 86 нь 1-3 жил ажиллаж байна.



**1.78** ТАЗ-ийн ХНУМТ системд YAMAT-г<sup>17</sup> мөрдөж байгаа боловч үнэн бодит байдалд хяналт хийх ажил сул байна.

**1.79** ТАЗ-өөс авсан 2023 оны 10 дугаар сарын байдлаарх мэдээллээс үзэхэд төрийн албанд МХХТ-ийн чиглэлээр ажиллаж байгаа 625 ажилтны 191 (30.6%) ажилтны боловсролын зэргийн мэдээлэл, 317 (50.7%) ажилтны бакалаврын мэргэжлийн нэр тус тус нөхөгдөөгүй байсан нь зарим төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүд эдгээр өгөгдлийг дутуу оруулсан буюу төрийн байгууллагуудын оруулсан (нөхсөн) өгөгдлийн хүрээнд ТАЗ-ийн “Хүний нөөцийн мэдээллийн тогтолцооны систем”-ийн мэдээлэл гарч байна.

<sup>16</sup> ТАЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын мэдээлэл

<sup>17</sup> Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Үндэсний Ажил Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт 08”, ХНХ-ийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/210 дугаар тушаал

**1.80** ТАЗ-ийн “Хүний нөөцийн мэдээллийн тогтолцооны систем”-д YAMAT-ын кодын үнэн бодит байдал хангагдахгүй байгаа нь орчин үеийн технологийн хувьслын агуулга, процесст дүйцсэн нэр, агуулгаар ажил, мэргэжлийг ангилах, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, бусад төрийн өгөгдлийн сангуудтай уялдуулж, төрийн албан хаагчдын нөхцөл байдлын талаарх бодит цагийн, өргөн хүрээний судалгаа, шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байна.

**1.81** ЦХХХ-ны сайд, ҮСХ-ны даргын хамтарсан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/193, А/79 дүгээр тушаалын хавсралтаар “Статистикийн үйл ажиллагаанд хамаарах нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын тайлбар”-ыг баталсан.

**1.82** Тушаалд зааснаар шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь ҮСХ, ЦХХХЯ-ны үүрэг боловч ТАЗ-ийн “Хүний нөөцийн мэдээллийн тогтолцооны систем” дэх өгөгдөл буюу төрийн албан хаагчийн статистикийн мэдээллийн ангилал, кодын үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахгүй байна.

### **“Бодлогын зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, үр чадварыг иж бүрэн үнэлээгүй байна”**

**1.83** Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох төрийн албан хаагчдын цахим үр чадварыг дээшлүүлэх бодлого, стратегийг боловсруулахад төрийн албан хаагчдын мэдлэг, үр чадварыг иж бүрэн үнэлээгүйгээс цахим шилжилтийн үеийн суурь нөхцөлийг бэхжүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хугацаа алдах эрсдэлтэй байна.

**1.84** Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудад төрийн албан хаагчдын мэдээллийн технологи, инновац ашиглах мэдлэг, үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх талаар олон арга хэмжээг төлөвлөжээ.

**1.85** ЦХХХЯ-наас хүн амын цахим үр чадварыг төрөл бүрийн эх үүсвэрээр судалсан хэдий ч төрийн албан хаагчдын МХХТ-ийн талаарх мэдлэг, үр чадварын түвшнийг бүрэн тодорхойлж чадаагүй байна.

**1.86** Төрийн албан хаагчийн цахим үр чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах хүрээнд 5 аймгийн 598 төрийн албан хаагчдыг хамруулсан судалгааны үр дүнгээс онцолбол судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын шинэ техник

технологийн мэдлэгийн түвшин 11.3 хувь, цахим төхөөрөмжийн мэдлэгийн түвшин 20.2 хувь, интернэт орчинд ажиллах үр чадварын түвшин 20.3 хувь, мэдээллийн аюулгүй байдлын хэрэглээний түвшин 20.3 хувь, хэрэглээний программтай ажиллах чадварын түвшин 23.1 хувьтай байна. Мөн оролцогчдын 80 хувь нь энэ чиглэлийн сургалтад хамрагдаж байгаагүй гэж хариулжээ.

**1.87** Иргэдийн цахим үр чадварын судалгаа\*-ны үр дүнгээр төрийн захиргааны байгууллагад ажиллагсдын цахим үр чадварын түвшин 83.7 хувь, төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагсдынх 81.6 хувьтай байна. Харин төрийн тусгай албаны байгууллагад ажиллагсдын цахим үр чадвар түвшнийг үнэлж тодорхойлоогүй байна.

### **“Бүх нийтийн цахим үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж, хянаж, үнэлээгүй байна”**

**1.88** БШУ-ын сайд, ЦХХХ-ны сайд, ХНХ-ийн сайд, Соёлын сайдын хамтарсан 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/260, А/391, А146, А/260 дугаар тушаалаар “Бүх нийтийн цахим үр чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)”-г баталсан.

**1.89** Гэсэн хэдий ч уг шийдвэрт төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгтгэн тайлагнах байгууллага, албан тушаалтныг тодорхой заагаагүй нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зохион байгуулалт, ялангуяа тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байдал хангагдахгүйд хүргэсэн байна.

**1.90** Уг төлөвлөгөөний 3 дугаар зорилтын хүрээнд:

- **Бэлтгэл шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр:** “Төрийн албан хаагчийн мэдээллийн технологийг ашиглах чадавхыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах”, “Мэдээллийн технологи хариуцсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах”,

- **Анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр:** “Төрийн зарим үйлчилгээний албан хаагчдыг иргэдэд төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээс үйлчилгээ авах чадвартай болгоход чиглэл өгөх, зүгшрүүлэх сургагч багш нар болгон бэлтгэсэн байна” гэж төлөвлөсөн байна.

Гэсэн хэдий ч уг төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайлан гараагүй байна.

\* БШУЯ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, 2023 он

## **“Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөл” ажиллахгүй байна**

**1.91** НМИТБТХ-ийн 8 дугаар зүйл<sup>18</sup>-д мэдээлэл хариуцагч хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг нээлттэй байлгах тухай заасан ба байнга ил тод байлгах 68 төрлийн мэдээллийг тухайлан заасан байна.

**1.92** “Нийтийн мэдээлэл хариуцагч”-ийг тус хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон бөгөөд үүнд дараах байгууллагууд хамарч байна.

- Төрийн байгууллага;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд;
- Хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд;
- Олон нийтийн радио, телевиз;
- Улс төрийн нам.

**1.93** НМИТБТХ-ийн 8.16-д энэ хуулийн 8.8-д заасан цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмыг Засгийн газар батална гэж заасан бөгөөд МУЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор тус журмыг баталсан.

**1.94** Мөн НМИТБТХ-ийн 8.17-д Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллахаар, 8.18-д уг зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тус тус заасан.

**1.95** Дээрх хуулийн заалтын дагуу ХЗДХ-ийн сайд, ЦХХХ-ны сайдын хамтарсан 2022 оны 09 дүгээр

<sup>18</sup> НМИТБТХ-ийн 8.1. “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана”

сарын 19-ний өдрийн А/268, А/48 тушаалаар “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг баталсан. Тус журмын 2.2-т зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө, үнэлгээ хийх хуваарийг хагас, бүтэн жилээр боловсруулж, тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ХЗДХ болон ЦХХХ-ны сайдад танилцуулах бөгөөд төлөвлөгөөг хамтран батлахаар заасан байна.

**1.96** Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн 2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөө, түүний хавсралтаар уг зөвлөлийн үнэлгээ хийх хуваарийг ХЗДХ болон ЦХХХ-ны сайд хамтран баталсан байна. Гэсэн хэдий ч энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан гараагүй, 2023 оны сүүлийн хагас жилийн төлөвлөгөөг батлаагүй байна.

**1.97** Мөн “нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээлэл болон батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу үнэлэх, хэрэгжилт хангаагүй тохиолдолд авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргах”, “мэдээлэл хариуцагчдыг нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг үндэслэн эрэмбэлсэн үнэлгээ, авах арга хэмжээний санал, зөвлөмжийг агуулсан улсын хэмжээний нэгдсэн тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж, Засгийн газарт танилцуулах”, “нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн үнэлгээ, тайланг олон нийтэд тухай бүр мэдээлэх” зэрэг журамд заасан үйл ажиллагаа хэрэгжээгүй байна.


**1.98** МУЗГ-аас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн ажил хариуцуулах 48 дугаар захирамжаар “Шил ажиллагаа”-г ЦХХХ-ны сайдад хариуцуулсан байна.

**1.99** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын хуулиар ил тод байлгах үүрэгтэй 68 төрлийн мэдээллийг өргөтгөн, 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, долоо хоног тутамд shilen.gov.mn платформоор дамжуулан “Шилэн индекс”-ээр зарлаж байгаа нь сайшаалтай хэдий ч тухайн шалгуур үзүүлэлтийг үнэлэх журмын зохицуулалтыг нарийвчлан, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

**1.100** Харин шил ажиллагаа нь шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчлэх асуудлыг зохицуулж буй бөгөөд үүнийг Зөвлөлийн зохицуулах асуудлаас ялгаатай авч үзэх шаардлагатай байна. Тодруулбал,

- Зөвлөл нь нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар мэдээлэл хариуцагчийн цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгслээр 68 төрлийн мэдээллийг байнга ил тод байлгах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хүлээдэг. “Шил ажиллагаа” нь шаардлагатай мэдээллүүдийг нэгдсэн системээр хүргэж байгаа үйл ажиллагаа боловч Зөвлөлийн үйл ажиллагааг Шил ажиллагаатай холбон тайлбарлаж байгаа нь учир дутагдалтай байх бөгөөд цаашлаад нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хариуцах эзэн тодорхойгүй болох эрсдэлийг бий болгож байна.
- Төрийн байгууллагаас бусад НМИТБТХ-д мэдээлэл хариуцагчаар заасан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, олон нийтийн радио, телевиз, улс төрийн намуудын ил тод байдлыг хангах, хяналт тавих асуудал орхигдсон байдалтай байна.

**1.101** НМИТБТХ-ийн 8.19-д “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг батлахаар заасан бөгөөд уг журмыг МУЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолоор баталсан журмын 2 дугаар зүйлд “Нээлттэй мэдээллийн ил тод байдал”-ыг үнэлэх дараах 4 шалгуур үзүүлэлт болон үнэлгээ хийх аргачлалыг тусгасан байна.




**1.102** ЦХХХЯ-наас төрийн байгууллагуудын мэдээлэл зохих 68 мэдээллийн ил тод байдлыг үнэлсэн үнэлгээг ирүүлсэн боловч журамд заасан аргачлалын дагуу үнэлгээг хийгээгүй байна.

**“Цахим засаглал, цахим шилжилтийн хүрээнд анхаарвал зохих асуудал”**

**1.103** Цахим оролцоог “цахим мэдээлэл”, “цахим зөвлөлдөх уулзалт”, “цахим шийдвэр гаргах” хэмжигдэхүүнээр хэмжиж байна<sup>19</sup>.

<sup>19</sup> UN, E-Government survey 2022 (“Цахим мэдээлэл” нь иргэдийн хүссэн (хүсэлт гаргаагүй) мэдээлэл болон төрийн мэдээллийг хүртээмжтэй болгох замаар иргэдийн оролцоог идэвхжүүлэх, “цахим зөвлөлдөх уулзалт” нь Төрийн бодлого, үйлчилгээнд иргэдийн санал, бодлыг сонсох замаар тэднийг татан оролцуулахыг, “цахим шийдвэр гаргах” нь бодлогын хувилбаруудыг хамтран боловсруулах замаар иргэдийг чадавхжуулах, дэмжих үйл ажиллагааг хамааруулна).



**1.104** ЦХХХЯ-наас цахим шилжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд тус салбарын сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг баталж, аймаг бүрд хүргүүлэн ажиллаж байна.

**1.105** Аймгуудын хувьд цахим шилжилтийн бэлэн байдлын үнэлгээгээр цахим шилжилтийг эрчимжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэсэн бөгөөд үнэлгээний хамрах хүрээнд удирдлагын манлайлал, дэд бүтэц, хандлага, ур чадвар, инновац гэсэн үндсэн 5 бүрэлдэхүүн хэсэг багтаж байна.

**1.106** Цаашид цахим шилжилтийн төлөвлөгөөг аймгийн нөхцөл байдалд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх боломж байгаа ч үүсэж болох хамгийн том эрсдэл нь төрийн байгууллагуудын албан хаагчдын болон иргэдийн цахим ур чадварын түвшин сул, ур чадварын түвшнийг бодитой хэмждэггүй, сайжруулах талаар арга хэмжээг тогтмол зохион байгуулах чадамж сул, удирдлагын манлайлал хангалтгүй байгаа зэрэг нь үндсэн шалтгаан болж байна.

**1.107** Иймд улсын хэмжээнд хэрэгжүүлж буй “Цахим аймаг” зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний үр нөлөөг үнэлж дүгнэх шаардлагатай байна.

**1.108** Хөгжиж буй орнууд дахь цахим засаглалын бодлогын хэрэгжилтэд гарч буй нийтлэг алдаа оноог авч үзэхэд манай улсын хувьд ч мөн адил цахим хөгжлийг бий болгоход дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байна. Жишээлбэл,

- Олон нийтийн удирдлага систем хооронд зохилдлогоо байхгүй байх;
- Төлөвлөгөө ба стратеги нь хангалтгүй байх;
- Хүний нөөц хангалтгүй, боловсон хүчний ур чадвар төгөлдөршөөгүй;
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтгүй байх;
- Систем нийлүүлэгч буюу мэдээллийн технологийн программ хомсдолтой;

- Бэлтгэл болон туршилтын ажил болох нэвтрүүлэлт, зүгшрүүлэлтийг бүрэн хийлгүйгээр гүйцэтгэх.

#### Сайн туршлага

##### Ухаалаг Дархан-Уул аймгийн дижитал шийдэл бүхий бүтээгдэхүүн, тэдгээрийн уялдаа холбоог хангах эко систем:

- Зүүн Европын улсуудын орон нутгийн байгууллагуудын холбооны хөгжлийн ухаалаг хотын хөгжлийн зарчим, олон улсын сайн туршлагыг нутагшуулах зорилготой хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцон санхүүжилт авч чадсан байна.

##### Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг сонгон шалгаруулах цахим программ:

- Тус программ нь үнэлгээний хорооны гишүүдийг санамсаргүй байдлаар сонгодог бөгөөд тус системийг 2022 оны 12 дугаар сараас эхлэн нэвтрүүлжээ.

##### Хамтын ажиллагаа:

- Салбар хариуцсан төрийн захиргааны төв болон харьяа дэд бүтэц, мэдээлэл, технологи, харилцаа холбооны мэргэжлийн байгууллагуудтай байнгын, үр нөлөөтэй харилцааг бий болгожээ.
- ЦХХХ-ны сайд болон Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2022 онд хийгдсэн хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг зүйл бүрээр дүгнэн ажилласан байна.

**1.109** Дэлхийн улс орнууд цахим хөгжлийн хувьд харилцан адилгүй түвшинд байгаа ч хөгжингүй орнуудын жишгээр цахим салбарын хөгжил нь үйлдвэрлэлтэйгээ шууд холбогдож, дотоодын эдийн засагт зонхилох байр суурийг нэгэнтээ эзэлж байх тул энэ чиглэлээр тусгайлсан бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай нь ажиглагдаж байна.

**1.110** Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх арга хандлагыг төлөвшүүлэх, төрийн захиргааны төв байгууллагууд болон салбар хоорондын уялдааг хангасан хамтын ажиллагааг удирдан чиглүүлж бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, үндэсний зорилтын хэрэгжилтийн үр дүн, түүний ахиц дэвшлийг үнэлэх горим тогтолцоог бий болгоход санал санаачилгатай ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаад анхаарах ёстой.

**1.111** Тухайлбал, аудитын урьдчилсан судалгааны болон талбарын үе шатны ажлын явцад МХХТ-ийн чиглэлд төрийн байгууллагуудын зарцуулж буй

төсвийн урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалтын талаарх нэгдсэн судалгаа байхгүй байгаа нь нотлогдсон.

**1.112** Төсвийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох төсөл, хөтөлбөрийн талаар улсын хэмжээнд нэгтгэсэн мэдээлэлгүй байгааг анхаарч үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд гарч буй төсвийн зарцуулалтын үр нөлөөг үнэлэх шаардлагатай байна<sup>20</sup>.

**1.113** Монгол улсын хэмжээнд тавигдсан үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр салбар бүрд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилтийн мэдээлэл, тэдгээрийн бүртгэл, үр дүнгийн мэдээллийг нэгтгэн тайлагнаж, үр нөлөөг үнэлэх асуудлыг Сангийн яам болон ЦХХХЯ хамтран хариуцаж ажиллах шаардлагатай байна.

**1.114** Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд цахим шилжилтийн хүрээнд төрийн бүхий л байгууллагууд нөөцийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах боломжийг тэр бүр ашиглахгүй байгаагийн дээр ялангуяа төсвийн эх үүсвэрээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үндэслэл, баталгаажуулалт, мөн чиглэлээр төсвийн урсгал зардлын хяналтыг сайжруулах явдал хангалтгүй байна.



<sup>20</sup> Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл





## ДҮГНЭЛТ

### **“Харилцаа холбооны болон бусад салбарын хуулийн уялдааг хангах, салбар дундын зохицуулалт, өгөгдөл, мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай”**

- МХХТ-ийн салбарын хөгжлийг хурдасгах, “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн хууль тогтоомжийн шинэчлэл нь хэрэгцээ шаардлага, бодлогын үндсэн зорилтод нийцэж, нэгдмэл эрх зүйн орчинд ажиллах нөхцөлийг бий болгосон байна.
- Эрх зүйн зохицуулалтын нэгдмэл байдлыг хангаж үндэсний хэмжээнд МХХТ-ийн салбарын чиглэлээр хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан шийдлүүд, зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг гүйцэтгэлд суурилсан арга хандлагаар хэмжих, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.
- Үндэсний зорилтын хэрэгжилтийг хангахын тулд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдааг хангасан зохицуулалтыг бий болгоогүй, хууль тогтоомжийн дагуу зарим хэм хэмжээний актыг баталж мөрдөөгүй, хуулийн хэрэгжилт, төлөв байдал, үр дагаврыг үнэлэх, хянах горим тогтолцооны үйлчлэл сул байгаа нь үндсэн зорилт болон хуулийн хэрэгжилт сулрахад хүргэж болзошгүй байна.
- Салбарын хууль тогтоомжийн хүрээнд батлах дүрэм, журам, стандарт, бодлогын баримт бичгүүдийг баталж мөрдүүлэх, мөн салбарын зарим хууль /Радио давтамжийн тухай хууль, Шуудангийн тухай хууль/-ийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх цаг хугацааны болон практик шаардлага үүссэн байна.
- МХХТ-ийн салбарт суурь дэд бүтэц, хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд тавигдах хяналт, хариуцлагын асуудлыг нарийвчлан зохицуулах, бусад салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.
- НМИТБТХ-ийн 27.8, 29 дүгээр зүйлд заасан мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр ЦХХХЯ-нд бүртгүүлэх, мэдээлэл хариуцагч систем хөгжүүлэхийн өмнө цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дүгнэлт, зөвлөмж авах тухай зохицуулалт хангалтгүй хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь нийтийн мэдээлэл хариуцагч нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.
- “Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн нийтлэг журам”, “Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт”, “Нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл хөгжүүлэхэд ашиглах технологийн талаар баримтлах чиглэл”-ийг батлаагүй байна.
- Салбар дундын зохицуулалтыг оновчтой болгон хэвшмэл байдлыг халах, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг үр нөлөөтэй удирдах, үр дүнг хянах горим тогтолцоог бий болгоогүйгээс салбар бүрийн мэдээлэл, харилцаа холбоо, технологи, үйлчилгээ нь харилцан уялдаагүй, нэгдсэн хяналтгүй, хөрөнгө оруулалтын давхардалтай байгаа нь хуулийн хэрэгжилтийг сулрахад хүргэж байна.
- Цахим шилжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбаруудын удирдлагын манлайлал дутмаг байгаа нь цахим шилжилтээс хойш татах нэг хүчин зүйл болж байна.

### **Хөгжлийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг “Цахим Монгол” зорилтын хүрээнд дэвшүүлж чадсан ч хэрэгжилтийг үнэлэх үйл явц сул, гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, стандартад нийцсэн өгөгдлийн системийн стратеги, бодлого байхгүй байна**

- Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт мэдээлэл харилцаа холбоо, технологийн салбарыг

хөгжүүлэх зорилт, арга хэмжээ нь ЦХХХЯ-наас гаргасан бодлогын баримт бичигт тусгалаа олсон байна.

- Мэдээллийн системийн тусламжтай үүсэж байгаа өгөгдөл, түүнийг цуглуулах, хадгалах, чанарыг хангах, хянаж үнэлэх, ашиглах үйл ажиллагааг удирдах болон өгөгдөлд тулгуурласан үйл ажиллагаа явуулахад удирдамж чиглэл болох үндэсний стратеги, бодлогогүй байна.
- МХХТ-ийн салбарын бодлогын хэрэгжилтийг хэмжих, хянах үйл явц бүрэн төлөвшиж чадаагүй байна.

**“Бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт бүрэн төлөшлийг олж чадаагүй, Төрийн албаны зөвлөлийн мэдээлэл бодит цагийн хэрэгцээг хангахгүй байна”**

- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогод МХХТ-ийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, төрийн албанд ажиллах мэдээллийн технологийн хүний нөөцийн тогтвор суурьшилтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн цогц арга хэмжээ тусгагдаагүй байна.
- Засгийн газрын байгууллагууд МХХТ-ийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн сурах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталсан ч тэдгээрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, төлөвлөгөө, үнэлгээний шалгуур үзүүлэлт нь тодорхой бус, хэрэгжүүлэх хугацаа харилцан адилгүй байгаа нь хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд эрсдэл үүсэж байна.
- МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга зам тодорхой бус, боловсруулалт хангалтгүй байна. Мөн энэ тогтоолын хэрэгжилтийн талаарх төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын талаарх ТАЗ-ийн мэдээлэл хангалтгүй байна.
- МУЗГ-ын байгууллагууд цахим шилжилт, хөгжлийг бодлогоор дэмжиж байгаа хэдий ч тэдгээр бодлогыг дэмжсэн зохион байгуулалт, хүний нөөц хангалтгүй, тусгайлсан горим тогтолцоо үгүйлэгдэж байна.
- Бүх нийтийн цахим үр чадварыг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байдал хангагдахгүй байгаа нь уг төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг бүхэлд нь хянаж, удирдах боломжийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

- ТАЗ-ийн мэдээлэл бодит цагийн хэрэгцээг хангахгүй, төрийн бусад байгууллагуудын өгөгдлийн сангуудтай уялдаагүйгээс төрийн албаны ялангуяа ХНУМТ системд мөрдөж буй ангилал, кодын үнэн бодит байдал хангагдахгүй байна.
- ТАЗ нь ТАТХ-иар хүлээсэн “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах” үүргээ хэрэгжүүлээгүй байна.

**“Үндэсний бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үйл явц удаашралтай, нээлттэй ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байна”**

- “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөл” нь ажиллахгүй байгаагаас гадна хяналт, удирдлага байхгүй байна. МУЗГ-аас хэрэгжүүлж буй 5Ш ажиллагааны нэг болох “Шил ажиллагаа” нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох зорилго бүхий үйл ажиллагаа бөгөөд шаардлагатай мэдээллийг нэгдсэн платформ /цахим хуудас/ буюу “shilen.gov.mn”-д байршуулах тухай асуудал юм. Энэхүү үйл ажиллагааг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ХЗДХЯ-ны дэргэд ажиллах Зөвлөл”-ийн үйл ажиллагаанаас ялгаатай авч үзэх шаардлагатай байна.
- Үндэсний зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дотоодын сайн туршлагыг нэвтрүүлэхээс гадна цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж байгаа улс орны ололт, сайн жишгийг судалж нэвтрүүлэх, зорилтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж ажиллах шаардлагатай байна.

**Хавсралт 1.1**

Хууль тогтоомжийн дагуу батлагдаагүй хэм хэмжээний акт

№	Хуулийн үндэслэл	Батлах субъект	Баримт бичгийн нэр
<b>1. Харилцаа холбооны тухай хууль</b>			
1	5.1.5. харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журмыг батлах	Засгийн газар	Судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам
2	6.1.14.в. төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийг шалгаруулах, тэдгээрийг дамжуулах үйлчилгээний журам
3	6.1.14.г. интернэтийн дундын холболтын журам	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Интернэтийн дундын холболтын журам
4	6.1.16. харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
5	30.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батална.	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам
6			Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал
7	30 <sup>1</sup> .3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.	Засгийн газар	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалт
<b>2. Шуудангийн тухай хууль</b>			
8	6.1.5. шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам батлах	Засгийн газар	Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам
<b>3. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль</b>			
9	28.2. Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах радио, телевизийн тоог тодорхойлно.	Засгийн газар	Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах радио, телевизийн тоо
10	28.3. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг батална.	Засгийн газар	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам
11	29.1.5. төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага
<b>4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль</b>			
12	27.9. Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар	Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам
13	28.1. нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийг Засгийн газар батална.	Засгийн газар	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт
14	28.3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмыг Засгийн газар батална.	Засгийн газар	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журам
15	32.1.10. нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл хөгжүүлэхэд ашиглах технологийн талаар баримтлах чиглэлийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл хөгжүүлэхэд ашиглах технологийн талаар баримтлах чиглэл

16	32.1.17.нээлттэй өгөгдлийн нөхцөл, шаардлага, стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;	Стандартын байгууллага	Нээлттэй өгөгдлийн нөхцөл, шаардлага, стандарт
<b>5.Кибер аюулгүй байдлын тухай хууль</b>			
17	10.1.3.үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг батлах;	Засгийн газар	Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө
<b>6.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль</b>			
18	27.7.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл
<b>7.Цахим гарын үсгийн тухай хууль</b>			
19	8.5.Тоон гарын үсгийн хэрэгслийн төрөлд хязгаар тогтоохгүй бөгөөд шаардлага хангасан тоон гарын үсгийн хэрэгслийн төрлийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, нийтэд мэдээлнэ.	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тоон гарын үсгийн хэрэгслийн төрлийн жагсаалт
20	9.5.Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага
21	24.1.2.цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон санхүү, хүний нөөц, техник, технологи болон мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх.	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих санхүү, хүний нөөц, техник, технологи болон мэдээллийн аюулгүй байдлын шаардлага
22	31.1.5.нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлагыг батлах;	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлага
23	32.1.2.нийтийн түлхүүрийн дэд бүтцийн стандарт боловсруулах;	Стандартын байгууллага	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн стандарт

**Хавсралт 1.2**

Зарим төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн мэдээлэл

№	Яамдын нэр	Баримт бичгийн нэр	Баталсан огноо	Хэрэгжих хугацаа	Төлөвлөгөө бий эсэх /тийм, үгүй/	Шалгуур үзүүлэлттэй эсэх /тийм, үгүй/
1	Эдийн засаг, хөгжлийн яам	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2022.04.15	2022-2025	Үгүй	Үгүй
2	Гадаад харилцааны яам	Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, ахмад настанд буцалтгүй тусламж үзүүлэх хөтөлбөр	2020.03.20	-	Үгүй	Үгүй
3	Сангийн яам	Сангийн яамны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр	2020.12.30	2019-2029	Үгүй	Тийм
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2022.11.16	2022-2024	Үгүй	Үгүй
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр	2022.05.25	2022-2026	Үгүй	Үгүй
6	Батлан хамгаалах яам	Батлан хамгаалах яамны албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө	2023	2023	Тийм	Тийм
7	Барилга, хот байгуулалтын яам	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2021.05.24	2021-2024	Тийм	Үгүй
8	Боловсрол, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2018.05.26	2018-2022	Тийм	Үгүй
9	Зам, тээврийн хөгжлийн яам	Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2017.03.21	2017-2020	Тийм	Үгүй
10	Соёлын яам	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө	2023	2023	Тийм	Тийм
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2018.02.22	2016-2020	Үгүй	Тийм
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	ХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр	2022.11.22	2022-2025	Үгүй	Үгүй
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2022.11.29	2023-2027	Үгүй	Үгүй
14	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	ЦХХХЯ-ны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр	2022.12.06	2022-2024	Үгүй	Үгүй
15	Эрчим хүчний яам	Эрчим хүчний яамны төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	2020.01.24	2020-2024	Үгүй	Үгүй
16	Эрүүл мэндийн яам	ЭМЯ-ны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр	2023.10.06	2023-2025	Тийм	Тийм

**Хавсралт 1.3**

МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт (боловсролын түвшин, бакалавр)

№	Байгууллага, ажлын байрны нэр	Бакалавр								Нийт
		Бизнесийн удирдлага	Газрын инженер	Компьютер	Мэдээллийн систем	Мэдээллийн технологи	Мэдээлэл зүй	Программ, мэдээллийн систем	Тодорхойгүй	
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар		1					1		2
	Орон зайн веб үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженер		1							1
	Салбарын программ хангамж хөгжүүлэлт хариуцсан инженер							1		1
2	Оюуны өмчийн газар				1				1	2
	Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн								1	1
	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн				1					1
3	Төрийн албаны зөвлөл				1	1				2
	Мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн				1	1				2
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар			1	1	1			1	4
	Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн программист			1		1			1	3
	Мэдээллийн сүлжээ, техник ашиглалтын хэлтсийн сүлжээний инженер				1					1
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар				1					1
	Нийгмийн халамжийн программ хангамж хариуцсан программист				1					1
6	Цахим хөгжил харилцаа холбооны яам	1			1					2
	Мэдээлэл технологийн ажилтан	1			1					2
7	Шүүхийн сахилгын хороо							1		1
	Эрхлэгч, сүлжээний							1		1
Нийт		1	1	1	5	2	1	1	2	14

Эх сурвалж: ТАЗ-ийн мэдээлэл

## МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт (боловсролын түвшин, магистр)

№	Байгууллага, ажлын байрны нэр	Магистр				Нийт
		Бизнесийн удирдлага	Боловсрол судлал	Компьютер	МАН-н өргөн мэргэжил	
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар				1	1
	Орон зайн веб үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженер				1	1
	Салбарын программ хангамж хөгжүүлэлт хариуцсан инженер					-
2	Оюуны өмчийн газар	1	1			2
	Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн		1			1
	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	1				1
3	Төрийн албаны зөвлөл			1		1
	Мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн			1		1
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар	1				1
	Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн программист	1				1
	Мэдээллийн сүлжээ, техник ашиглалтын хэлтсийн сүлжээний инженер					-
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар					-
	Нийгмийн халамжийн программ хангамж хариуцсан программист					-
6	Цахим хөгжил харилцаа холбооны яам	1				1
	Мэдээлэл технологийн ажилтан	1				1
7	Шүүхийн сахилгын хороо					-
	Эрхлэгч, сүлжээний					-
Нийт		3	1	1	1	6

Эх сурвалж: ТАЗ-ийн мэдээлэл

## МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт (өмнөх хөдөлмөр эрхлэлт)

№	Байгууллага, ажлын байрны нэр	Өмнөх хөдөлмөр эрхлэлт			Нийт
		ТА-нд ажиллаж байгаагүй	Тодорхой бичээгүй	Энэ байгууллагадаа ажиллаж байгаад томилогдсон	
1	<b>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар</b>		1	1	2
	Орон зайн веб үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженер		1		1
	Салбарын программ хангамж хөгжүүлэлт хариуцсан инженер			1	1
2	<b>Оюуны өмчийн газар</b>	1		1	2
	Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн			1	1
	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	1			1
3	<b>Төрийн албаны зөвлөл</b>			2	2
	Мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн			2	2
4	<b>Улсын бүртгэлийн ерөнхий газар</b>			4	4
	Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн программист			3	3
	Мэдээллийн сүлжээ, техник ашиглалтын хэлтсийн сүлжээний инженер			1	1
5	<b>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</b>			1	1
	Нийгмийн халамжийн программ хангамж хариуцсан программист			1	1
6	<b>Цахим хөгжил харилцаа холбооны яам</b>	2			2
	Мэдээлэл технологийн ажилтан	2			2
7	<b>Шүүхийн сахилгын хороо</b>			1	1
	Эрхлэгч, сүлжээний			1	1
Нийт		3	1	10	14

Эх сурвалж: ТАЗ-ийн мэдээлэл



## МУЗГ-ын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилт (тухайн байгууллагад ажилласан жил)

№	Байгууллага, ажлын байрны нэр	Тухайн байгууллагад ажилласан жил								Нийт
		1 хүргэлх	1 жил	5 жил	7 жил	8 жил	10 жил	11 жил	12 жил	
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	2								2
	Орон зайн веб үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан инженер	1								1
	Салбарын программ хангамж хөгжүүлэлт хариуцсан инженер	1								1
2	Оюуны өмчийн газар	1							1	2
	Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн								1	1
	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	1								1
3	Төрийн албаны зөвлөл	1	1							2
	Мэдээллийн сангийн ахлах мэргэжилтэн	1	1							2
4	Улсын бүртгэлийн ерөнхий газар				1	1	1		1	4
	Мэдээллийн сан, программ хангамжийн хэлтсийн программист				1	1	1			3
	Мэдээллийн сүлжээ, техник ашиглалтын хэлтсийн сүлжээний инженер								1	1
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар			1						1
	Нийгмийн халамжийн программ хангамж хариуцсан программист			1						1
6	Цахим хөгжил харилцаа холбооны яам	2								2
	Мэдээлэл технологийн ажилтан	2								2
7	Шүүхийн сахилгын хороо		1							1
	Эрхлэгч, сүлжээний		1							1
	Нийт	6	2	1	1	1	1	1	1	14

Эх сурвалж: ТАЗ-ийн мэдээлэл

## БҮЛЭГ 2

Цахим Монгол зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бодит тооцоо судалгаанд үндэслэж оновчтой төлөвлөөгүйгээс арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна



## Үндсэн мэдээлэл

МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г, 2 дугаар хавсралтаар “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г тус тус баталж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг дараах байгууллага, албан тушаалтанд даалгасан байна. Үүнд:

- Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн улс болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Үндэсний хөгжлийн газарт;
- Эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад тус тус даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим Монгол” зорилтын хүрээнд дэвшүүлсэн 15 зорилтын 86 арга хэмжээг 14 байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

“Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ агуулгын хүрээнд “Цахим хөгжлийн нэгдсэн бодлогын төлөвлөлт, удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх” зорилтод 8 (ЗГХЭГ, ЦХХХЯ, ХЗДХЯ, ТЕГ, ТӨБЗГ, ШСАА/МХЕГ, Сангийн яам/ТАЗ, УИТ) төрийн байгууллагын 64, хувийн хэвшил (Монгол шуудан ТӨХК)-ийн 1, нийт 65 арга хэмжээ;


- Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлэх хүрээнд ЗГХЭГ-ын 1 арга хэмжээ;
- Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 8 арга хэмжээ;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох хүрээнд 5 арга хэмжээ;
- Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлэх зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;
- Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгох зорилтын хүрээнд 6 арга хэмжээг тус тус баталсан байна.

“Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 86 арга хэмжээний 11 нь төсөвгүй, үлдсэн 75 арга хэмжээнд нийт 763.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. /Хавсралт 2.1-ийг үзнэ үү/

**Хүснэгт 2.1** “Цахим Монгол” зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хөрөнгийн хэмжээ (тоо, тэрбум төгрөг)

Зорилт	Арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ		Нийт хөрөнгийн хэмжээ
		Үгүй	Тийм	
Нийт	86	11	75	763.7
“Цахим Монгол” зорилтод чиглэсэн	65	7	58	597.5
Бусад зорилттой уялдаж чиглэсэн	21	4	17	166.2

“Цахим Монгол” зорилтын хүрээнд тусгагдсан 45 арга хэмжээнд 144 худалдан авах ажиллагааг зохион байгуулж 89.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 61 худалдан авах ажиллагаа зохион байгуулж 39.3 тэрбум төгрөг, олон улсын зээл тусламжаар 44 худалдан авах ажиллагаа зохион байгуулж 22.7 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. /Хавсралт 2.2-ыг үзнэ үү/



ТХААГ-ын цахим системд бүртгэлтэй худалдан авах ажиллагааны мэдээлэлтэй тулган баталгаажуулахад “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 25 арга хэмжээний 27.0 тэрбум төгрөгийн 39 худалдан авах ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлээгүйгээс аудитад хамрагдаагүй болно.  
/Хавсралт 2.2, 2.5-ыг үзнэ үү/

“Цахим Монгол” зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 105 худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас 6 нь барилга байгууламжид 13.5 тэрбум төгрөг, 39 нь тоног төхөөрөмжид<sup>1</sup> 19.4 тэрбум төгрөг, 5 нь тоног төхөөрөмж болон программ хангамжид 11.7 тэрбум төгрөг, 14 нь программ хангамжид<sup>2</sup> 10.3 тэрбум төгрөг, 41 нь бусад<sup>3</sup> буюу зөвлөх үйлчилгээнд 7.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.  
/Хавсралт 2.3, 2.4-ийг үзнэ үү/



**1** Сервер, компьютер бусад холбогдох электроник биет хөрөнгүүд орж байгаа болно.  
**2** Систем хөгжүүлэх, лиценз худалдаж авах гэх мэт худалдан авалт орж байгаа болно.  
**3** Баримт бичиг боловсруулах, орчуулга хийх, ажлын даалгавар боловсруулах, сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээ



## “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ бодлогын зорилттой нийцэж байгаа боловч хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна

### “Төсөл, арга хэмжээний хөрөнгө, санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүй байна”


2.1 “Цахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 86 арга хэмжээ тусгагдсанаас зорилтын хэрэгжилтийг хангахад чиглэсэн 84, зорилтоос гадуур төлөвлөсөн 2 арга хэмжээ байна.

2.2 Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим Монгол” зорилтын 4.1.1-д “Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэн нэг удаа бүртгүүлээд

төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна” гэж тусгасны дагуу ХЗДХЯ хариуцан хэрэгжүүлэх 11 арга хэмжээнээс бодлогын зорилтод чиглээгүй 2 арга хэмжээ байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна. /Ховд, Хэнтий аймгийн Улсын бүртгэл, архивын тасгийн барилга/
- Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төслийг хэрэгжүүлнэ. /Барилгын засвар/

2.3 “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй 86 арга хэмжээнээс шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж төсвийн төсөлд санал хүргүүлээгүй 26, санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй 26, төсвийн урсгал зардлаар санхүүжүүлсэн 8 арга хэмжээ байна.



**2.4** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсвөөс дараах арга хэмжээний санхүүжилт нь хэтэрсэн байна. Үүнд:

- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа тодорхой төрлийн хэргийн материалыг цахимжуулах” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2020-2024 онд шаардагдах эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 200.0 сая төгрөг тусгасан ч ХЗДХЯ-наас авсан мэдээллээр гадаад эх үүсвэрийн талаарх мэдээлэл хангалтгүй, улсын төсвөөс 2022 онд 338.4 сая төгрөг, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.3 тэрбум төгрөг, нийт 1.6 тэрбум төгрөгийг зарцуулсан;
- “Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлэх” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 100.0 сая төгрөг тусгасан ч 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.

**2.5** 2023 оны хүрэх түвшинд төлөвлөгдсөн хэмжээгээр санхүүжилт аваагүй дараах арга хэмжээ байна. Тухайлбал,

#### **ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Сум суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох” арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 8.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч 2021 онд улсын төсвөөс 227.3 сая төгрөг, бүх нийтийн үүргийн сангаас 2021-2022 онд 1.1 тэрбум төгрөг, нийт 1.4 тэрбум төгрөгөөр шилэн кабель суурилуулсан байна.
- “Үндэсний дата төвийн техник, хүчин чадлыг сайжруулна” арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 30.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч 2021-2022 онд улсын төсвөөс 13.6 тэрбум төгрөгөөр техник, хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.
- “Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна” арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 9.0 тэрбум төгрөгөөр 5 зангилаа төвийг байгуулахаар төлөвлөсөн боловч 2022 онд улсын төсвөөс 6.5 тэрбум төгрөгөөр Дархан-Уул аймагт өгөгдөл мэдээллийн зангилаа төвийг барьж байна.

#### **ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ”

арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 3.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч 2022-2023 онд улсын төсвөөс 365.9 сая төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд 2021, 2023 онд 1.6 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, нийт 2.0 тэрбум төгрөгийг мобайл тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлтэд зарцуулсан байна.

#### **ШСАА/МХЕГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

МУЗГ-ын 2022 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгах шийдвэр гаргаж тус арга хэмжээг ЦХХХЯ-нд шилжүүлсэн байна.

- “Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэнэ” арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 580.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч 2021 онд улсын төсвөөс 198.9 сая төгрөгөөр хяналтын системийг шинэчилсэн байна.

#### **БХБЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ” арга хэмжээг 2021 онд улсын төсвөөс санхүүжүүлж, нийт хөрөнгийн хэмжээг 1.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч 2020 онд улсын төсвөөс 1.0 тэрбум төгрөгөөр хаягийн мэдээллийн системийг хийсэн байна.

#### **ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Цахим архив албан хэрэг хөтлөлт хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 8.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг тусгасан ч 81.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
- “Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалт сайжруулах” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021, 2022, 2023 оны нийт төсөв 53.2 тэрбум төгрөгөөр тусгагдсан ч 2023 оны байдлаар нийт 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан

буюу Ховд аймгийн Улсын бүртгэл, архивын тасгийн барилгын ажлын гүйцэтгэлд 4.4 тэрбум төгрөг, Хэнтий аймгийн Улсын бүртгэл, архивын тасгийн барилгын ажлын гүйцэтгэлд 3.4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

- “Ухаалаг эмнэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021, 2022, 2023 оны нийт төсөв 3.6 тэрбум төгрөгөөр тусгагдсан ч 2023 оны байдлаар 0.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**2.6** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй дараах арга хэмжээ байна. Үүнд:

#### **ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ;
- Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ;
- Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна;
- Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ;
- Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна;
- Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна;
- Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулна;
- Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд үр чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулна;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан албан хаагчдад мэргэжлийн үр чадвар олгох мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулна;

- Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулна;
- Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв байгуулна.

#### **ЗГХЭГ-аас ЦХХХЯ-ны чиг үүргийн хүрээнд шилжүүлсэн арга хэмжээ<sup>4</sup>:**

- Үндэсний CERT-ийн үйл ажиллагааг эхлүүлнэ;
- Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлнэ;
- Зөвшөөрлийн нэгдсэн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Нээлттэй өгөгдлийн порталыг өргөтгөнө;
- Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулна.

#### **БХБЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна;
- Навигацийн хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана;
- Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна;
- Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ;
- Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.

#### **СХЗГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.

#### **ТӨБЗГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно;
- Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно.

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж ЗГХЭГ-ын хэрэгжүүлэх 13 арга хэмжээг шилжсэн байна.

**ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулах.

**2.7 “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд батлагдсан арга хэмжээний санхүүжилтийг Төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу төсвийн төсөлд санал хүргүүлээгүй дараах арга хэмжээ байна. Үүнд:**

**ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулна;
- Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгоно;
- Шуудан, ложистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулна;
- Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлнэ;
- Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна;
- Харилцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, барилга байгууламж зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө;
- Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулна;
- Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ;
- Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно;
- Инновац, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний институтийг бэхжүүлнэ;
- МХХТ-ийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана;
- Оюуны өмч, зохиогчийн эрх, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах систем хөгжүүлнэ.
- МХХТ-ийн хэрэглээний өрх болон хувь хүний судалгааг хийнэ.

- Шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулж, хэрэглээг цахим худалдаанд нэвтрүүлнэ.

Тус арга хэмжээг ХХЗХ-ны санхүүжилтээр хийдэг тул төсвийн төсөлд санал хүргүүлэх шаардлагагүй байна.

**ЗГХЭГ-аас ЦХХХЯ-ны чиг үүргийн хүрээнд шилжүүлсэн арга хэмжээ<sup>5</sup>:**

- Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, контент боловсруулж, түгээнэ;
- Бүх шатны төрийн байгууллагын албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх онлайн сургалтын платформ хөгжүүлж, сургалтын контент боловсруулж, сургалт зохион байгуулна;
- Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн шийдвэр гаргалтад иргэдээс санал авах цахим хэлэлцүүлгийн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

**ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний дэд бүтцийг бий болгоно;
- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ;
- Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна.

**ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болох;
- Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглах.

**2.8 “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, тооцооллын үндэслэл нь хууль тогтоомжийн шаардлагад нийцээгүй нь бодлогын зорилтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.**

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж ЗГХЭГ-ын хэрэгжүүлэх 13 арга хэмжээ шилжсэн байна.



## **Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нээлттэй, ил тод зарлан мэдээлсэн боловч төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг баримтлан ажиллаагүй байна**

**2.9** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 24 арга хэмжээний хүрээнд бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулсан байна.

**2.10** Зорилтын хүрээнд шаардагдах бараа, ажил үйлчилгээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хангалтгүй боловсруулсан дараах 2 арга хэмжээ байна. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх /ЭМЯ/;
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах /Сангийн яам, Төрийн албаны зөвлөл/

**2.11** Бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулсан 20 арга хэмжээ байна.

**2.12** Харин бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг арвилан хэмнэлттэй зохион байгуулсан дараах 4 арга хэмжээ байна. Тухайлбал,

### **ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.13** “Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ” арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

**2.14** Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг нь 2 дэд хэсгээс бүрдэж байгаа бөгөөд олон улсын 2 зөвлөх 656,975 ам.доллароор “Олон янзын үндэсний хэмжээний энтерпрайз архитектурыг боловсруулах”, “Эрүүл мэндийн өгөгдөл, мэдээллийн иж бүрэн стандартыг тогтоох” ажлын даалгаврыг боловсруулсан боловч мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлэхэд ашиглаагүй байна.

**2.15** Дэлхийн банкнаас Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх төслийн гүйцэтгэгч “Тайхан элэктрик вайрэ” ХХК (“Тайхан Кабель Солюшн” ХХК-ийн нэр солигдсон)-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2022 оны 8 дугаар сард “мэдээлэл технологийн аудит” хийж нийцлийн ерөнхий түвшин 29 хувьтай гэж дүгнэсэн байна. Харин Дэлхийн банкны Дотоод аудитын газрын авлига, ашиг сонирхлын газраас хийсэн шалгалтаар бичиг баримт хуурамчаар үйлдсэн, залилангийн шинж чанартай гэж үзсэн тухай мэдээллийг төслийн нэгжээс аудитын багт өгсөн.

**2.16** Эрүүл мэндийн өгөгдөл мэдээллийн иж бүрэн стандартыг тогтоох ажлын даалгаврын дагуу Швед улсын “Хорус Эй Би” ХХК (CHORUS AB), туслан гүйцэтгэгчээр Монгол улсад бүртгэлтэй “Моно Солюшн” ХХК нар Эрүүл мэндийн төслийн өгөгдөл, мэдээллийн технологийн стандартууд, Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь бичиг боловсруулах ажлыг тус бүр 199,950 ам.доллароор гүйцэтгэхээр шалгарсан боловч ажлын гүйцэтгэлийг ЭМЯ-аас хангалтгүй, Дэлхийн банкнаас хийсэн мэдээллийн технологийн аудитаар FHIR эх сурвалжийн үйлчилгээний хүсэлтийг ашиглах ёстой боловч бодит байдал дээр ашиглагдахгүй, бүрэн утгаараа хэрэгжээгүй гэж тус тус үзсэн байна.

**2.17** “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд дотоодын 8 зөвлөх үйлчилгээг 464.4 сая төгрөгөөр авсан боловч хийгдсэн ажлын тайланг хүлээж авсан акт үйлдээгүй, Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэхэд ашиглаагүй байна.

**2.18** Дээрх арга хэмжээний хүрээнд “Тайхан Кабель Солюшн” ХХК, “Бит Компьютер” ХХК-ийн түншлэлтэй байгуулсан ЭММСП-ыг боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх гэрээг Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу монгол хэлээр хөтлөн хэрэглээгүйгээс ажлын явц, гүйцэтгэлийг ЭМЯ иж бүрэн үнэлээгүй байна.

**2.19** ЭМЯ-ны Эрүүл мэндийн мэдээллийн технологийн техникийн хорооны 2022 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн тогтоолоор “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ /НІЕР/-ыг нэвтрүүлэх гэрээт ажлын 11 зорилтын хүрээнд ажлын явцыг 61.28 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

**2.20** Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл хангалтгүй, үнэлгээ хийсэн хууль ёсны нотлох баримтад үндэслэхгүйгээр **6** Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ

санхүүжилтийг олгосон шалтгаанаар Дэлхийн банк МУЗГ-аас 1.7 сая ам.долларыг буцаан нэхэмжилсэн байна.

**2.21** Тодруулбал, Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх “Тайхан элэктрик вайрэ” ХХК (“Тайхан Кабель Солюшн” ХХК-ийн нэр солигдсон)-тай байгуулсан 6.0 сая ам.долларын гэрээт ажлын гүйцэтгэлийн 2 дахь төлөлтийг төслийн удирдагч мэдээлэл технологийн аудитын үр дүн гарах хүртэл төлбөрийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналаа мэдэгдсэн байна.

**2.22** Гэвч ЭМЯ-ны ТНБД-ын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталсан бөгөөд ажлын хэсгийн 2021-03 дугаар дүгнэлтээр ажлын гүйцэтгэлийг 19.2 хувь гэж дүгнэж, дараагийн төлбөрийг гүйцэтгэгчид шилжүүлэхэд татгалзах зүйлгүй гэж дүгнэсэн байна.


**2.23** Цахим эрүүл мэнд төсөл (5489-MN)-өөс ЭМЯ-д нэхэмжлэлийг хангах боломжгүй тухай мэдэгдсэн боловч ЭМЯ-ны ТНБД-ын албан бус хэлбэрээр үүрэг өгсний дагуу (баталгаажсан уулзалтын тэмдэглэл байхгүй) Сангийн яаманд 2 дахь төлбөр болох 1.2 сая ам.долларын санхүүжилтийг хянан баталгаажуулсан албан бичгийг хүргүүлсэн байна.

**2.24** Нөхцөл байдлаас үзэхэд “Тайхан Кабель Солюшн” ХХК, “Бит Компьютер” ХХК-ийн түншлэл, туслан гүйцэтгэгч Монгол улсад бүртгэлтэй “Аксиссистемс” ХХК-тай байгуулсан гэрээний 2 дахь төлбөр болох 1.2 сая ам.долларын санхүүжилтийг ийнхүү шилжүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байгаа тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлэв.

**2.25** Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан захирал 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 026/23 дугаар албан бичгээр санхүүжилтийн гэрээнд (2006 оны 5 дугаар сард батлагдсан “Дэлхийн банкны Төслийн зарцуулалтын журам”-ын 7.1-ийн заалт) заасны дагуу нийт 1.7 сая ам.долларыг 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөрт багтаан Дэлхийн банканд буцаан олгох тухай мэдэгдлийг МУЗГ-т хүргүүлж байсан байна.

**2.26** МУЗГ-ын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 8 дугаар хурлын тэмдэглэл, 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор төлбөрийг эргүүлэн төлүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

**2.27** “Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн дараах байдалтай байна. Үүнд:



**2.28** Дүрс архивлан хадгалах (PACS) системийн патент, ашиглалтын загвар, худалдааны тэмдэг, загвар, зохиогчийн эрх, ноу-хау эсвэл бусад оюуны өмчийн эрхийн өмчлөлийг гэрээнд тодорхой тусгаагүйгээс эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэгч компанид төлбөр төлж нэвтрүүлэхээр байна.

**2.29** Мөн системийг боловсруулан, хэрэгжүүлэх 1.9 сая ам.долларын MN-MOH-120874-NC-RFB-PACS (№ 150) дугаар гэрээг “Арема жапан” ХХК, “Амин” ХХК-ийн түншлэлтэй байгуулсан бөгөөд гэрээний лиценз/техникийн мэдээллийг ашиглах талаар 15 дугаар зүйлийн 15.1-д “...нийлүүлэгчийн эсвэл аливаа гуравдагч талын патент, ашиглалтын загвар, худалдааны тэмдэг, загвар, зохиогчийн эрх, ноу-хау эсвэл бусад оюуны өмчийн эрхийн өмчлөлийг захиалагчид шилжүүлнэ гэсэн ойлголт биш юм.” гэж тусгасан нь хэрэглэгчийн систем ашиглах, хөгжүүлэх, сайжруулах ажиллагаанд саад болж байна.

**2.30** Тус арга хэмжээний хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын 3 дугаар төв эмнэлэг, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв,

Сонгино хайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг зэрэг 6 эмнэлэг, Үндэсний дата төвд нийт 5.4 тэрбум төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлсэн байна. Гэвч гэрээнд тусгасан 38 ширхэг тоног төхөөрөмж, мөн программ хангамжийг холбогдох байгууллагуудад хуваарилж, суурилуулаагүй байна.

**2.31** Гэрээний хавсралт 5-д байгууламж болон түүний суурилуулалттай холбоотой үйлчилгээний гол тоног төхөөрөмжийг хэрэглэгч талд хүлээлгэн өгөхөөр тусгасан боловч Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар уг төслийн санхүүжилтээр бэлтгэсэн хөрөнгийг хуваарилж, хүлээлгэн өгсөн 2.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, программ хангамжийг гэрээнд зааснаас зөрүүтэй хуваарилсан байна. Үүнийг ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзэж хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлэв.

#### **Сангийн яам болон Төрийн албаны зөвлөлийн хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд:**

**2.32** “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах” арга хэмжээний хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2017 болон 2020 оны худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй, чанаргүй гүйцэтгэгч шалгарсан, гүйцэтгэлийн үр дүн хангалтгүй, тухайн программ системийг шилжүүлэн аваагүй зэрэг нь үргүй зардлыг бий болгосноос гадна худалдан авах ажиллагааг арвилан хэмнэлтгүй зохион байгуулсан байна.

#### **ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.33** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна” арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймагт зангилаа төв баригдаж байна.

**2.34** “Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна” арга хэмжээг 2021-2023 онд 5 зангилаа төвийг улсын төсвөөс 9.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь 1 аймагт барих зангилаа төвийн төсөв дунджаар 1.8 тэрбум төгрөг болохоор байна.

**2.35** Гэвч Дархан-Уул аймагт баригдаж байгаа өгөгдөл, мэдээллийн зангилаа төвийн барилгын төсөвт өртөг болох 6.5 тэрбум төгрөгийг ЦХХХ-ны сайдын багцад тусгасан байна. Энэ нь дээрх төсөвлөсөн дүнгийн 72.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 4 зангилаа төвийг барих төсөв хүрэлцэхгүй болох улмаар энэхүү арга хэмжээний хэрэгжилт хангагдахгүйд хүрч байна.

**2.36** ТХААГ-аас 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Мэдээлэл холбооны Дархан дэд төв"-ийн 2,406 м.кв талбай бүхий барилгын гүйцэтгэчийг сонгон шалгаруулан ирүүлсэн зөвлөмжийн дагуу 6.5 тэрбум төгрөгийн гэрээг байгуулж, арга хэмжээний гүйцэтгэл 60 хувьтай байна.

**2.37** Харин “Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв” байгуулах арга хэмжээний хүрээнд “Монгол шуудан” ХК өөрийн санхүүжилтээр 4.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2,620 м.кв барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажил дууссан байна.

**2.38** Олон улсын шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв болон Өгөгдөл мэдээллийн зангилаа төвийн төсөвт өртгийг харьцуулахад талбайн хэмжээ 200 м.кв-аар илүү барилгыг төсөвт өртгийн хувьд 1.6 тэрбум төгрөгийн бага зардлаар барьж байна.

**2.39** Харьцуулалтаас үзэхэд өгөгдөл мэдээллийн зангилаа төвийн барилга нь улсын төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж байх магадлалтай байна.

Өгөгдөл мэдээллийн зангилаа төв  
(Дархан-Уул аймаг) 2,406 м.кв, 6.5 тэрбум төгрөг



Олон улсын шуудангийн үндсэн сүлжээний ялган  
боловсруулах төв. 2,620 м.кв, 4.9 тэрбум төгрөг



## **“Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна”**

**2.40** Бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 24 арга хэмжээнээс 4 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хангалтгүй зохион байгуулсан, мөн 2 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

### **БОАЖЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.41** “Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ” арга хэмжээний хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

#### **2.42 [www.mongolia.travel](http://www.mongolia.travel) цахим платформ:**

БОАЖЯ нь Тайландын хаант улсын “Камелеон стратеги” ХХК-тай 2018 оны 10 дугаар сарын 29-нд “[www.mongolia.travel](http://www.mongolia.travel) цахим платформ бий болгох, контент хөгжүүлэх” ажлаар хамтран ажиллах санамж бичгийг сайдын хэмжээнд, ажил гүйцэтгэх гэрээг нэгжийн даргын хэмжээнд шууд байгуулан 2018 оны 11 дүгээр сараас 2019 оны 3 дугаар сар хүртэл хөгжүүлэлт, туршилтын ажил хийсэн байна.

**2.43** Уг цахим платформын нээлтийн үйл ажиллагааг 2019 оны 03 дугаар сарын 07-нд ХБНГУ-ын “ITV Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн худалдааны үеэр хийж, БОАЖ-ын сайд ахалсан Засгийн газрын гишүүд, аймаг, сумдын засаг дарга нар, төсөл болон аялал жуулчлалын операторуудын төлөөлөл нээлтэд оролцсон байна.

**2.44** [Mongolia.travel](http://Mongolia.travel) цахим платформыг 2018-2022 онд үүсгэн хөгжүүлэхэд 146.1 сая, олон улсад сурталчлахад 62.9 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн буцалтгүй тусламжаар хүлээн авсан санхүүжилтээс 12.7 сая төгрөг (3,700 евро), нийт 221.7 сая төгрөгийг зарцуулсан хэдий ч тус платформын домэйн эрхийг аваагүйн улмаас хөгжүүлэлт хийх боломжгүй болж тус арга хэмжээ үр дүнгүй болсон байна.

**2.45** ЗГХЭГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Хүсэлт уламжлах тухай” БОАЖ-ын сайдад ирүүлсэн ХЭГ/96 дугаар албан бичгээр [Mongolia.travel](http://Mongolia.travel) цахим платформыг хөгжүүлэхтэй холбоотой гэрээний хуримтлагдсан өр төлбөр болох 72,911.7 ам.долларыг төлж барагдуулах асуудлыг шийдвэрлэж, дүнг танилцуулахыг мэдэгдсэн байна.

**2.46** БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/97 дугаар тушаалаар байгуулсан “Ажлын хэсэг”-ийн 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар 2022 оны аялал жуулчлалын хөтөлбөрийн зардалд тус өр төлбөрийг барагдуулах төсөв батлагдсан, нэмэлт зардлыг төлөх эрсдэл үүсэж болзошгүйг харгалзан төлбөрийг барагдуулах дүгнэлтэд үндэслэн БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/135 дугаар тушаалаар дээрх зардалд шаардагдах 222.4 сая төгрөгийг холбогдох зардлаас гаргахаар шийдвэрлэж, 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр төлбөрийг шилжүүлсэн байна.

#### **2.47 [Mongoliatravel.guide](http://Mongoliatravel.guide) шинэ веб хуудас:**

Энэхүү төсөл нь “Монгол улсыг гадаад сурталчилгааны нэгдсэн веб хуудас, аппликейшн хөгжүүлэх, контент хийх” буюу Монгол улсыг сурталчлах зорилготой.

**2.48** Уг төслийн хүрээнд [Mongoliatravel.guide](http://Mongoliatravel.guide) вэбсайтыг дахин шинээр хийсэн ба 2022 оны 6 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 15-ныг хүртэлх 2 сарын хугацаанд [Mongoliatravel.guide](http://Mongoliatravel.guide) веб хуудас болон аппликейшны хөгжүүлэлтийн контент, видео мэдээ, мэдээллийг 6 хэл дээр дижитал, интерактив хэлбэрээр бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн байна.

**2.49** БОАЖЯ нь “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ-тай гэрээ байгуулсан ба тус ТББ нь “Ворлд плас” ХХК-тай 200.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий “[Mongoliatravel.guide](http://Mongoliatravel.guide)” вэбсайтыг хөгжүүлэх, орчуулгын ажил хийх гэрээг байгуулжээ.

**2.50** БОАЖ-ын сайдын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн А/246 дугаар тушаалыг үндэслэн БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/266 тушаал болон “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ-ын нэхэмжлэлээр эхний санхүүжилтийн 70 хувь болох 140.0 сая төгрөгийг 2022 оны 07 дугаар сард, үлдэгдэл санхүүжилт болох 60.0 сая төгрөгийг 2022 оны 08 дугаар сард “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ-д шилжүүлсэн байна.

**2.51** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.4.8.1-д тусгасан Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлэх арга хэмжээний хөрөнгийн нийт хэмжээг 100.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ч нийт 200.0 сая төгрөгийн зардал гаргаж төсөвлөсөн хөрөнгөөс илүү зардал гаргажээ.

**2.52** “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ нь mongoliatravel.guide шинэ веб хуудас төслийг хэрэгжүүлэхдээ “Ворлд плас” ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлд заасан гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх нөхцөлд хамаарахгүй бөгөөд БОАЖЯ-ны аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлсэн 200.0 сая төгрөгийн зарцуулалт нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчимтай нийцэхгүй, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, гүйцэтгэгч компанид давуу эрх олгосон байна.

**2.53** “Цахим Монгол” зорилтын хүрээнд аялал жуулчлалын салбарт хэрэгжсэн өмнөх төслийн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүйн улмаас Mongolia.travel цахим платформыг ашиглах боломжгүйд хүрсэн ба улмаар шинээр хэрэгжүүлсэн mongoliatravel.guide шинэ веб хуудсын худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод, арвилан хэмнэлттэй зарчмаар зохион байгуулаагүй, шаардлагатай зардал, санхүүжилтийн эх үүсвэрийг хуулийн шаардлага хангасан тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлгүй санхүүжилтийг олгосон байна.

**2.54** “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлэх, цахим платформыг хөгжүүлэх арга хэмжээнд нийт 644.1 сая төгрөгийг зарцуулжээ.

**2.55** Дээрх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх асуудлаар БОАЖЯ-д албан шаардлага өгөх, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 6 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг баримтлан аялал жуулчлалын салбарт улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжсэн хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, үр дүнг цаашид нягтлан шалгах, тодруулах шаардлагатай гэж үзэн эрсдэл бүхий асуудлаар аудитыг төлөвлөн, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.

#### **Сангийн яам болон ТАЗ-ийн хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.56** Төрийн албаны зөвлөл Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо систем (ХНУМТ)-ийг, Сангийн яам Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-ийг тус тус үүсгэж, хөгжүүлсэн байна.

**2.57** Төрийн албаны зөвлөл 2017 онд ХНУМТ цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг анх ЗИОН ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Үүний дараа НҮБ-ын дэмжлэгтэйгээр ХНУМТ системийн

суурь судалгааг 2019 онд хийсэн байна. Тус судалгаанд үндэслэн системийн “Суурь платформ” болон “Үндсэн хүний нөөц” гэсэн 2 модулийг 2020 онд Төрийн нууцад хамруулан дахин “Зион” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч ажлын даалгавар, техникийн нөхцөлийг чанартай боловсруулаагүйн улмаас системийн хөгжүүлэлт хангалтгүй хийгдсэн байна.

**2.58** 2017 онд “ЗИОН” ХХК-иар гүйцэтгүүлсэн систем хөгжүүлэлтийн ажлын гэрээг дүгнэсэн акт, тэмдэглэл, ажил хүлээлцсэн акт зэрэг баримт бичгийн бүрдэл дутуу, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг зөрчсөн байна.

**2.59** “ЗИОН” ХХК-ийн хөгжүүлсэн “Суурь платформ”, “Үндсэн хүний нөөц” гэсэн 2 модулийн хөгжүүлэлтийн эх кодыг авч чадаагүй учраас “Дижитал воркс” ХХК шинээр хийж гүйцэтгэсэн байна.

**2.60** ТАЗ нь 2021 онд “Дижитал воркс” ХХК-тай 614.1 сая төгрөгийн, 2022 онд 305.0 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулж санхүүжилтийг олгож, энэ системийн хөгжүүлэлтэд нийт 1.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**2.61** ТАЗ “ХНУМТ системийн нэмэлт хөгжүүлэлт”-ийг хийлгэхээр 2023 онд 350.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тус тендерт 2021, 2022 онд шалгарч байсан “Дижитал воркс” ХХК саналаа ирүүлсэн боловч ТАЗ-өөс уг компанийн өмнө нь хийсэн системийн нөхцөл байдлыг үнэлэх ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн тул тус компанитай гэрээ байгуулах ажлыг түр хойшлуулсан байна. Гэвч “Дижитал воркс” ХХК 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр гэрээ байгуулахаас татгалзаж байгаагаа албан бичгээр мэдэгдсэн байна.

**2.62** “Цахим Монгол” зорилтын хүрээнд Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системтэй холбогдох Төрийн албаны зөвлөлийн “ХНУМТ” системийн үйл ажиллагаа нь алдаа дутагдалтай, хөгжүүлэлтийн байдалд тавих хяналт сул, зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь нээлттэй, ил тод, арвилан хэмнэлттэй байх зарчмаар хэрэгжээгүй, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй, гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй, систем дэх мэдээллийн үнэн зөв, найдвартай, нууцлал, аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа зэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.

**ХНХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.63** ТБОНӨХБАУХАТХ<sup>7</sup>, Сангийн сайдын 2021 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам<sup>8</sup>”-д нийцүүлэн зохион байгуулаагүй дараах 3 арга хэмжээ байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлнэ;
- Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ;
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлнэ.

**ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Ухаалаг эмнэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд хяналт тавьж ажиллах талаар заалт ороогүй байгаа нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасныг хангаж ажиллаагүй байна. ТБОНӨХБАУХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.3, 47.4 болон 47.6-д заасан үнэлгээний хорооны гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэх нотлох баримт байхгүй байна.

## “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, явц удаашралтай байна

### “Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан нөхцөлүүд нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдаагүй байна”

**2.64** Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй 24 арга хэмжээний явц, гүйцэтгэлийг үзэхэд 22 арга хэмжээний гэрээ, ажлын даалгаварт тусгагдсан шаардлагын дагуу хэрэгжиж байгаа бөгөөд дараах 2 арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан нөхцөлүүд нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдаагүй байна. Үүнд:

<sup>7</sup> ТБОНӨХБАУХАТХ-ийн 46-р зүйл 46.1.2.үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;

<sup>8</sup> Сангийн сайдын 2021 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 2-р зүйл 2.13. Захиалагч үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох мэргэшсэн ажилтныг мэдээллийн санд бүртгэлтэй эсэх, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах хууль, журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана, 2.19. Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн бүр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэнэ.

**ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд ЭМЯ-наас анхан шатны эмнэлгийн байгууллагын өвчтөний цахим түүхийн системийг хөгжүүлж нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд хийгдсэн “E-hospital” системийг ашиглахгүй байх талаар албан ёсоор мэдэгдээгүй, хөгжүүлэлт хийхгүй байгаагаас цаашид ашиглах эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал, ЭМЯ-наас өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалтыг “E-hospital” цахим систем болон health.gov.mn системд нэвтрүүлсэн боловч сум, тосгоны эрүүл мэндийн төвд тусламж, үйлчилгээ үзүүлэх жагсаалтыг “health.gov.mn” системд нэвтрүүлээгүй.
- “Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээ

**2.65** Эрүүл мэндийн салбарт харилцаа холбооны болон мэдээллийн технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зайнаас үзүүлэх технологи (Телемедицин)-ийн үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтэц байхгүй байна.

**2.66** ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд мэргэжлийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Телемедициний албыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцээс хассан байна.

**2.67** Мөн 2020 онд Ковид цар тахлын улмаас эрүүл мэндийн салбарын албан хаагчид албан бус zoom, teams гэх мэт бусад холбогдох төхөөрөмжөөр холбогдож эхэлснээр тусгайлан телемедициний ашиглалт буурсан байна.

**2.68** Аудитын баг Баянзүрх дүүргийн анхан шатны тусламж, үйлчилгээний 45, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний 22 байгууллагаас салбарын систем ашиглалтын талаар судалгаа авсан ба судалгаа болон ажиглалтын үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Цахим орчинд ажиллахтай холбоотой нэгдсэн нэг системгүй олон программ ашигладаг, үйлчлүүлэгчийн бусад эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлсэн мэдээлэл, үзлэг, оношилгооны түүхийг харах боломжгүй, үйлчлүүлэгчийн ижил мэдээллийг олон программд давтан оруулж байгаа зэрэг нь эмчийн нэг иргэнд зарцуулах үзлэгийн цаг хугацааг уртасгаж чанаргүй үйлчилгээ үзүүлэх үндсэн шалтгаан болж иргэдийн гомдол, бухимдлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.


- Цахим системд шилжсэн гэх боловч бодит байдал дээр үйл ажиллагаа бүрэн цахимжаагүй, давхар цаасаар явагдаж байна. Мөн ашиглаж буй программ, системийн хэрэглээний хугацаа богино, тогтворгүй, ойр ойрхон дээд шатны байгууллагын шийдвэрээр солигддог нь системийг өдөр тутамдаа ашиглаж байгаа албан хаагчдад хүндрэл бэрхшээл учруулж байгаа нь судалгаанаас харагдаж байна.
- ӨЭМТ-ийн албан хаагчид нэгдсэн нэг программыг удаан хугацаагаар ашиглах, программ нь хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, найдвартай, аюулгүй байдлыг хангасан, үйлчлүүлэгчийн мэдээллийг эрүүл мэндийн салбарын байгууллагууд хоорондоо солилцох боломжтой системийг хөгжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.
- Сүүлийн 3 жилд ӨЭМТ цахимжилт нь асуудалтай, хэрэглээний программууд тогтмол солигддог, гацдаг, хоорондоо мэдээлэл солилцдоггүй байдал даамжирсан.
- Лавлагаа шатлалын эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвийн ашиглаж буй системүүд өөр хоорондоо мэдээлэл солилцдоггүй нь талуудад хүндрэл учруулж байна.

**Хүснэгт 2.2** Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл нь гэрээ, ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хэрэгжсэн байдал (тоо)

№	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага	Нийт арга хэмжээ	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй
1	ЦХХХЯ	5	5	-
2	ЭМЯ	2	-	2
3	БХБЯ	4	4	-
4	ХЗДХЯ	6	6	-
5	ХНХЯ	4	4	-
6	БОАЖЯ	1	1	-
7	ҮИТ	1	1	-
8	СЯ/ТАЗ	1	1	-
	Бүгд	24	22	2

**“Цахим Монгол зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний 55.8 хувь нь хугацаандаа хэрэгжээгүй байна”**

**2.69** Зорилтын хүрээнд хэрэгжих 86 арга хэмжээний явц, гүйцэтгэлийг үнэлэхэд 38 арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичигт заасан цаг хугацаанд хэрэгжсэн, харин 48 арга хэмжээ нь цаг хугацаандаа хэрэгжээгүй байна. Цаг хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээнээс хүрэх түвшин, үр дүндээ хүрсэн 3, хэрэгжиж байгаа 26, хэрэгжээгүй 19 арга хэмжээ байна. /Хавсралт 2.6-г үзнэ үү/



**2.70** Дээрх арга хэмжээнээс төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдэж батлагдаагүй 5 байгууллагын 18 арга хэмжээ байна. Үүнд:

**ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ;
- Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ;
- Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна;
- Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна;
- Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулна;
- Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх

зорилгоор иргэдэд үр чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулна;

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан албан хаагчдад мэргэжлийн үр чадвар олгох мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулна;
- Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулна.

### **ЗГХЭГ-аас ЦХХХЯ-ны чиг үүргийн хүрээнд шилжүүлсэн арга хэмжээ:**

- Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.

### **БХБЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна;
- Навигацийн хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц (GNSS)-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана;
- Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна;
- Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ;
- Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.

### **СХЗГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох.

### **ТӨБЗГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбох;
- Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно.

**2.71** Төсвийн төсөлд санал хүргүүлээгүй 4 байгууллагын 19 арга хэмжээ байна. Үүнд:

### **ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Монгол Улсын хэмжээнд тоон гарын үсгийн тоо, хэрэглээний төрөл нэмэгдэж байгаа ч нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажил хийгдээгүйн улмаас үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж, олон улсын жагсаалтад оруулах боломжгүй байна. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 дугаар албан бичгээр 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг хүргүүлсэн боловч төсвийг батлаагүй байна.
- Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгоно;
- Шуудан, ложистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулна;
- Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна;
- Харилцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, барилга байгууламж зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө;
- Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулна;
- Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ;
- Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно;
- Инновац, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний институтийг бэхжүүлнэ.

### **ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ;
- Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна.

### **ЗГХЭГ-аас ЦХХХЯ-ны чиг үүргийн хүрээнд шилжүүлсэн арга хэмжээ:**

- Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр,



контент боловсруулж, түгээнэ;

- Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн шийдвэр гаргалтад иргэдээс санал авах цахим хэлэлцүүлгийн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ;
- Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.

#### **ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болох” арга хэмжээний хүрээнд МУЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” 180 дугаар тогтоолыг баталж, уг ажлыг эрчимжүүлж ажиллахыг БХБЯ, ЦХХХЯ, УБЕГ болон ГЗБГЗЗГ-т даалгасан. Хэдийгээр Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021, 2022, 2023 оны нийт төсөв 49.3 тэрбум төгрөгөөр тусгагдсан ч одоо ашиглагдаж буй УБЕГ-ын газар эзэмших, ашиглах дундын системд хаягийн мэдээлэл оруулж байгаа тул улсын төсвийн төсөлд санал хүргүүлээгүй байна.
- “Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглах” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021, 2022, 2023 оны нийт төсөв 0.1 тэрбум төгрөгөөр тусгагдсан ч УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS-2/-ийн хөгжүүлэлтийг хийсэн “Ай Ти Зон” ХХК болон УБЕГ-ын Мэдээлэл технологийн газартай хамтран уг системд онлайн мэдүүлэг цэсийг шинээр нэмж, нэмэлт хөгжүүлэлт хийх замаар шийдвэрлэсэн тул төсвийн төсөлд санал өгөөгүй байна.

**2.72** Төсөл, арга хэмжээний 2023 оны хүрэх түвшинд төлөвлөгдсөн хөрөнгийн хэмжээгээр санхүүжилтээ бүрэн авч чадаагүй дараах арга хэмжээ байна. Үүнд:

#### **ЦХХХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.

#### **ШСАА/МХЕГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд

суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэнэ.

#### **ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Цахим архив албан хэрэг хөтөлөлт” хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд Архивын Ерөнхий газар нь 3 систем хөгжүүлэхээс 1 систем нь цаг хугацаандаа хэрэгжээгүй байна. Үүнд:
  - » 2022 оны 05 дугаар сарын 03-наас 06 дугаар сарын 03-ны хооронд хөгжлийн баримт бичигт заасан хугацаанд <https://e-archives.gov.mn> системийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.
  - » Мөн адил заасан хугацаанд 2021 оны 05 дугаар сарын 07-ноос 08 дугаар сарын 01-ний хооронд цахим архивын нэгдсэн бааз үүсгэх <https://e-documents.gov.mn> системийг нэвтрүүлсэн.
  - » Архивын цахим лавлагаа, архивын нэгдсэн сангийн систем хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байгаа боловч хүний нөөцийн дутмаг байдлаас шалтгаалж удирдлагын хяналтын нэгдсэн системийг цаг хугацаанд нь нэвтрүүлж чадаагүй байна.
- “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл” арга хэмжээнд “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2020 онд авах зээлийн тухай МУЗГ, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хоорондын Ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд Сангийн яам, БНСУ-ын Экзим Банктай 19.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Гэтэл уг арга хэмжээний төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн тушаалаар байгуулсан нь Зээлийн гэрээг байгуулснаас 3 жилийн дараа үндсэн үйл ажиллагаа эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл, уг зээлийн гэрээ<sup>9</sup>-нд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 25 сарын дотор төсөл хэрэгжиж дуусахаар заасан боловч төсөл хугацаандаа хэрэгжиж эхлээгүй нь үргүй зардлыг бий болгож, их хэмжээний хөрөнгө оруулалтыг үр дүнтэй, ашигтай шингээх чадавхыг хязгаарлаж байна.

#### **2.73** Худалдан авах ажиллагааны 20 арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон

<sup>9</sup> “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийн Сангийн яам, БНСУ-ын Экзим Банктай байгуулсан зээлийн гэрээний 2.02.(b)-д “Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 31 сарын дотор хамгийн сүүлийн зарцуулалт хийгдэх бөгөөд Банк, Зээлдэгч хооронд өөрөөр тохироогүй бол түүнээс хойш банк аливаа зээлийн зарцуулалт хийхгүй”, Зээлийн гэрээний Хуваарь 1-ийн 4-т “Төсөл нь Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 25 сарын дотор хэрэгжиж дуусна” гэж тус тус тусгасан.

бол дараах арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. Үүнд:

- “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах” арга хэмжээний хүрээнд хэрэгжсэн “ХНУМТ” системийг 2017 оноос хөгжүүлж эхэлсэн. Төслийн гүйцэтгэгч “ЗИОН” ХХК-тай 78.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй буюу гэрээ байгуулсны дараах өдөр гүйцэтгэгчид гэрээний үнийн дүнгээр санхүүжилтийг 100 хувь олгосон нь Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмыг зөрчсөн байна.



- “Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх” арга хэмжээний төслийн гүйцэтгэгч “Тайхан электрик вайрэр” ХХК (“Тайхан Кабель Солюшн” ХХК-ийн нэр солигдсон)-тай байгуулсан гэрээт ажлын 2 дахь санхүүжилтийг Дэлхийн банкны төслийн удирдагч мэдээлэл технологийн аудитын дүн гарах хүртэл төлбөрийн зөвшөөрлийг түдгэлзүүлэхийг мэдэгдсэн боловч ЭМЯ, төслийн нэгжээс 2 дахь төлбөр болох 1.2 сая ам.долларын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлийг тодруулалгүй шууд шилжүүлсэн.
- “Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар уг төслийн нэрээр хуваарилсан 2.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, мөн программ хангамжийг гэрээнд зааснаас зөрүүтэй байхад төлбөрийг шилжүүлсэн.


**2.74** “Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах” арга хэмжээний хүрээнд Хэнтий



**Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд мөрдөж буй нийтлэг дүрэм, журам**



Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан **“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”**





Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”



Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”

аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын зураг, магадлалын нэгдсэн дүгнэлтэд халаалтын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлэх ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулсан, барилгын ажилчдын жишиг тариф болон барилгын материалын үнийн өсөлт зэргийг урьдчилан тооцоолоогүйгээс барилгын ажлын төсөвт өртөг нэмэгдэж, Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 7 дугаар сард гарсан дүгнэлтэд үндэслэн батлагдсан төсөвт өртөг болох 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлуулсан байна.

## Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна


“Арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо хангалтгүй ажиллаж байна”

2.75 “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй ажиллахгүй байгаа нь төсөл, арга хэмжээ хангалтгүй хэрэгжихэд хүргэж байна. Тухайлбал,

**Төрийн албаны зөвлөлийн хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

2.76 “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах” арга хэмжээний хүрээнд ХНУМТ системийг хөгжүүлэх, ашиглах, уг системийн мэдээллийн сангийн аюулгүй байдал, хамгаалалт зэрэгт тавигдаж буй дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй байгааг дараах зөрчил, дутагдал харуулж байна. Үүнд:

- Зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө цаашид бий болох үр өгөөж, үр ашгийг урьдчилан тооцож, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгө, хүний нөөц зэргийг холбогдох судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үйл ажиллагаа сул;
- Системийг нэвтрүүлснээс хойш мэдээллийн аюулгүй байдал болон өгөгдлийн санд байршиж байгаа мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавиагүй, системд нэвтэрсэн хэрэглэгчийн бүртгэл хийгдээгүй, нэг эрхээр олон хэрэглэгч зэрэг нэвтрэх, хяналт шалгалт хийхэд зориулсан “Аудитын лог” байхгүй, гүйцэтгэгч компанийг зөвхөн тестийн серверт хандах эрхээр хязгаарлаагүй;



- Систем ашиглах бүх түвшинд танилт нэвтрэлтийн системийг нэвтрүүлээгүй ба системийн холболтын session time-out байхгүй;
- Тус системд хүний нөөцийн бүртгэл үүсгэхдээ нэг хүнийг олон ангилалд зэрэг бүртгэх, төрийн үйлчилгээний ажилтанд улс төрийн ангиллын нэмэгдэл оруулах, ажилласан жил болон холбогдох мэдээллийг системд дутуу оруулах, ажилд орсон тушаал болон нэмэгдэл авах шаардлага хангасан байхад нотлох баримтыг хавсаргадаггүй.

**ХЗДХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.77** МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу арга хэмжээний хэрэгжилтэд хагас болон бүтэн жилийн хугацаанд хяналт тавьж байгаа боловч гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна. Үүнд:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно;
- Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана;
- “Ухаалаг эмнэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд Төрийн тусгай албан хаагчийн эмнэлгийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/42 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг батлуулан ажиллаж байгаа

боловч уг журмын 2.5.1-д “Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг хийнэ” гэсний дагуу холбогдох шалгалтыг зохион байгуулаагүй байна.

- “Цахим архив албан хэрэг хөтлөлт хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд ХЗДХЯ-ны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалаар 2023-2027 онд “Цахим архив албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг даалгасан. Тус чиглэлийн 7.1-д архив, албан хэрэг хөтлөлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр аудит хийхээр заасан боловч энэ ажил огт хэрэгжээгүй байна.

**2.78** Тавигдаж буй хяналт нь зөвхөн бодлогын хэрэгжилтийн түвшинд авч үзсэн байх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хязгаарлагдаж байна. Зорилтот арга хэмжээний гүйцэтгэл, зохион байгуулсан худалдан авах ажиллагаа, гарсан үр дүн, үр өгөөж зэрэгт дотоод аудит хийгддэггүй байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ;
- УБЕГ, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна;
- Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл хэрэгжүүлнэ.

**ХНХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

**2.79** Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй нь МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж ажиллаагүй байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлэх;
- Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Үйлчлүүлэгч төвтэй аргачлал”-ыг нэвтрүүлж, цахимжуулах;
- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулах.

**ШСАА/МХЕГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэх” арга хэмжээний хүрээнд МУЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгах шийдвэр гарснаас шалтгаалан дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг хариуцах эзэнгүй болсон байна.

**ҮИТ-ийн хариуцсан арга хэмжээний хүрээнд:**

- “Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болох” арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

**ЭМЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:**


- “Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх”, “Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээг хэрэгжих хугацаанд Эрүүл мэндийн сайд 5, ТНБД 7, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга 5, Төслийн удирдах хороо 6, Төслийн захирал 7, Төслийн зохицуулагч 3 удаа тус тус өөрчлөгдөж байсан нь төсөл эхлэхээс дуусах хүртэл хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг үнэлэх ажил хийгдэхгүй байх, дотоод хяналтын тогтолцооны үйлчлэл, удирдлагын хүлээх хариуцлагыг орхигдуулахад хүргэсэн байна.
- “Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлэх” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн хөгжлийн төв телемедициний талаарх асуудлыг хариуцаж байсан боловч ЭМС-ын 2021 оны А/26 дугаар тушаалаар энэхүү чиг үүргийг өөрчлөн зохион байгуулснаар хариуцах эзэнгүй болсон байна.
- “Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлэх” арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн явц, үр дүнг тодорхойлж шийдвэр гаргадаггүй, удирдлагын тодорхойгүй шийдвэрээс шалтгаалж хэрэгжилт удааширч, үзлэгийн цаг товлох үйлчилгээний нэвтрүүлэлтийн үр дүн хангалтгүй болоход хүргэжээ.
- “Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв

байгуулах” арга хэмжээний хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 2/542, 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 4/364 дугаар албан бичгээр тус төвийг байгуулах зөвлөмжийг ЭМЯ-нд хүргүүлж байсан боловч МУЗГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолоор “И-Монгол академи” УТҮГ-ыг байгуулснаар энэ асуудлыг хариуцан хэрэгжүүлэхээр болсон гэх боловч одоогоор хэрэгжээгүй байна.

- “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх” арга хэмжээний хүрээнд мобайл тусламж, үйлчилгээний тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл хөтлөхгүй байгаа нь мобайл тусламж, үйлчилгээний үр нөлөө, хүрэх үр дүн, нөөцийн судалгааны мэдээллийг олж авах, танилцах боломжгүйд хүргэж байна.

**2.80** Цахим шилжилтийн хүрээнд төрийн байгууллагууд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нөөцийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байгаад болон төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд дотоод хяналтыг иж бүрэн хийхгүй байна.

**2.81** “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 86 арга хэмжээнээс 45 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч зөвлөмж өгөөгүй, 7 арга хэмжээнд зөвлөмж өгсөн, 34 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.



**2.82** ЦХХХЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн дараах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгох;
- Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулах;
- Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв байгуулах.

#### ШСАА/МХЕГ-ын хариуцсан ажлын хүрээнд:

“Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэх” арга хэмжээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хариуцаж байсан боловч МУЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор тус газар татан буугдсанаар арга хэмжээний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил хийгдээгүй орхигдсон байна.

#### ЗГХЭГ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:

- ЗГХЭГ-аас ЦХХХЯ-ны чиг үүрэгт хамаарах 15 арга хэмжээг шилжүүлсэн бөгөөд үүнээс 14 арга хэмжээ нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын хариуцсан хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим санд бүртгэгдээгүйгээс гадна “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

#### ХНХЯ-ны хариуцсан арга хэмжээний хүрээнд:

**2.83** Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байгаа боловч 4 арга хэмжээнд тухайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаагүй байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлэх;
- Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Үйлчлүүлэгч төвтэй аргачлал”-ыг нэвтрүүлж, цахимжуулах;
- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах

хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулах.

**2.84** Төсөл, арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлж, хэрэгжихгүй байгаа шалтгааныг үнэлж дүгнэх арга хэмжээ авч ажиллаагүй байна. Үүнд:

#### ХЗДХЯ-ын хариуцсан арга хэмжээний хүрээнд:


- Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана;
- Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл;
- Цахим архив албан хэрэг хөтлөлт хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ;
- Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлнэ;
- Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэрийн бүтцийг УБЕГ-т байгуулан үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлнэ.

#### ҮИТ-ийн хариуцсан арга хэмжээний хүрээнд:

- Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болно.



**2.85** Зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй төлөвлөгөөнд тусгагдсан систем нэвтрүүлэлттэй холбоотой нийт 32 арга хэмжээнээс хяналтын горим зохистой хэрэгжиж байгаа 11 арга хэмжээ, мэдээллийн сангийн үнэн зөв, бодитой байдлын хяналт сул 2 арга хэмжээ байна. Үүнд:




**ШСАА/МХЕГ-ын хариуцсан ажлын хүрээнд:**

- “Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд, байгууллагуудад цахимаар хүргэх” арга хэмжээний хүрээнд “Бодь-Электроникс” ХХК-ийн хөгжүүлсэн хяналт удирдлагын нэгдсэн систем буюу [www.e-khyanalт.mn](http://www.e-khyanalт.mn)-ийн гэрээ, системийг хүлээж авсан акт, гүйцэтгэл, үр дүнгийн тайлан мэдээлэл ЦХХХЯ-нд байхгүй, ШСАА нь энэ талаар хүчин чармайлт гаргаж ажиллаагүй байна.

**2.86** “Цахим Монгол” зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилтот арга хэмжээний хэрэгжилт, түүний явц, гүйцэтгэлийн үр дүнд арга хэмжээг хариуцан ажиллаж байгаа төрийн байгууллагуудын дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ төдийлөн үр нөлөөтэй байж чадахгүй байгаагийн зэрэгцээ зарим арга хэмжээний хэрэгжилтийг хамруулаагүй байна.

**2.87** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь МУЗГ-ын 2022 оны 474 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан дүрмийн 1.3-г<sup>10</sup> заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

**2.88** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас чиг үүргийн дагуу цахим шилжилтийн үед төрийн байгууллагуудын хариуцан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, арга хэмжээний явцыг хянаж, үнэлэх замаар хариуцагч байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг хэмжиж тодорхойлоогүйгээс төрийн үйлчилгээний хүртээмжтэй, ил тод байдлын зорилт хангалтгүй хэрэгжиж байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

<sup>10</sup> Засгийн газрын 474 дүгээр тогтоол

- ☞ **1.3.1.** яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан (цаашид “байгууллага, албан тушаалтан” гэх), улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, захирамж, хуралдааны тэмдэглэл (цаашид “хууль тогтоомж, бодлого, шийдвэр” гэх)-ийг болон албаны чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох хуульд заасны дагуу хяналт тавих, байгууллагын дотоод хяналтын нэгж, ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- ☞ **1.3.2.** байгууллага, албан тушаалтны хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах;
- ☞ **1.3.3.** Засгийн газрын харьяа байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн сэтгэл ханамж, авлига, хүнд суртлын индекс, олон нийтийн санаа бодол, өргөдөл, гомдлын шинж байдал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд тандалт судалгаа хийх, дүн шинжлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- ☞ **1.3.4.** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах.



## ДҮГНЭЛТ

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан цахим шилжилтийг дэмжих арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд тавигдах удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна.**

- “Цахим Монгол” зорилтын хүрээнд төрийн байгууллагууд дэвшүүлсэн үйл ажиллагаа, зорилт, арга хэмжээг үр нөлөөтэй арга хандлагад суурилан төлөвлөөгүй, удирдлага, зохион байгуулалт, түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх цогц бодлогын шийдэл гаргаж ажиллахгүй байна.
- “Цахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бодит тооцоо судалгаанд үндэслэж боловсруулаагүй, хөрөнгө санхүүжилтийн удирдлагыг зохистой хэрэгжүүлэхгүй байгаагаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
- “Цахим Монгол” зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүүгийн нөөц нэн чухал юм. Зорилтын хэрэгжилтэд шууд нөлөө үзүүлэх хөрөнгө, санхүүгийн нөөцийн хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй, бодитой тооцоолох, эх үүсвэрийг оновчтой сонгох, арвилан хэмнэлттэй зарцуулах зэрэг асуудлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлагаар хангах ажиллагаа дутагдалтай байна.
- Мэдээллийн технологийн салбарт шаардлагатай хөрөнгө, санхүүгийн нөөцийн хэмжээ, тэдгээрийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр төлөвлөсөн байдал, хэрэгжилт гүйцэтгэлийн талаар нэгтгэсэн мэдээлэл ЦХХХЯ-д байхгүй

байна. Тухайлбал, Сангийн яаманд мэдээллийн технологийн салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл иж бүрэн бус байна.

**Төрийн байгууллагуудын МХХТ-ийн чиглэлээр хариуцан хэрэгжүүлж буй арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, зохион байгуулалт, тэдгээрт тавигдах хяналт хууль, журмын дагуу хийгдэхгүй байна.**

- Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийг томилсон тушаалд хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилсон заалтыг тусгаагүй байна.
- Мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо болон гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн гишүүдийг салбарын мэдлэг, үр чадвар, туршлага зэргийг харгалзан үзэлгүйгээр бүрдүүлдэг нь төсөл, арга хэмжээг цаг хугацаандаа амжилттай хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАтХ-ийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахгүй шууд гэрээ байгуулж байгаа нь шударга өрсөлдөөн, тэгш боломжийг хязгаарлаж улмаар төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах нөхцөлийг бий болгож байна.
- ТБОНӨХБАҮХАтХ-ийн 3.4-т хамаарах бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мөрдөх тусгайлсан зохицуулалт байхгүй байна.



- Мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хүрээнд программ, систем шинээр үүсгэх, хөгжүүлэх ажлын даалгаврыг үндэслэлтэй боловсруулаагүй, гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцөл, хамрах хүрээ, хийх ажлыг оновчтой тодорхойлоогүйгээс гэрээний хэрэгжилт хангагдахгүй байх, улмаар төсөл, арга хэмжээ үр дүнгүй болоход хүргэж байна.
- Мэдээллийн технологийн сервер, тоног төхөөрөмжийн элэгдэл, худалдан авалт, мэдээллийн системийн лиценз, засвар үйлчилгээ, шинэчлэл, сайжруулалтын зардал зэрэг дэд бүтцийн байнга гардаг зардлыг тогтмол зардал оруулан төлөвлөж, зарцуулах нь зохимжтой байна. Эдгээр зардлыг олон янзаар төлөвлөж байгаа нь зарим тохиолдолд санхүүгийн нөөцийн хомсдол, үр ашиггүй зардал гарах, улмаар мэдээллийн технологийн бодлого, стратегийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.
- Монгол хэлний тухай хууль, Төрийн албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг баримталж төрийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийг монгол хэл дээр хөтлөн явуулаагүйгээс төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилт, үр дүнд хяналт тавихад хүндрэл учруулж байна.

#### **“Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явц удаашралтай байна**

- “Цахим Монгол” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн систем, программ шинээр үүсгэж, хөгжүүлж байгаа нь төрийн үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гарч улмаар иргэд, олон нийт, үйлчлүүлэгчид цаг хугацаа, хөрөнгө нөөцөө хэмнэх боломжийг олгосон байна.
- “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь тооцоо судалгаанд үндэслэн хүрэх түвшнийг тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой тодорхойлоогүйгээс төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрэх үр дүн, үр өгөөжийг тооцоход хүндрэл учруулж байна.
- Төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд улсын болон орон нутгийн төсөв, боломжит гаднын болон дотоод эх үүсвэрүүдийг ашиглан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх санал хүргүүлж байгаа боловч шийдвэрлэгдээгүйгээс төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.
- Систем, программ хангамжийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон гэрээг боловсруулах, байгуулахдаа хариуцлагагүй ханддаг, программ хангамж, систем хоорондын уялдаа хангагдаагүй зэрэг шалтгааны улмаас төсвийн үр ашиггүй зарцуулалт нэмэгдэх,

тухайлбал, дахин шинээр систем, программ үүсгэх, хөгжүүлэх, нэгэнт ашиглаж буй программыг хэрэглээндээ бүрэн нэвтрүүлэх боломжгүйд хүрэх, энэ нь улмаар төрийн албан хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Түүнчлэн, иргэд, олон нийт төрийн үйлчилгээг удаашралтай авах нөхцөлийг бий болгож байна.

- Системийн ажлын даалгаврыг хангалтгүй боловсруулснаас үүдэн нэмэлт ажлыг гүйцэтгүүлснээр гэрээний хугацаа сунгагдах, төлөвлөсөн хугацаанд системийг нэвтрүүлж, ашиглаж чадахгүйд хүрч байна.
- Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, гэрээ дүгнэх акт үйлдээгүйгээс гүйцэтгэсэн ажил нь үр дүнгүй болж улсын төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулалтыг бий болгож байна.
- Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажил хийгдээгүй, хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулаагүйгээс үндэсний тоон гарын үсгийг хэрэглээг нэмэгдүүлэх боломжгүйд хүрч, цахим шилжилтэд бүрэн шилжих суурь бүтэц бүрдэж чадаагүй байна.

#### **“Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна”**

- Зорилтот арга хэмжээний хүрээнд ашиглаж буй программ, системд “Аудитын лог” үүсгээгүй, систем хөгжүүлэлтийг хариуцан гүйцэтгэж буй компанийг зөвхөн төсвийн серверт хандах эрхээр хязгаарлаагүй, онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө байхгүй, системийн аюулгүй ажиллагааг тогтмол хянах тогтолцоо бүрдээгүй байна.
- Удирдлагын алдаатай шийдвэр, албан хаагчийн хариуцлагагүй байдал, учирч болох эрсдэлийг тодорхойлж үнэлэхгүй байгаа зэрэг нь дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.
- “Цахим монгол” зорилтын арга хэмжээг төлөвлөх явцад хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой тодорхойлоогүйгээс хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийхэд хүндрэл учруулж байна.
- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд үүсэж болох эрсдэлийг удирдах, хэрэгжилтийн үр нөлөөт байдалд баталгаа өгөх чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа бүрэн төлөвшөөгүй нь төсөл, арга хэмжээ үр нөлөөгүй болоход хүргэж байна.

**Хавсралт 2.1**

“Цахим Монгол” зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний нийцэл (тоо)

№	Асуудлын шинжилгээ	Хариулт	Хариултын тоо
1	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь бодлогын зорилтод чиглэсэн эсэх	Чиглэсэн	84
		Чиглээгүй	2
2	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй зорилтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, эх үүсвэрийг оновчтой, тооцоо судалгаанд үндэслэж, холбогдох хуулийн шаардлагыг ханган төлөвлөсөн эсэх	Төлөвлөсөн төсөв таарч байна	8
		Төлөвлөсөн төсөв хэтэрсэн байна	3
		Төлөвлөсөн төсөв буурсан байна	15
		Төсвийн төсөлд санал өгсөн боловч батлагдаагүй	26
		Төсвийн төсөлд санал өгөөгүй	26
3	Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл нь хөгжлийн бодлогын баримт бичигт заасан цаг хугацаанд хэрэгжсэн эсэх	Хэрэгжсэн	38
		Хэрэгжээгүй	48
4	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, арга хэмжээ авсан эсэх	Хяналт шинжилгээ хийсэн	45
		Хяналт шинжилгээ хийж, зөвлөмж өгсөн	7
		Хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй	34
5	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэмэлт санхүүжилт үндэслэлтэй эсэх	Нэмэлт санхүүжилт авсан нь үндэслэлтэй	1
		Нэмэлт санхүүжилт авсан нь үндэслэлгүй	0
6	Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн үнэн зөв, бодитой байдалд хяналт тавьж байгаа эсэх	Хяналт тавьдаг	19
		Хяналт тодорхой хэмжээнд тавьдаг	2
		Хяналт тавьдаггүй	11
		Системгүй арга хэмжээ	54
7	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд тавих дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх	Үр нөлөөтэй	58
		Үр нөлөөгүй	28
<b>Нийт арга хэмжээ</b>			<b>86</b>
8	Зорилтын хүрээнд шаардагдах бараа, ажил, үйлчилгээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг оновчтой, үндэслэлтэй боловсруулсан эсэх	Оновчтой үндэслэлтэй боловсруулсан	22
		Хангалтгүй боловсруулсан	2
9	Бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг нээлттэй ил тод, арвилан хэмнэлттэй зохион байгуулсан эсэх	Нээлттэй ил тод, арвилан хэмнэлттэй зохион байгуулсан	20
		Нээлттэй, ил тод, арвилан хэмнэлттэй зохион байгуулаагүй	4
10	Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх	Хууль, журмын дагуу зохион байгуулсан	18
		Хууль, журмын дагуу зохион байгуулаагүй	2
		Зарим талаараа хууль, журмын дагуу зохион байгуулаагүй	4
11	Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээтэй нийцэж байгаа эсэх	Нийцсэн	22
		Нийцээгүй	2
12	Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл нь гэрээ, ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хэрэгжиж байгаа эсэх	Хэрэгжсэн	22
		Хэрэгжээгүй	2
13	Хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэх	Гүйцэтгэлд үндэслэн олгосон	20
		Гүйцэтгэлд үндэслэн олгоогүй	4
<b>Нийт арга хэмжээ</b>			<b>24</b>

**Хавсралт 2.2** “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээлэл сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагууд	Нийт худалдан авах ажиллагаа		Нээлттэй тендер шалгаруулалтын журам		Тендер шалгаруулах онцгой журам				Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам		Олон улсын байгууллагын зээл		Нийт худалдан авалт		Судалгаа бөглөөгүй худалдан авалт			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хязгаарлагдмал	Харьцуулалт	Гэрээ шууд байгуулах	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	ЦХХХЯ	14	21,304.7	13	21,282.2	-	1	22.5	-	-	-	-	-	14	21,304.7	28	26,307.0		
2	БХБЯ	7	1,239.9	-	-	1	977.8	3	172.1	2	40.0	1	50.0	-	1,239.9	5	253.0		
3	ХЗДХЯ	28	12,288.3	9	8,375.3	-	2	47.9	15	2,590.5	2	1,274.6	3	1,479.6	31	13,767.8	-		
4	ХНХЯ	10	3,517.8	6	3,291.1	-	2	63.1	-	-	2	163.6	26	6,740.7	36	10,258.5	-		
5	БОАЖЯ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	4	40.8	4	40.8	
6	ҮИТ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	14.8	1	14.8	
7	ТАЗ	2	919.2	-	-	-	-	-	-	-	2	919.2	-	-	2	919.2	-		
8	Сангийн яам	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	862.6	2	862.6	-		
9	ЭМЯ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	13	13,650.8	13	13,650.8	-		
10	ШСАА/МХЕГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	198.9	1	198.9	
<b>Бүгд</b>		<b>61</b>	<b>39,269.8</b>	<b>28</b>	<b>32,948.6</b>	<b>1</b>	<b>977.8</b>	<b>8</b>	<b>305.6</b>	<b>17</b>	<b>2,630.5</b>	<b>7</b>	<b>2,407.3</b>	<b>44</b>	<b>22,733.7</b>	<b>105</b>	<b>62,003.5</b>	<b>39</b>	<b>26,984.5</b>

**Хавсралт 2.3**

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн арга хэмжээний худалдан авах ажиллагаа

сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагууд	Нийт худалдан авах ажиллагаа		Барилга байгууламж		Програм хангамж		Тоног төхөөрөмж болон програм хангамж		Тоног төхөөрөмж		Бусад	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЦХХХЯ	14	21,304.7	1	6,373.7	-	-	2	3,661.9	8	9,903.8	3	1,365.3
2	БХБЯ	7	1,239.9	2	145.4	1	977.8	-	-	-	-	4	116.7
3	ХЗДХЯ	28	12,288.3	2	6,932.9	3	307.1	2	1,593.6	19	1,279.0	2	2,175.6
4	ХНХЯ	10	3,517.8	-	-	3	182.2	-	-	6	2,321.3	1	1,014.3
5	ТАЗ	2	919.2	-	-	2	919.2	-	-	-	-	-	-
Бүгд		61	39,269.8	5	13,452.0	9	2,386.2	4	5,255.6	33	13,504.1	10	4,671.9

**Хавсралт 2.4**

Олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн арга хэмжээний худалдан авах ажиллагаа сая төгрөг

№	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагууд	Нийт худалдан авах ажиллагаа		Барилга байгууламж		Програм хангамж		Тоног төхөөрөмж болон програм хангамж		Тоног төхөөрөмж		Бусад	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХЗДХЯ	3	1,479.6	1	-	1	-	-	-	1	1,479.6	-	-
2	ХНХЯ	26	6,740.7	-	-	3	1,987.4	-	-	4	3,788.6	19	964.7
3	Сангийн яам	2	862.6	-	-	-	-	-	-	1	652.3	1	210.3
4	ЭМЯ	13	13,650.8	-	-	1	5,914.7	1	6,468.6	-	-	11	1,267.5
Бүгд		44	22,733.7	1	-	5	7,902.1	1	6,468.6	6	5,920.4	31	2,442.6

**Хавсралт 2.5**  
Аудитад хамрагдаагүй худалдан авах ажиллагааны жагсаалт (төгрөг)

№	Арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага	Дугаар	Худалдан авах ажиллагааны нэр	Худалдан авах ажиллагааны төрөл	Бараа, ажил үйлчилгээний төрөл	Захиалагч	Тендер шалгаруулалт зохион байгуулагч	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ хэрэгжиж эхлэх огноо	Гэрээ хэрэгжиж дуусах огноо	Батлагдсан төсөв
1	БХБЯ	3.7.2.6	Газар зүйн нэрийн тодруулга /Дунд говь аймаг Адаацаг сум/	Шууд гэрээ байгуулсан	Бусад	Адаацаг сумын Засаг дарга	Адаацаг сумын Засаг дарга	Хануйн цав ХХК	2022	2023	12,000,000
2	БХБЯ	3.7.2.6	Газар усны нэр тодруулах /Дундговь аймаг Дэлгэрцогт сум/	Шууд гэрээ байгуулсан	Бусад	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	Хануйн цав ХХК	2022	2022	11,911,000
3	БХБЯ	3.7.2.6	Сумын газарзүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн сан байгуулах ажлын гэрээ / Дорнод аймаг Сэргэлэн сум/	Шууд гэрээ байгуулсан	Бусад	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга	Хануйн цав ХХК	2021	2021	10,000,000
4	БХБЯ	3.7.2.6	Дорноговь аймгийн зарим сумдын газар зүйн нэрийн тодруулалт хийх	Шууд гэрээ байгуулсан	Бусад	Аймгийн Засаг дарга	Аймгийн Засаг дарга	Тэгш хэм групп ХХК	2023	2023	219,087,218
5	БХБЯ	3.7.2.2	Худалдан авахын нэр нь мэдэгдэхгүй	Шууд гэрээ байгуулсан	Бусад	ГЗБГЗЗГ	Аймгийн Засаг дарга	Чандмань Сүрвэй ХХК	-	-	-
6	ЦХХХЯ	4.1.3.4	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ТЭЗУ боловруулах зөвлөх үйлчилгээ авах	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	90,000,000
7	ЦХХХЯ	4.1.3.2	Иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх	Нээлттэй тендер шалгаруулах	Програм хангамж	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	300,000,000
8	ЦХХХЯ	4.1.3.3	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлт	Нээлттэй тендер шалгаруулах	Програм хангамж	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	300,000,000
9	ЦХХХЯ	4.1.5.10	Шуудангийн хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Нээлттэй тендер шалгаруулах	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	194,932,512
10	ЦХХХЯ	4.1.3.3	Нийслэл болон хөдөө орон нутаг дахь И-Монголиа цахим системийн хэрэглээ болон сэтгэл ханамжийн судалгаа хийх	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	150,000,000
11	ЦХХХЯ	4.1.7.2	Өрхийн болон хувь хүний МХХТ-ийн хэрэглээний судалгаа хийх	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	330,000,000
12	ЦХХХЯ	4.1.7.4	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	300,000,000
13	ЦХХХЯ	4.1.3.3	И-Монголиа цахим системээр иргэд, ААН-д хүргэж байгаа цахим үйлчилгээний зориулалтаар бүлэглэн алслагдсан иргэдэд өргөн нэвтрүүлгийн сувгуудаар дамжуулан хүргэх, сурталчлан таниулах контентыг бэлтгэх	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	85,000,000
14	ЦХХХЯ	4.1.7.7	Төрийн албан хаагчдад мэдээллийн технологи ашиглах чадавхыг сайжруулах сурталтыг үе шаттайгаар зохион байгуулах	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	200,000,000

№	Арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага	Дугаар	Хүдэлдэн авах ажиллагааны нэр	Хүдэлдэн авах ажиллагааны төрөл	Барaa, ажил үйлчилгээний төрөл	Захиалагч	Тендер шалгаруулалт зохион байгуулагч	Гүйцэтгэчийн нэр	Гэрээ хэрэгжиж эхлэх огноо	Гэрээ хэрэгжиж дуусах огноо	Батлагдсан төсөв
15	ЦХХХЯ	4.1.7.4, 4.1.7.7	Бэлтгэсэн контентыг нэвтрүүлгээр иргэдэд хүргэх	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	78,000,000
16	ЦХХХЯ	4.1.7.4, 4.1.7.7	Бэлтгэгдсэн контентыг /Терийн байгууллагын үзүүлж байгаа зориулалтаар бүлэглэн иргэдэд хүргэх өргөн нэвтрүүлгийн сувгуудаар дамжуулан хүргэх	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	75,000,000
17	ЦХХХЯ	4.1.7.4	Телевизийн өргөн нэвтрүүлгээр иргэдэд хүргэх зорилгоор тусгай контент бэлтгэх	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	97,000,000
18	ЦХХХЯ	4.1.7.6	Орон нутгийн бүсчилсэн семинар зохион байгуулах	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	80,000,000
19	ЦХХХЯ	4.1.6.3, 4.1.7.4	Цахим үндэстэн, Тоон бичиг үсэгтэн, МАБ-ын хүрээнд хийгдэх хөтөлбөр боловсруулах суурь судалгаа хийх	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ХХМТГ	ХХМТГ	-	2021	2021	158,000,000
20	ЦХХХЯ	4.1.6.1, 4.1.6.5	Цахим халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах ТЗҮ боловсруулах	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	200,000,000
21	ЦХХХЯ	4.1.5.10	Шүүдэнгийн хүргэлтийн давамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	77,392,000
22	ЦХХХЯ	4.1.6.2	Терийн байгууллагуудын (улсын хэмжээнд) мэдээллийн технологийн өнөөгийн байдлын судалгаа	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	100,000,000
23	ЦХХХЯ	4.1.9.2	Мэдээлэл технологийн үндэсний паркийн цаашдын үйл ажиллагааг сайжруулах ТЗҮ боловсруулах	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	150,000,000
24	ЦХХХЯ	4.1.9.3, 4.1.7.3	Хөшгийн хөндийд Мэдээллийн технологийн HUB байгуулах ТЗҮ боловсруулах	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	250,000,000
25	ЦХХХЯ	4.1.7.4, 4.1.7.5, 4.1.7.6, 4.1.7.7	"Цахим аймаг" сэдвээр 21 аймагт сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	130,000,000
26	ЦХХХЯ	4.1.3.3	"Терийн үйлчилгээний оновчлол" судалгаа	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Бусад	ЦХХХЯ	ЦХХХЯ	-	2022	2022	150,000,000
27	ЦХХХЯ	4.1.3.1	Тоног төхөөрөмж	-	Тоног төхөөрөмж	ЗГХЭГ	Ухаалаг засаг төсөл	-	-	2021	13,618,880,000

№	Арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага	Дугаар	Хүдэлдэн авах ажиллагааны нэр	Хүдэлдэн авах ажиллагааны төрөл	Бараа, ажил үйлчилгээний төрөл	Захиалагч	Тендер шалгаруулалт зохион байгуулагч	Гүйцэтгэчийн нэр	Гэрээ хэрэгжиж эхлэх өгнөө	Гэрээ хэрэгжиж дуусах өгнөө	Батлагдсан төсөв
28	ЦХХХЯ	4.1.3.1	Тоног төхөөрөмж	-	Тоног төхөөрөмж	Сангийн яам	Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдал төсөл	-	-	2022	833,840,000
29	ЦХХХЯ	4.1.3.1	Цахим монгол платформын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн /EXADATA/	-	Тоног төхөөрөмж	ЗГХЭГ	Ухаалаг засаг төсөл	-	-	2022	2,581,050,000
30	ЦХХХЯ	4.1.3.1	Төрийн байгууллагын цахим шууданг сайжруулах аюулгүй байдлыг хангах лиценз нийлүүлэх	-	Тоног төхөөрөмж	ЗГХЭГ	Ухаалаг засаг төсөл	-	-	2022	1,762,850,000
31	ЦХХХЯ	4.1.5.11	www.zipcode.mn цахим хуудасны сайжруулалт, хөгжүүлэлт хийх зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Програм хангамж	ХХЗХ	ХХЗХ	Бодь Электроникс ХХК	2021	2022	29,979,840
32	ШСАА/МХЕГ	4.1.1.1	Шилэн хяналтын цахим системийг шинэчлэн хөгжүүлж, Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Програм хангамж	МХЕГ	МХЕГ	Бодь Электроникс ХХК	2021	2021	198,856,900
33	ЦХХХЯ	4.1.5.6	Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал дахь "ялган боловсруулах төв"-ийн барилга угсралтын ажил гүйцэтгэх	Шүүд гэрээ байгуулсан	Барилга байгууламж	Монгол Шуудан ХЗ	Монгол Шуудан ХЗ	Томо болдинг ХХК	2020	2021	3,885,089,863
34	ЦХХХЯ	4.1.9.4	Зохиогчийн эрхийн програм хангамж	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах журам	Програм хангамж	ӨӨГ	ӨӨГ	-	-	2020	100,000,000
35	ҮИТ	4.1.4.4	Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх программ хангамжтай болно	Тендер шалгаруулалтын онцгой журам	Цахим системийг боловсруулах ажил	ҮИТ	ҮИТ	Инвизибл дот ХХК	2021	2021	14,800,000
36	БОАЖЯ	3.4.8.1	Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Харилцагчийн CRM ажиллуулах	Аялал жуулчлалын төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	МОГУЛ Консалтинг Сервис ХХК	2023	2023	45,300,000
37	БОАЖЯ	3.4.8.1	Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Систем хөгжүүлэлтийн ажил	Аялал жуулчлалын төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	2023	2023	65,120,000
38	БОАЖЯ	3.4.8.1	Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	6-н хэлний орчуулгын ажил	Аялал жуулчлалын төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	2023	2023	67,800,000
39	БОАЖЯ	3.4.8.1	Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	Сайтуудтай холболт хийх ажил	Аялал жуулчлалын төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	2023	2023	32,600,000

**Хавсралт 2.6****Цаг хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээний жагсаалт**



№	Салбар	Арга хэмжээний нэр	Явц
1	БХБЯ	Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	Хэрэгжиж байгаа
2	БХБЯ	Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.	Хэрэгжиж байгаа
3	БХБЯ	Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц (GNSS)-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана.	Хэрэгжээгүй
4	БХБЯ	Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.	Хэрэгжээгүй
5	БХБЯ	Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.	Хэрэгжээгүй
6	ЗГХЭГ	Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.	Үр дүнд хүрсэн
7	ЗГХЭГ	Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, контент боловсруулж, түгээнэ.	Хэрэгжиж байгаа
8	ЗГХЭГ	Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.	Хэрэгжиж байгаа
9	ЗГХЭГ	Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн шийдвэр гаргалтад иргэдээс санал авах цахим хэлэлцүүлгийн систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.	Хэрэгжиж байгаа
10	ЗГХЭГ	Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.	Хэрэгжээгүй
11	ЗГХЭГ	Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлнэ.	Хэрэгжээгүй
12	ЗГХЭГ	"Цахим монгол" арга хэмжээний хүрээнд Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийнэ.	Хэрэгжээгүй
13	СХЭГ	Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	Хэрэгжээгүй
14	ТӨБЗГ	Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно.	Хэрэгжээгүй
15	ТӨБЗГ	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.	Хэрэгжээгүй
16	ХЗДХЯ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно.	Хэрэгжиж байгаа
17	ХЗДХЯ	Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана.	Хэрэгжиж байгаа
18	ХЗДХЯ	Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	Хэрэгжиж байгаа
19	ХЗДХЯ	Цахим архив албан хэрэг хөтлөлт хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ.	Хэрэгжиж байгаа
20	ХЗДХЯ	Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Хэрэгжиж байгаа
21	ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулна.	Хэрэгжээгүй
22	ЦХХХЯ	Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ.	Үр дүнд хүрсэн



№	Салбар	Арга хэмжээний нэр	Явц
23	ЦХХХЯ	Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлсэн цахим систем бий болгоно.	Үр дүнд хүрсэн
24	ЦХХХЯ	Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ.	Хэрэгжиж байгаа
25	ЦХХХЯ	Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.	Хэрэгжиж байгаа
26	ЦХХХЯ	Шуудан, ложистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	Хэрэгжиж байгаа
27	ЦХХХЯ	Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна.	Хэрэгжиж байгаа
28	ЦХХХЯ	Шуудангийн үндсэн сүлжээний ялган боловсруулах төв байгуулна.	Хэрэгжиж байгаа
29	ЦХХХЯ	Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна.	Хэрэгжиж байгаа
30	ЦХХХЯ	Харилцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, барилга байгууламж зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө.	Хэрэгжиж байгаа
31	ЦХХХЯ	Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна.	Хэрэгжиж байгаа
32	ЦХХХЯ	Монгол Улсын хэмжээнд интернэтийн хаягжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Хэрэгжиж байгаа
33	ЦХХХЯ	Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно.	Хэрэгжиж байгаа
34	ЦХХХЯ	Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулна.	Хэрэгжиж байгаа
35	ЦХХХЯ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан албан хаагчдад мэргэжлийн ур чадвар олгох мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулна.	Хэрэгжиж байгаа
36	ЦХХХЯ	Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулна.	Хэрэгжиж байгаа
37	ЦХХХЯ	Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулна.	Хэрэгжээгүй
38	ЦХХХЯ	Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулна.	Хэрэгжээгүй
39	ЦХХХЯ	Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.	Хэрэгжээгүй
40	ЦХХХЯ	Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулна.	Хэрэгжээгүй
41	ЦХХХЯ	Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулна.	Хэрэгжээгүй
42	ЦХХХЯ	Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний институтыг бэхжүүлнэ.	Хэрэгжээгүй
43	ШСАА/ МХЕГ	Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлдэг төрийн үйлчилгээг технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системээр дамжуулан иргэд байгууллагуудад цахимаар хүргэнэ.	Хэрэгжиж байгаа
44	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ.	Хэрэгжиж байгаа
45	ЭМЯ	Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	Хэрэгжээгүй
46	ЭМЯ	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.	Хэрэгжээгүй
47	ЭМЯ	Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна.	Хэрэгжээгүй
48	ЭМЯ	Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ.	Хэрэгжээгүй

### БҮЛЭГ 3

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүн тулгарч буй аюул, эрсдэлээс хоцорч байна



## Үндсэн мэдээлэл

Монгол улс 2022 онд Сахим хөгжил, харилцаа холбооны сайдын баталсан “Сахим Үндэстэн” 2022-2027 онд баримтлах чиглэлийн 7 дугаар зүйлд заасан гадаад хамтын ажиллагааны хүрээнд олон улсын 16 байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон бөгөөд энэ ажлын хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр ОУЦХБ-тай хамтран ажиллаж байна.

ОУЦХБ нь дэлхийн улс орнуудын кибер аюулгүй байдлын үүрэг хариуцлага, бэлэн байдлын индексийг тогтсон шалгуурын дагуу тодорхойлдог байна.

Анх 2015 онд АВИ судалгааны байгууллага болон ОУЦХБ хамтран кибер аюулгүй байдлын индексийг улс орнуудын кибер аюулгүй байдлын оролцоо, соёлыг төлөвшүүлэх, түүнийг МХХТ-ийн салбарын хөгжлийг үнэлэх бүрэлдэхүүн үзүүлэлтийн нэгээр тооцож эхэлжээ.

Улс орнууд 2015, 2017, 2018, 2021 онд кибер аюулгүй байдлын индекс тодорхойлох дараах 5 тулгуур чиглэлийн хүрээнд амлалт өгсөн байна. Үүнд:

- Хууль, эрх зүйн орчин;
- Техникийн бэлэн байдал;
- Зохион байгуулалт;
- Чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэх;
- Хамтын ажиллагаа.

Монгол улс 2015 оны байдлаар 2013, 2014 оны суурь мэдээлэлд үндэслэсэн индексийн оноогоор 1-29 зэрэглэлд жагсаахад дэлхийн 105 улс орноос 15 дахь зэрэглэлд эрэмбэлэгдсэн байна. ОУЦХБ 2017 онд Дэлхийн улс орнуудын кибер аюулгүй байдлын индексийг тулгуур 5 чиглэл, 25 шалгуур үзүүлэлтээр 157 асуумжаар тооцоход Монгол улс 164 орноос 103-т, 2018 онд 25 шалгуур үзүүлэлт, 50 асуумжаар тооцоход 175 орноос 85-д, 2021 онд 20 шалгуур үзүүлэлт, 82 асуумжаар тооцоход



195 орноос 120-д тус тус эрэмбэлэгдсэн байна. /Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд боловсруулж баталсан төрөөс баримтлах бодлого, стратегийн талаарх мэдээллийг Хавсралт 3.1-ээс үзнэ үү/

## Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа ч хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

**“Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах гол баримт бичгүүд батлагдаагүй байна”**

**3.1** УИХ-аас 2021 оны 12 дугаар сард Кибер аюулгүй байдлын тухай хуулийг баталж, 2022 оны 05 дугаар сараас мөрдөж эхэлснээр кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж хөгжүүлэх боломж бүрджээ.

**3.2** Кибер аюулгүй байдлын тухай хуулиар кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдэж, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг хуульчлан баталгаажуулжээ.

**3.3** МУЗГ 2022 онд “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”-ийг баталснаар кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хөгжил, төлөвшилд бодит хувь нэмэр болсон байна.

**3.4** Тус стратегийг цахим шилжилт, “Сахим Монгол” зорилттой уялдуулан кибер аюулгүй байдлыг хангах дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын стандарт, сайн туршлагад үндэслэн боловсруулахыг эрмэлзсэн байна. Энэ нь Монгол Улсын кибер аюулгүй байдлыг хангах гол үзүүлэлтийг бусад улс оронтой харьцуулан цаашдын чиг баримжаагаа оновчтой тодорхойлох, хөгжүүлэх боломжийг бий болгосон чухал алхам юм.

**3.5** ЦХХХЯ болон Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, цахим халдлага, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээх чиглэлээр контент бэлтгэх, уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, цахим орчинд мэдээлэл сурталчилгаагаар дамжуулан урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн гүйцэтгэж байна.

**3.6** Тухайлбал, 2023 оны 10 дугаар сард Монгол улсын кибер аюулгүй байдлын тогтолцоонд чухал үүрэгтэй төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн 79

байгууллагын 170 гаруй төлөөлөгчийг оролцуулсан “Кибер тусгаар тогтнол” хэлэлцүүлгийг зохион байгуулж, кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр 3 уриалга гаргажээ.

**3.7** Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэл солилцох үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан дараах баримт бичгүүд өнөөг хүртэл эцэслэн батлагдаагүй байна. Үүнд:

- Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэгт заасан “Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө”;
- Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан “Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”;
- Кибер аюулгүй байдлын стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллага халдлага зөрчлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам.

**“Кибер аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаа төлөвшөөгүй байна”**



**3.8** Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий орон тооны бус Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тушаалаар баталж, Зөвлөлийн дүрэм болон Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ажиллах журмыг Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тушаалаар тус тус баталсан байна.

**3.9** МУЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрмийн 3.1-д “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.” гэж заасан боловч Кибер аюулгүй байдлын зөвлөл нь өнөөг хүртэл нэг ч удаа хуралдаагүй, албан ёсоор асуудал шийдвэрлээгүй байна.

**3.10** Тус зөвлөлийн хийх ёстой кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, уялдуулан зохицуулахтай холбоотой тулгамдсан асуудлууд хүлээгдэж байна.

**3.11** Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах ажил төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа нь шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлээгүй, санхүүгийн эх үүсвэр дутагдаж байгаатай холбоотой байна.

**3.12** Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг судлах явцад хуулийн зүйл заалтад тусгагдсан байгаа журмын нэр болон захиргааны хэм хэмжээний актын нэр зөрүүтэй тохиолдлууд байна. Энэ нь хууль эрх зүйн актыг нэгдсэн байдлаар ойлгож, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, үнэлэх үйл явцад хүндрэл учруулахаас гадна тэдгээрийн хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

**Хүснэгт 3.1** Хуулийн зүйл заалт болон захиргааны хэм хэмжээний актын нэр зөрүүтэй журам

№	Хуулийн нэр	Зүйл, заалт	Батлах байгууллага	Журмын батлагдвал зохих нэр	Дугаар	Батлагдсан огноо	Журмын батлагдсан нэр
1	Кибер аюулгүй байдлын тухай	7.1.Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журмыг Засгийн газар батална.	Засгийн газар	Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам	224	2023.06.07	Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам
2	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай	23.3.Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Мэдээлэл хариуцагч хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад үнэлгээ хийх аргачлал, журам	А/81	2023.09.01	Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам

**“Кибер аюулгүй байдлын талаар баримталж буй хууль тогтоомж, бодлого, стратеги, дүрэм, журмын хэрэгжилт хангалтгүй байна”**

**3.13** Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор “Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа”, “Эрсдэлийн удирдлага”, “Мэдээлэл технологийн үйлчилгээний удирдлага” гэсэн 3 бүлэг асуудлын хүрээнд 9 байгууллагыг судалгаанд хамруулсан. Улсын хэмжээнд мэдээлэл технологи, харилцаа холбоо, сансар, өргөн нэвтрүүлэг, шуудан, кибер аюулгүй байдлыг хамгаалах бодлого, зохицуулалтын асуудлыг эрхэлсэн ЦХХХЯ, улсын хэмжээнд мэдээллийн дэд бүтцийг хариуцах Үндэсний дата төв УТҮГ, 21 аймаг, 336 сум, сууринг хамарсан шилэн кабель, сүлжээний дэд бүтэц хариуцах Мэдээллийн холбоо сүлжээ ТӨХК, төрийн захиргааны төв байгууллага болох БХБЯ, ХНХЯ, ЭЗХЯ, ЭМЯ, Сангийн яам, БШУЯ тус тус хамрагдсан. Үүнд:

- Түүвэрт хамрагдсан 9 байгууллагын эрсдэлийн нөлөөлөл, тохиолдох магадлалыг 13 бүлэглэж, эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн. /Хавсралт 3.2-ыг үзнэ үү/
- Түүвэрт хамрагдсан 6 байгууллагыг 3 бүлэгт хамаарах 28 асуумжийн хүрээнд үнэлгээг хийсэн. /Хавсралт 3.3-ыг үзнэ үү/

**3.14** Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын дагуу шалгагдагч байгууллагууд кибер аюулгүй байдлын дотоод журмыг шинэчлэн, боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагууд уг дотоод журмыг боловсруулж, мөрдөөгүй байна. Энэ нь кибер аюулгүй байдлын асуудал хариуцсан

\* 2014 онд Олон улсын аудитын дээд байгууллагуудын (INTOSAI) мэдээллийн технологийн аудитын ажлын хэсэг (WGITA) болон хөгжлийн санаачилга (IDI) хамтран аудитын дээд байгууллагын аудиторудад мэдээллийн технологийн аудитыг гүйцэтгэх нэгдсэн стандарт, сайн туршлагыг түгээх зорилгоор нийтлүүлсэн удирдамжийн шалгуур матрицаас түүвэрлэн, судалгааны асуудлыг боловсруулав.

яам, зөвлөлийн баталсан бодлого, журмын талаарх мэдээллийг танин мэдүүлэх, уялдуулан зохицуулах, зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах үүргээ хангалтгүй биелүүлж байгаатай холбоотой байна.

**3.15** Судалгааны дүнгээс үзэхэд түүвэрт хамрагдсан байгууллагуудаас мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтний батлагдсан орон тоотой 2 байгууллага байгаа боловч ажлын байрны сул орон тоог нөхөөгүй, үлдсэн 4 байгууллагын хувьд албан ёсны батлагдсан орон тоо байхгүй, хавсран гүйцэтгэж байна. Энэ нь мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд нэн тулгамдсан асуудал бөгөөд кибер аюулгүй байдлын чиглэлээр нарийн мэргэшсэн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалж байна.

**3.16** Албан ёсны эрхтэй аюулгүй байдлын төхөөрөмж, программ хангамж ашиглаж кибер аюулгүй байдлын халдлага, зөрчлийг илрүүлж байгаа боловч, тэдгээрийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах, баримтжуулах, урьдчилан сэргийлэх, танин мэдүүлэх тогтолцоо төлөвшөөгүйн улмаас кибер аюулгүй байдлыг хангах нөхцөл байдлыг бодитой тодорхойлох, цаашид авах арга хэмжээг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

**3.17** Түүвэрт хамрагдсан байгууллагын нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой чиг үүрэг, үйл ажиллагааг хангалттай тусгаагүй байна. Энэ нь кибер аюулгүй байдлыг хангах талаарх удирдлагын ойлголт, мэдээлэл дутмаг, зохион байгуулалт сул байгааг харуулж байгаа бөгөөд кибер халдлагад өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

**3.18** Түүвэрт хамрагдсан байгууллагууд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, эрсдэлийн удирдлагын

журам, эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн гадаад, дотоод болон болзошгүй гэмтэл, саатлын нөлөөллийн шинжилгээ зэрэг эрсдэлийн удирдлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй байна.

**3.19** Мэдээлэл технологийн чиглэлийн ажлыг бусдаар гүйцэтгүүлэхдээ төрийн болон албаны нууцтай холбоотой асуудлыг гэрээгээр зохицуулж байгаа тохиолдолд гэрээний хэрэгжилт, явцын хяналт бүрхэг, тэдгээрийн бүртгэл, баталгаажуулалтын мэдээлэл хангалтгүй байна.

### **Суурь дэд бүтцийн хөгжүүлэлтийг найдвартай судалгаа мэдээлэлд тулгуурлан нэгдсэн бодлого, чиглэлээр удирдан зохицуулах ажиллагаа хангалтгүй байна**

**3.20** Цахим үндэстэн болох, цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, Монгол улсын хүн ам, нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан, сүлжээний найдвартай, чанартай, хүртээмжтэй, дэвшилтэт технологийн үйлчилгээг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх;
- Хүн ам суурьшсан төв суурин газар, аялал жуулчлалын бүс нутаг, А зэрэглэлийн зам дагуу болон боомтуудад харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах;
- Интернэтийн дижитал дэд бүтцийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжих интернэтийн чанар болон нээлттэй байдлыг сайжруулах;
- Гамшгийн болон онцгой байдлын үеийн холбооны сүлжээ зохион байгуулах төлөвлөгөөг тодорхойлж, шаардлагатай өргөтгөл хийх;
- Өргөн нэвтрүүлэг, шуудангийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Үндэсний дата төвийн найдвартай ажиллагаа, багтаамжийг нэмэгдүүлэх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээ.

**3.21** Техник хангамжийг үүлэн дэд бүтцийн хэлбэрт шилжүүлж, нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой “Төрийн үүлэн дэд бүтэц төсөл” нь хэрэгжилтийн шатандаа явж байгаа боловч төслийг

хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөөгүй байгаа нь төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих, улмаар цаашдын бодлого, чиглэлээ оновчтой тодорхойлох боломжийг хязгаарлаж байна.

**3.22** Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах нь чухал бөгөөд суурь дэд бүтцийн хөгжүүлэлтийг бодит судалгаа, мэдээлэлд тулгуурлан төлөвлөх, гүйцэтгэлийг хянах нэгдсэн бодлого, чиглэлээр удирдан зохицуулах ажиллагаа хангалтгүй байна.

**“Технологийн боломж бүрдээгүй нөхцөлд, хангалттай тооцоо судалгаа хийлгүй шийдвэр гаргасан нь цахим шилжилт, цахим гарын үсгийн ашиглалт хангалтгүй байх нөхцөл болжээ”**

**3.23** “Цахим Монгол” зорилтын хүрээнд цахим гарын үсэгтэй холбоотой 2 арга хэмжээ төлөвлөжээ. Үүнд:

- Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх;
- Үндэсний цахим гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулах.

**3.24** Түүвэрт хамрагдсан байгууллагуудад нийтлэг ашиглагдаж буй албан хэргийн систем (Able, ерр. mongolia.mn, Office 365)-д цахим гарын үсгийн ашиглалт хангалтгүй байна. Үүлэн технологид суурилсан хэрэглээний Office 365 программ хангамж ашиглан албан бичиг хэргийн хөтөлөлтийг автоматжуулсан боловч цахим гарын үсэг ашиглах боломжгүй болсон байна.

**3.25** Цахим гарын үсгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор МУЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу “И-Монгол Академи” УТУГ нь <https://docx.gov.mn/> төрийн албан бичиг солилцооны дундын систем боловсруулан хөгжүүлж байна. Гэвч хэрэгжүүлэлтийн шатанд дараах хүндрэл бэрхшээл үүссэн байна. Үүнд:

- Монгол улсын нийтийн түлхүүрийн дэд бүтцийн хувьд цагийн тамганы системийг нэгтгэж өгөөгүй нь цахим гарын үсэг зурсан цагийг ашиглаж байгаа төхөөрөмжийн цагийг солих замаар өөрчилж болохуйц байгаа нь баталгаатай байдлыг бууруулж байна;
- Цахим гарын үсэг нийлүүлэгчдийн гэрчилгээ хоорондоо уялдаа холбоогүй;
- Цахим гарын үсгийн гэрчилгээ шалгах дундын систем байхгүй;
- Цахим гарын үсгийг олгох үйл явц нь нийлүүлэгч компаниас хараат;

- Төрийн албан хаагчийн шилжилт хөдөлгөөн бүрд цахим гарын үсэг авах шаардлага бий болж, төсвийг үр ашиггүй зарцуулах нөхцөл үүссэн;
- Цахим гарын үсэгт ашиглах үндсэн технологийг нийлүүлэгч компани үйл ажиллагаагаа зогсоосон нь цаашид системийг өргөтгөх, нэмэлт хөгжүүлэлт хийх боломжгүй болсон.

**“Цахим гарын үсгийн гэрчилгээ олгож буй байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээх хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна”**

**3.26** Улсын бүртгэлийн байгууллагаас гадна цахим гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий дараах 4 байгууллага байна. Үүнд:

- Тридүм Э-Секьюрити ХХК;
- МОНПАСС СА ХХК;
- ВИ ЭС ЭМ ХХК;
- НЬЮ КОМПАСС ХХК.

**3.27** Дээрх компаниуд нь 2011 онд батлагдсан ЦГҮтХ хүчин төгөлдөр үйлчилж байх үеэс гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эзэмшиж байсан ба 2021 оны хуулийн шинэчилсэн найруулгаас хойш одоог хүртэл технологийн шинэчлэл хийлгүй үргэлжлүүлэн олгож байна.

**3.28** Шинэчилсэн ЦГҮтХ-ийн 21<sup>1</sup>, 22<sup>2</sup> дугаар зүйлүүдэд гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох бүртгэл хийх, мэдээллийг нээлттэй болгохтой холбоотой зохицуулалтуудыг хуульчилсан боловч дээр дурдсан байгууллагууд уг заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

**3.29** Мөн холбогдох бусад мэдээ, мэдээллийг байнга шинэчлэхээр заасан боловч бодит байдал дээр тус байгууллагуудын цахим хуудаст хуульд заасан мэдээллийг ил болгоогүйгээс гадна мэдээ, мэдээлэлдээ шинэчлэл хийгээгүй, иргэд, олон нийтийг мэдээллээр бүрэн хангахуйц нөхцөлийг бүрдүүлээгүй байгаа нь цахим гарын үсгийн ашиглалт хангалтгүй байгаагийн нэг шалтгаан болж байна.

**3.30** Цахим гарын үсэг, гэрчилгээ олгох байгууллагууд нь хөндлөнгийн баталгаажуулалтад

**1** Гэрчилгээжүүлэх байгууллага нь гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар хүсэлт гаргагчийн хүсэлтийг хүлээн авах, энэ хуулийн 20.2.4-т заасны дагуу холбогдох мэдээллийг шалгасан талаар бүртгэл хөтөлж, бүртгэлийг хадгална.

**2** Гэрчилгээжүүлэх байгууллага дараах мэдээллийг өөрийн цахим хуудас болон төрийн үйлчилгээний нэгдсэн системд ойлгомжтой байдлаар байршуулж, тогтмол шинэчилнэ: гэрчилгээ олгох журам, олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон гэрчилгээний дугаар

хамрагдаж байгаагүй нь цахим гарын үсгийн экосистемийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах, нөгөө талаас технологийн боломж бүрдээгүй тохиолдолд алдаатай шийдвэр, чиглэлүүдийг гаргаж байгаа нь хөрөнгө, санхүүгийн нөөцийг үр ашиггүй зарцуулах шалтгаан болжээ.

**Киберхалдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч үр дүнгүй байна**

**3.31** Кибер аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаанд кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хэрэгжилт чухал үр нөлөөтэй юм.<sup>3</sup>

**3.32** Засгийн газрын 2022 оны 13 дугаар тогтоолоор баталсан ЦХХХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.5.4.9-д зааснаар тус яам кибер аюулгүй байдлын талаар иргэд, хувийн хэвшил рүү чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах үүрэг хүлээж байна.

**3.33** ЦХХХЯ-ны дээрх үүрэг чиглэлийн хүрээнд кибер аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхийг цахим гэмт хэргийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзвэл цахим гэмт хэргийн тоо өссөн байх тул чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах үр нөлөө бүхий арга хэмжээг төлөвлөн эрчимжүүлэх шаардлагатай байна.<sup>4</sup>


**“Цахим гэмт хэргийн тоо жил дараалан өсөж байна”**

**3.34** Цагдаагийн байгууллагын мэдээллээр улсын хэмжээнд 2018-2022 онд нийт 151577 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 16579 буюу 10.9% нь цахим орчинд үйлдэгдсэн бол тэдгээрээс 2018 онд 659, 2019 онд 737, 2020 онд 1795, 2021 онд 4825, 2022 онд 8563 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.




**3** Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт  
**4** Кибер аюулгүй байдал, цахим гэмт хэргийн нөхцөл байдалтай холбоотой тайланд тусгагдсан баримт мэдээлэл Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийн эх сурвалжид тулгуурласан болно.


**3.35** 2022 оны байдлаар цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоог 2018 оны мөн үетэй харьцуулахад 13 дахин, 2020 оны мөн үетэй харьцуулбал 4.8 дахин өссөн байна.



**3.36** Бүртгэгдсэн гэмт хэргийг зүйл ангиар нь авч үзвэл нийт гэмт хэргийн 14086 буюу 89.6% нь залилах, 647 буюу 4.1% нь цахим мэдээлэлд хууль бусаар халдах, 574 буюу 3.6% нь мөрийтэй тоглоом зохион байгуулах, 421 буюу 2.7% нь худал мэдээлэл тараах төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.



**3.37** Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 78.5 тэрбум төгрөгийн хохирол учирсныг оноор нь харуулбал 2018 онд 10.0 тэрбум, 2019 онд 0.8 тэрбум, 2020 онд 16.5 тэрбум, 2021 онд 18.5 тэрбум, 2022 онд 32.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.



**3.38** Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг их хэмжээгээр өссөнөөс иргэдэд учирсан хохирол үлэмж хэмжээгээр нэмэгдэж, хохирол барагдуулалт 41.2 хувь байгаа нь гадаад, дотоод олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал:

- Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил дэвшил нь иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд эерэг өөрчлөлт бий болгохын зэрэгцээ мэдээллийн технологийн ололт амжилтыг ашиглан иргэд, аж ахуйн нэгжийн өгөгдөл, хүний хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй олж авах, залилах замаар эд хөрөнгө, нэр хүндэд нь хохирол учруулах цахим гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж байна.
- Дэлхий дахинаа кибер гэмт хэргийн улмаас 2019 онд 2.1 их наяд ам.долларын хохирол учирч байсан бол 2022 онд 6.0 их наяд ам.долларт хүрч хохирлын хэмжээ 2.8 дахин өссөн байна.

**3.39** Иргэдийн кибер аюулгүй байдал, цахим хэрэглээний боловсрол, цахим орчин дахь тодорхой төрлийн аюул занал, гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээлэл дутмаг, аюулгүй байдлын дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлдэггүй, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад байгууллага, аж ахуйн нэгжүүд төсөв, хөрөнгө төсөвлөхгүй байгаа нь цахим гэмт хэрэгт өртөх үндсэн шалтгаан болж байгааг анхааралдаа авч, энэ чиглэлээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

**3.40** Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Цахим ур чадварын үндэсний аяныг 2023-2026 оны хооронд зохион байгуулахаар эхлүүлсэн ч бодит үр дүн хараахан гараагүй байна.

**3.41** Цагдаагийн Ерөнхий газар кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр холбоотой талуудыг оролцуулсан олон удаагийн уулзалт хэлэлцүүлэг, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох, сургалт, сурталчилгааны материал бэлтгэж түгээх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч үр дүн, үр нөлөөг хэмжиж үнэлэх асуудал орхигдож байна.

**3.42** Түүнчлэн цахим халдлагад өртөх, улмаар хохирлын хэмжээ нэмэгдэж байгаа нь иргэд, төр болон хувийн хэвшлийн байгууллага, бусад оролцогч талуудын цахим ур чадвар сул байгаатай холбоотой тул соён гэгээрүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.





## ДҮГНЭЛТ

### **“Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, тэдгээрийн үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна”**

- Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдэж байгаа ч баталсан бодлого, эрх зүйн актын хэрэгжилтийг зохицуулах, хянах үүрэг бүхий бүтцийн нэгжийн ажиллагаа төлөвшөөгүйгээс тэдгээрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.
- Мэдээллийн хадгалалт, хамгаалалт, кибер аюулгүй байдлыг хангах тогтолцооны үр нөлөө хангалтгүй байгаад баталсан хууль тогтоомжийн мөрдөлт, дэд бүтцийн хөгжүүлэлт болон хөрөнгө, хүний нөөцийн дутагдал, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт нөлөөлж байна.
- Хүний нөөцийн дутагдалтай байдал нь одоо ажиллаж байгаа ажилтнуудын чиг үүргийн давхардал үүсгэн ажлын ачааллыг нэмэгдүүлэн, ажлын гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлж, улмаар үйл ажиллагаа доголдох эрсдэл бий болгож байна.
- Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах явдал нь чухал бөгөөд суурь дэд бүтцийн хөгжүүлэлтийг бодит судалгаа, мэдээлэлд тулгуурлан төлөвлөх, гүйцэтгэлийг хянах нэгдсэн бодлого, чиглэлээр удирдан зохицуулах ажиллагаа хангалтгүй байна.
- Нийтийн мэдээллийн сангийн удирдлага, тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн болон удирдлага, зохион байгуулалтын орчин төлөвшөөгүй байна.
- Төрийн байгууллагууд боловсруулж, хөгжүүлсэн программ хангамжуудаа биет бус хөрөнгийн бүртгэлд тайлагнадаггүй, нягтлан бодох бүртгэл, тайланд хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэх эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс бүртгэл, тайлагнал жигд биш байна.
- Технологийн боломж бүрдээгүй, бодит тооцоо судалгаа, мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргаагүйгээс цахим шилжилт, мэдээллийн нууцлалын гол асуудал болох цахим гарын үсэгт шилжих асуудал үр нөлөөгүй, үр дүнгүй арга хэмжээ болоход хүргэж байна.
- Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ үр дүнгүй байгаа нь хариуцсан байгууллагуудын уялдаа сул, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт дутагдаж байгаатай холбоотой байна.
- Кибер аюулгүй байдлыг хангах дүрэм, журамд заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, тэдгээрийн талаарх ойлголт, мэдээлэл дутмаг, удирдлага зохион байгуулалт сул байгаа нь холбогдох байгууллага, албан тушаалтнууд баталсан бодлого, журам, хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаарх мэдээлэл түгээх, харилцан мэдээлэл солилцох, уялдуулан зохицуулах, зохион байгуулах албан үүргээ хангалтгүй биелүүлж байгаатай холбоотой байна.
- Кибер аюулгүй байдлын зөрчил, авсан арга хэмжээний талаар бүртгэл хөтөлж, баримтжуулдаггүй нь кибер аюулгүй байдлыг хангах нөхцөл байдлыг бодитой тодорхойлох, цаашид авах арга хэмжээг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахаас гадна кибер халдлагад өртөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүдийн цахим боловсролыг дээшлүүлэх, кибер халдлага, зөрчил, цахим гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд шаардлагатай санхүүжилт төсөвлөгдөхгүй байгаа нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

**Хавсралт 3.1**

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны шалгуур болгож ашигласан эрх зүйн акт, баримт бичиг

№	Журам	Хариуцсан байгууллага	Төлөв	Тайлбар
Кибер аюулгүй байдлын тухай хууль				
1	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам, холбогдох байгууллагын жагсаалт	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлуулсан.
2	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тогтоолоор батлуулсан.
3	Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 493 дугаар тогтоолоор баталсан
4	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ажиллах журам Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн хэмжээ	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/72 дугаар тушаалаар батлуулсан.
5	Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлуулсан.
6	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төвүүдийн ажиллах журам, тавигдах шаардлага	ЦХХХЯ	Батлагдсан	МУЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор батлуулсан.
7	Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө	ТЕГ	Батлагдаагүй	Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар байгуулагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан холбогдох журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 19 дүгээрт Тагнуулын Ерөнхий газар тус төлөвлөгөөг боловсруулахаар заасан. ТЕГ-аас журмын төслийг 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн. Журмын төсөлд санал тусгаж Тагнуулын ерөнхий газартай хамтран боловсруулаад байна.
8	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам	ЦХХХЯ	Батлагдсан	"Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ыг Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас ирүүлсэн дүгнэлтэд үндэслэн дахин боловсруулж, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/74 дугаар тушаалаар баталсан.
9	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал	ЦХХХЯ, ТЕГ	Батлагдаагүй	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын төслийг NIST 800.30 баримт бичгийг баримтлан боловсруулж, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8.3-т заасны дагуу тагнуулын байгууллагатай хамтран батлах тушаалын төслийг боловсруулж, бүтцийн нэгжүүдээс саналыг авч байна.
10	Кибер аюулгүй байдлыг хангах талаарх мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам	ТЕГ, БХЯ, ЦХХХЯ	Батлагдаагүй	Кибер аюулгүй байдлын чиглэлээр мэдээлэл солилцох, хамтран ажиллах журмын төслийг Тагнуулын Ерөнхий газартай хамтран боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 61.2 дахь хэсэгт заасны дагуу яамны цахим хуудсанд байршуулж олон нийт болон холбогдох байгууллагуудаас санал авч байна.
11	Кибер аюулгүй байдлын стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	ЦХХХЯ, ТЕГ, ЗХЖШ	Батлагдаагүй	Хамтран батлах байгууллагуудаас санал авч төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Төсөлд талууд гарын үсэг зурсан.

**Хавсралт 3.2****Мэдээллийн технологийн ерөнхий хяналтын эрсдэлийн үнэлгээ**

№	Бүлэг	Илрүүлсэн нөхцөл байдал	Нөлөөлөл	Тохиолдох магадлал	Эрсдэлийн түвшин
Төслийн удирдлага ба хяналт					
1	Төлөвлөлт	Мэдээллийн системийн төлөвлөлтийг процесст суурилан төлөвлөж хэрэгжүүлэхгүй байна. Түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагуудын хувьд дотоод үйл ажиллагааг хэсэгчилсэн байдлаар автоматжуулсан байна. Үйл ажиллагаа, процессын оновчлол дээр суурилан олон оролцогчтой системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.	Өндөр	Дунд	Өндөр
2		ҮДТ УТУГ-ын дэд бүтцийг үүлэн дэд бүтцэд шилжүүлэх "Төрийн үүлэн дэд бүтэц" төсөл нь хэрэгжилтийн шатандаа явж байгаа боловч төслийн нэгдсэн төлөвлөгөө, нэвтрүүлэлтийн үйл явц тодорхойгүй байна.	Дунд	Дунд	Дунд
3	Хувилбарын харьцуулалт	Мэдээллийн технологийн шийдлийг сонгоход хувилбарын харьцуулалт хийх бодлого, арга зүй тодорхойгүй байна.	Дунд	Дунд	Дунд
4	Төслийн чанарын удирдлага	Мэдээллийн технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэх баг ажлын хэсгийн зохион байгуулалтаар бүрдэж байгаа нь хэрэгжилтийн чанар, хяналтад нөлөөлж байна. Ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын чанар, төлөвлөгөө, хэрэгжүүлсэн байдлыг хянах тогтолцоо дутмаг байна.	Өндөр	Дунд	Өндөр
5	МТ-ийн технологийн шийдлийн үнэлгээ	Мэдээллийн технологийн шийдлүүдийн үнэ, өртөг тооцох аргачлалыг боловсруулах шаардлагатай байна. Хэрэгжиж байгаа төслүүд нь харилцан адилгүй үнэлгээтэй хэрэгжиж байна.	Өндөр	Өндөр	Өндөр
6	Төслийн судалгаа	Уламжлалт технологийн ашиглалт дээр үүсэх шинэ технологийг нэвтрүүлэх төсөл хөтөлбөрийг эхлэлийн урьдач нөхцөл бүрдсэн эсэх судалгааг хийхгүйгээр төлөвлөж байгаа нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, нөөцийг үр ашиггүй ашиглах эрсдэл үүсгэж байна. Блокчейн, зүйлсийн интернэт зэрэг технологиуд нь цахим гарын үсэг, цахим баримт бичиг, өгөгдлийн сангийн нэгтгэл, мэдээллийн системийн хөгжлийн тодорхой үе шатанд ашиглах боломж нөхцөл үүсдэг.	Өндөр	Өндөр	Өндөр
Чанарын баталгаажуулалт ба туршилт					
1	Системийн туршилт, сайжруулалт	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхийн өмнө туршилтыг зохион байгуулах, чанарын баталгаажуулалт хийсний үндсэн дээр үйл ажиллагаанд нэвтрүүлэх шийдвэр гаргах эрх зүйн орчин бүрдээгүй байна.	Дунд	Өндөр	Дунд
2	Чанарын баталгаажуулалт	Өгөгдлийн боловсруулалтад ашиглаж байгаа программ хангамжуудын тайлангийн чанар, тэнцлийг хянах, баталгаажуулах үйл явц хийгдэхгүй байна. Програм хангамжуудаас боловсруулагдаж байгаа тайланг хянах журам, зааврыг боловсруулах шаардлагатай байна.	Дунд	Дунд	Дунд
Үйлчилгээний удирдлага					
1	Нэвтрүүлэлт	Төрийн үйлчилгээний системүүдийн нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх арга зүй тодорхойлогдоогүй байна. Мэдээллийн системийг нэвтрүүлэх аргыг буруу сонгосноос шалтгаалан албан хаагчид давхар бүртгэл хөтлөх замаар ажлын ачаалал үүсгэж үйл ажиллагааны үндсэн чанарын үзүүлэлтэд нөлөөлж байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2	Дэмжлэг үйлчилгээ	Мэдээллийн технологийн дэмжлэг үйлчилгээний үр дүнг хянах бодлого, арга зүй тодорхойлогдоогүй байна. Дэмжлэг үйлчилгээний дуудлагын мэдээлэлд суурилан системийн хөгжүүлэлт сайжруулалтыг тогтмол явуулах нь ашиглалтыг дэмжих давуу талтай. 2023.01.02 - 2023.11.07 хүртэлх тайлант хугацаанд Төрийн цахим үйлчилгээний e mongolia системийн ашиглалттай холбоотой 2551 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна. Үүнээс гадаад паспорт цуцлах хүсэлт 650 удаа буюу нийт дуудлагын 25.4 хувийг эзэлж байна.	Дунд	Дунд	Дунд
3	Үйлчилгээний удирдлага	Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч төрийн өмчит байгууллагууд, улсын төсөвт үйлдвэрийн газруудыг үзүүлсэн үйлчилгээгээр орлого бүрдүүлэх чиглэлд бодлогоор дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.	Дунд	Дунд	Дунд

Өгөгдлийн удирдлага					
1	Өгөгдлийн засаглал Өгөгдлийн эрх	Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч, үйлчилгээ хүлээн авагч талуудад өгөгдөл эзэмших эрх, эзэмшлийг зохицуулсан зохицуулалт хангалтгүй байна. Мэдээллийн системийг ашиглах хугацаанд бүрдүүлсэн өгөгдлийг эзэмших, ашиглах эрхээ баталгаажуулахтай холбоотой бодлого, журмыг батлах шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2		Нууцын зэрэглэлийг тогтоохдоо байгууллагаар бус үйл явцаар эрэмбэлж баталгаажуулах шаардлагатай. Байгууллагын өгөгдлийн хамгаалалт, хандалтын эрхүүдийг төрийн болон албаны нууцын тухай хуультай уялдуулах шаардлагатай байна.	Дунд	Дунд	Дунд
3	Өгөгдлийн стандартчилал	Мэдээллийн санг бүрдүүлж байгаа өгөгдлийн үндэсний 11 стандарт мөрдөгдөж байна. Дээрх 11 стандартаас мэдээллийн технологийн 2, хэсэг газар зүйн мэдээллийн 8, барилгын 1 стандарт байна. Мэдээллийн технологи – Тайлбар толь Өгөгдлийн сан - 2001 он, Өгөгдөл солилцохын тулд өгөгдлийн бүрдэл хэсгүүдийг зохион байгуулах, илэрхийлэх удирдамж. Кодлох арга ба зарчим - 2012 он. Стандарт, хэмжил зүйн газрын стандартын мэдээллийн санд байршиж байгаа нь түгээмлээр авч ашиглах нөхцөлийг хязгаарлаж байна.	Өндөр	Өндөр	Өндөр
4		Үндэсний хэмжээн дэх өгөгдлийн стандартуудыг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна. Аудитын явцад улсын хэмжээнд өгөгдлийн удирдлагын нэгдсэн зохицуулалт (Master Data Management) дутмаг байна. Үндэсний хэмжээнд баримтлах өгөгдлийн стандартыг шинэчлэх ажил хийгдэхгүй, стандартыг хэрэгжүүлэхгүй байгаа нь бүхий л салбарын төрийн байгууллагуудын өгөгдлийн формат, бүтэц, хэмжих нэгж зэрэг зэргээр өгөгдлийн боловсруулалтын шаардлагад нийцэхгүй байх шалтгаан болж байна. Ингэснээр төрийн болон хувийн хэвшлийн нийт салбарт мэдээлэл солилцож, нэгдсэн, уялдаатай үндэсний өгөгдлийн сан бүрдүүлэх боломжгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
5		Өгөгдөл мэдээллийг бүрдүүлэхэд анхан шатны өгөгдлийг хянаж, баталгаажуулах, өгөгдлийг нэгж хэсэгт задлах, маягтын шинжилгээ хийх бодлого байхгүй байгаа нь өгөгдлийн чанарыг алдагдуулж байна.	Өндөр	Өндөр	Өндөр
6		Программ хангамжийн боловсруулалтад тавих нэгдсэн хяналтын механизм тодорхойгүй байна. Өгөгдлийн бүрдүүлэлт дээр ашиглаж байгаа программ хангамжууд нь өгөгдлийн цэвэр байдлыг дэмжсэн байх шаардлагатай. Анхааруулгын менежментийг ашиглан хэрэгжүүлэх боломжтой.	Өндөр	Өндөр	Өндөр
7	Өгөгдөл бүрдүүлэлт	Анхан шатны өгөгдөл боловсруулах чиг үүрэг бүхий албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод өгөгдөл бүрдүүлэлтийн чиг үүргийг тусгаагүй байна.	Дунд	Өндөр	Өндөр
8		Өгөгдлийн сангийн аюулгүй байдалтай холбоотой хууль эрх зүйн орчин, зохицуулалт, хариуцлагын механизм тодорхойгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
9	Өгөгдөл ашиглалт	Мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтыг мэдээлэл хариуцагч байгууллагуудад хэрхэн хэрэгжүүлж байгаад дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэхгүй байна.	Дунд	Өндөр	Өндөр
10	Өгөгдлийн архивлалт, устгал	Ашиглалтын зорилгоо биелүүлсэн өгөгдлийг архивлах, өгөгдлийг устгах бодлого тодорхойгүй байна. Дээрх нөхцөл байдал нь хадгалах төхөөрөмжийн хэмжээг дүүргэх, зөвшөөрөлтгүй хандалт, мэдээллийн аюулгүй байдлын зөрчилд өртөх эрсдэлийг өсгөж байна.	Дунд	Дунд	Дунд
Дахин сэргээлтийн нөөц					
1	Сүлжээ хангамж	ҮДТ УТУГ-ын Дархан нөөц төв нь Төрийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байна. Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан ҮДТ УТУГ-т гэмтэл саатал гарсан тохиолдолд нөөц төвөөр хэвийн ажиллагааг хангах боломжгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2		Нийслэл дэх харилцаа холбооны суурь дэд бүтцийн гол хэсэг болох худаг сувагчлал дахь физик кабелийн 73 хувь нь огт ашиглалтгүй байна.	Дунд	Дунд	Дунд
Бодлого, журам, стратеги					
1	Мэдээллийн технологийн стратеги, түүнтэй адилтгах баримт бичиг	Цахим шилжилтэд баримтлах үндэсний стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2		Төрийн энтерпрайс архитектур (enterprise architecture) боловсруулагдаагүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
3		Мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээний бодлого байхгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
4		Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам, Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмууд нь хуульд томъёологдсон нэршлээр батлагдаагүй нь журмыг хайх, ашиглах үйл явцыг хүндрүүлж байна. Тус журмууд нь нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт тул нэршлийг хуулийн томъёоллолтой нийцүүлэх шаардлагатай байна.	Дунд	Бага	Дунд

Үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох, чиглүүлэх, хянах					
1	Зохион байгуулалт	Мэдээллийн технологийн нэгжийн удирдлагын чиг, үүрэг, албан тушаалын тодорхойлолт харилцан адилгүй байна. Түүвэрт хамрагдсан яамнуудад статистик дүн шинжилгээ, мэдээллийн технологийн нэгжийг нэгтгэсэн 2 яам, мэдээллийн технологийн нэгжгүй 1 яам, мэдээллийн технологийн үйлчилгээний чиг үүргийг нэгжүүдэд салгаж зохион байгуулсан 3 яам байна.	Дунд	Дунд	Дунд
2	Мэдээллийн технологийн нийлүүлэлтийн удирдлага	Мэдээллийн технологийн үйлчилгээний нийлүүлэгчдэд хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээс шалтгаалсан хариуцлага, урамшууллын тогтолцоогүй байна. Мэдээллийн технологийн үйлчилгээний нийлүүлэгчдэд гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд үнэлгээ өгөх, эрэмбэлэх замаар чанарт чиглэсэн өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, үйлчилгээг худалдан авч байгаа хэрэглэгчдийг мэдээллээр хангах шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр
3	Мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд холбогдох судалгаа хийхгүй байна. Тухайлбал: 1. Монгол улсын "Интернэт хаягжилтыг IPv6 шилжүүлэх" ажлыг 2021 - 2024 онд эхлүүлэх зорилтын хүрээнд 2023 онд Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, төрийн байгууллагуудын интернэт хэрэглэгчийн 24 хувийг шилжүүлэхээр төлөвлөсөн. Тус ажлын хүрээнд төрийн байгууллагын сүлжээний төхөөрөмжийн хэдэн хувь шинэчлэгдэх талаар тодорхой тооцоо судалгаа байхгүй, ЦХХХЯ-аас явуулсан судалгаа эх олонлогийг төлөөлөхгүйц бус байна. 2. Монгол улсын "Интернэт хаягжилтыг IPv6 шилжүүлэх" ажлыг 2021 - 2024 онд эхлүүлэх зорилтын хүрээнд ЦХХХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/03 тушаалаар Монгол улсын "Интернэт хаягжилтыг IPv6 шилжүүлэх" ажлын төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. 2023 оны 3-р улирлын байдлаар үндэсний хэмжээнд "Монгол Улсын интернэтийн сүлжээг интернэт хаягжилтын IPv6 хувилбарт шилжих төлөвлөгөө" батлагдаагүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
Тохиргооны удирдлага					
1	Өөрчлөлтийн удирдлага	Тохиргоо, өөрчлөлтийн удирдлагыг хянах байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлон нэгтгэх шаардлагатай байна. Тохиргооны удирдлагын хяналтыг сүлжээ хангамжийн өөрчлөлт, шинэ программ хангамжийн эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлд ТЕГ-ийн МАБ, хүний хувийн мэдээллийг хамгаалах чиглэлд Хүний эрхийн үндэсний комисс хянаж зөвлөмж хүргүүлж байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар хяналтын процесс байхгүй байна.	Дунд	Өндөр	Өндөр
Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн удирдлага					
1	Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн удирдлага	Түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагуудад гэмтэл саатлын шийдвэрлэлтийн албан ёсны төлөвлөгөө (DRP) болон үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө (BCP) байхгүй байна. Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, нөхөн сэргээлтийг явуулах, нөхөн сэргээлтэд ашиглах зорилгоор нөөцлөлтийг гүйцэтгэх талаар нарийвчилсан зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэх механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2		Гэмтэл саатлын тохиолдлыг бүртгэх, гүйцэтгэлийн үзүүлэлттэй уялдуулах, эрсдэлийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх үйл ажиллагаа төлөвшөөгүй байна.	Дунд	Дунд	Дунд
Нийлүүлэлтийн удирдлага					
1	Бэлтгэн нийлүүлэгчийн үйлчилгээний удирдлага	Төрийн үйлчилгээний мэдээллийн системийн шийдлийг бусдаар гүйцэтгүүлэх ажил (outsourcing)-н гэрээгээр шийдвэрлэж байгаа тохиолдолд үйл ажиллагааны тасралтгүй байдал, өгөгдлийн эрх, аюулгүй байдал, өмчлөх эрх, зардлыг үйлчилгээний гэрээнд заавал тусгах зохицуулалт байхгүй байна. Мөн тухайн үйлчилгээ нь дотоод эх үүсвэрээс нийлүүлэгдэх боломжтой тохиолдолд зардал үр ашгийн шинжилгээ, хувилбарын шинжилгээ хийхгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2	Худалдан авалтын удирдлага	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтын нэгдсэн бодлого чиглэл байхгүй байна. Худалдан авалтын техникийн шаардлагыг хэт дэлгэрэнгүй оруулах нь эргээд халдлага, зөрчлийн эрсдэлийг үүсгэж байгаа бол худалдан авалтын шаардлага тодорхой бус байх нь шударга өрсөлдөөн, ашиг сонирхлоос ангид байх худалдан авалтын журмыг хангаж чадахгүйд хүрч байгаа тул зохицуулалт шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр

Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зохицуулалт					
1	Мэдээллийн аюулгүй байдлын аудитын зохицуулалт	КАБТХ-д онц чухал дэд бүтэцтэй хуулийн этгээд, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагууд нь эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитыг ЦХХХЯ-нд бүртгүүлсэн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх зохицуулалттай. Дээрх аудит, эрсдэлийн үнэлгээнд ашиглах мэдээллийн системгүй байгаа нь үйл ажиллагааны уялдааг хангах, бодит цагийн хяналтыг хэрэгжүүлэх, өгөгдлийг цуглуулах боломжгүй нөхцөлд хүргэж байна.	Дунд	Дунд	Дунд
2		Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хийх заавар аргачлалд аудитын тайлангийн чанарын хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах байгууллага тодорхойгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
3		Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байгууллагадаа хоёр жилийн хугацаанд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийхийг хориглох зохицуулалт байгаа боловч хяналтын механизм тодорхойгүй байна.	Өндөр	Өндөр	Өндөр
Хөрөнгийн удирдлага					
1	Мэдлэгийн удирдлага	Зөвлөх үйлчилгээ, судалгаа, дотоод үйл ажиллагааны хүрээнд бий болсон мэдлэгийг ашиглах арга зүй, мэдлэгийн менежментийн тогтолцоо бүрдээгүй байна.	Өндөр	Дунд	Өндөр
2	Мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлагын бодлого	Мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлагын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ашиглалтын хугацаа дууссан, системийн шинэчлэл зогссон техник хангамжийг шинэчлэх ажлыг тогтмол хийдэггүйгээс шалтгаалан ҮДТ УТУГ, интернэтийн харилцан холболтын үйлчилгээнд ашиглалтын хугацаа дууссан өндөр эрсдэлтэй тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Тухайлбал, Монгол улсын интернэтийн харилцан холболтын үйлчилгээнд ашиглаж байгаа Cisco Nexus 7010 салаалагч төхөөрөмж 2008 онд үйлдвэрлэгдсэн, ашиглалтын хугацаа дууссан байна. Тус бүрийн 1G Optical Ethernet бүхий 32 порт, 6 ш модультай. Дээрх модулиас 1 модуль ажиллаж байна. Тус төхөөрөмжид гэмтэл гарсан тохиолдолд шилжилтийн нөөц шийдэлгүй, гэмтлийг засах хугацаагаар үйлчилгээ тасалдаж байна.	Өндөр	Өндөр	Өндөр
Хүний нөөцийн аюулгүй байдал					
1	Хүний нөөцийн бодлого	Салбарын хэмжээнд хүний нөөцийг нөхөн бүрдүүлэх, сэлгэн ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр
2		Хүний нөөцийг чадавхжуулах, бэлтгэх чиглэлд “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх 2023-2026” төсөл эхэлсэн байна. Энэхүү төсөлд хамрагдсан мэргэжилтнүүдийг үр дүнтэй, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай. Мөн дээрх сургалтад хамрагдсан иргэдийг төрийн албанд томилох эрхзүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.	Өндөр	Өндөр	Өндөр

Кибер аюулгүй байдлыг хангах эрсдэлийн ерөнхий үнэлгээний дэлгэрэнгүй тайлбар

### МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТӨСЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

#### Илрүүлэлт 1,2: Төлөвлөлт

Түүвэрт хамрагдсан 9 байгууллагын хувьд мэдээллийн системийн төлөвлөлтийг үйл явцад суурилан төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байгаа нь эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мэдээллийн технологийн төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд тодорхой бүтэцтэй, үйл явцад суурилсан арга зүй ашиглахгүй байгаа нь мэдээллийн системийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, үр дүнтэй байдал ихээхэн эрсдэл учруулж байгаагийн дээр дотоод үйл ажиллагаагаа хэсэгчлэн автоматжуулснаас гадна олон хэрэглэгчтэй системийн хөгжүүлэлтийг хангалтгүй гүйцэтгэх нь эрсдэлийн түвшнийг нэмэгдүүлж байна.

#### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

##### Зөвлөмж:

Батлагдсан үйл явцууд дээр үндэслэн мэдээллийн системийн төлөвлөлтийн цар хүрээг цогцоор нь боловсруулж, олон оролцогчтой мэдээллийн системийг оновчтой хөгжүүлэхэд системтэй, хамтын ажиллагааны арга барил шаардлагатай байна. Үүнд:

- Оролцогч талуудын шинжилгээ:** Эцсийн хэрэглэгчид, шийдвэр гаргагчид, удирдлагууд, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчид, харилцагчид зэрэг холбогдох бүх оролцогч талуудын үүрэг, хэрэгцээ, хүлээлт, мэдээллийн системийн оролт, гаралтыг тодорхойлох шаардлагатай.
- Зорилго, шаардлагыг тодорхойлох:** Мэдээллийн системийн зорилгыг тодорхойлж, бүх оролцогч талуудаас нарийвчилсан шаардлагыг цуглуулж, ач холбогдлыг зэргээр эрэмбэлэх шаардлагатай.
- Процессын зураглал ба оновчлол:** Мэдээллийн системээр сайжруулахыг зорьж буй үйл явцын

зураглалыг гарган, саад бэрхшээл, үр ашиггүй байдал, сайжруулах шаардлагатай цэгүүдийг тодорхойлж, тэдгээрийг сайн туршлага, төслийн зорилгод нийцэхээр дахин оновчилж, тодорхойлох шаардлагатай.

4. **Хамтын шийдэл:** Системийн зохиомжийн үе шатанд оролцогч талуудын оролцоог хангаж, саналыг харгалзан үзсэний үндсэн дээр оролцогч талуудын янз бүрийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэн системийг зохиомжийг гаргах шаардлагатай.
5. **“Agile” хөгжүүлэлтийн арга зүй ашиглах:** Санал хүсэлтийг тасралтгүй тусгаж, сайжруулалт хийх agile хөгжүүлэлтийн аргачлалыг баримтлах нь уян хатан байдлыг хангаж, төсөл хэрэгжих явцад өөрчлөлтийг тусгах боломжийг олгож, оролцогч талуудын хэрэгцээ, хүлээлтийн өөрчлөлтийг тусгах боломжийг олгодог.
6. **Хэрэглэгч төвтэй зохиомж:** Хэрэглэгч төвтэй зохиомжийн зарчмаар хэрэглэгчийн туршлагыг (UX) эрэмбэлж, системийн интерфэйс болон функцийг боловсронгуй болгохын тулд эцсийн хэрэглэгчдээр туршуулан, санал хүсэлтийг тусгах шаардлагатай. Ингэснээр эцсийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн, системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд гол ач холбогдолтой.
7. **Гүйцэтгэлийн хэмжигдэхүүн ба гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд (KPI):** Төслийн зорилгод нийцсэн гүйцэтгэлийн хэмжигдэхүүн болон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг бий болгох. Үүнд үр ашиг, үр дүн, оролцогч талуудын сэтгэл ханамжийн хэмжүүрүүд орно. Төслийн хүрэх үр дүнгийн чанарыг тогтмол хадгалахын тулд дээрх хэмжигдэхүүнүүдийг тогтмол хянаж, үнэлэх шаардлагатай.
8. **Өгөгдлийн хадгалалт, хамгаалалт, нууцлал:** Өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, хувийн нууцыг хамгаалах арга хэмжээг дизайн, хөгжүүлэлтийн процесст тусгах шаардлагатай. Үүнд хандалтын хяналт, шифрлэлт, өгөгдөл хамгааллын холбогдох дүрэм журмын нийцэл хамаарна.
9. **Сургалт ба өөрчлөлтийн менежмент:** Оролцогч талууд шинэ системийг үр дүнтэй, бүрэн хүчин чадлаар нь ашиглахад дэмжлэг үзүүлэх сургалтын цогц төлөвлөгөөг боловсруулна. Өөрчлөлтийн эсэргүүцлийг арилгаж, системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг хөнгөвчлөх үүднээс өөрчлөлтийн менежментийн зөв стратегийг сонгон хэрэгжүүлэх шаардлагатай байна.
10. **Туршилт ба чанарын баталгаа:** Шинэ системтэй холбоотой аливаа алдаа, асуудлыг эрт илрүүлж, засахын тулд хөгжүүлэлтийн бүх үе шатанд нарийн шинжилгээ хийх шаардлагатай. Систем нь тогтоосон шаардлага, стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд чанарын баталгаажуулалтын үйл явцыг хэрэгжүүлэх

шаардлагатай.

**11. Баримт бичиг:** Мэдээллийн системд хэрэглэгчийн гарын авлага, системийн архитектурын баримт бичиг, үйл ажиллагааны журам зэрэг цогц баримт бичгийг бүрдүүлэх нь цаашид энэхүү баримт бичгийг ашиглан системийн засвар үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, алдаа доголдлыг илрүүлж засварлан, тогтмол сайжруулалт, шинэчлэл хийхэд тусална.

**12. Тогтмол сайжруулалт:** Системийг тогтмол сайжруулж, шинэчлэхийн тулд хэрэглэгчийн санал хүсэлтийн бүртгэл бий болгон, системийн гүйцэтгэлд хяналт тавьж, сайжруулах боломжуудыг тодорхойлох зорилгоор дээрх бүртгэлийг ашиглах шаардлагатай.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, хамтын ажиллагаа, хэрэглэгчийн оролцоо, тасралтгүй сайжруулалтыг тусгаснаар үйл ажиллагаа, үйл явцыг оновчтой болгох зорилтуудтай нийцсэн олон хэрэглэгчтэй мэдээллийн системийг хөгжүүлэх боломжтой.

### Илрүүлэлт 3: Хувилбарын харьцуулалт

Мэдээллийн технологийн шийдлийн хувилбаруудыг харьцуулах тодорхой бодлого байхгүй байгаа нь мэдээллийн технологийн худалдан авалт хийх явцад байгууллагын шийдвэр гаргах үйл явцад ихээхэн эрсдэл учруулж байна. Алтернатив хувилбаруудыг үнэлэх, сонгох бүтэцтэй тогтолцоо байхгүйгээс оновчтой бус технологийн худалдан хийх магадлал өндөрсөж, үр ашиггүй байдал, зардлыг нэмэгдүүлж, төслийн нийт үр нөлөө буурах магадлалтай.

### Эрсдэлийн түвшин: “Дунд”

#### Үр нөлөө:

Мэдээллийн технологийн шийдлийн хувилбаруудыг харьцуулах тодорхой бодлого байхгүй байгаа нь хэд хэдэн сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй, үүнд:

- Технологийн сонголт оновчгүй болох: Системчилсэн арга барилгүйгээр салбарын стратегийн зорилгод нийцэхгүй эсвэл чухал шаардлагад нийцэхгүй шийдлүүдийг сонгох эрсдэлтэй.
- Төлөвлөөгүй зардал бий болох: Технологийн шийдлийн сонголт буруу байснаар засвар үйлчилгээ, шинэчлэлттэй холбоотой гэнэтийн зардал гарах эсвэл үйл ажиллагааны дутагдлыг нөхөх нэмэлт технологийн хэрэгцээнд хүргэж болзошгүй.
- Үйл ажиллагааны үр ашиггүй байдал: Технологийн зохисгүй сонголт нь үйл ажиллагааны үр ашиггүй байдалд хүргэж,

бүтээмжид саад учруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлж болзошгүй.

- Алдагдсан боломжууд: Тодорхой бодлого байхгүйгээс байгууллага технологийн давуу талын бий болгож чадах шинэлэг шийдэл, шинээр гарч ирж буй технологиудыг алдахад хүргэж болзошгүй.
- Оновчгүй шийдвэр гаргах: Стандартчилсан үйл явцгүй бол шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг бууруулж, урт хугацааны үр нөлөөг үнэлэх боломжгүй болдог.

#### Зөвлөмж:

Мэдээллийн технологийн шийдлийн хувилбаруудыг харьцуулах цогц бодлого, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх замаар тулгарч буй сорилтуудыг багасгах. Энэ нь мэдээлэлтэй шийдвэр гаргах, зардал хэмнэх, байгууллага доторх мэдээллийн технологийн санаачилгыг амжилтад хүргэх ач холбогдолтой юм. Мөн зардал, үйл ажиллагаа, өргөтгөх боломж, аюулгүй байдал, төслийн зорилгод нийцүүлэх зэрэг шалгууруудыг агуулсан байх ёстой. Шийдвэр гаргахдаа гол оролцогч талуудыг хамруулсан стандартчилсан үнэлгээний үйл явцыг бий болгох. Технологийн өөрчлөлт, хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд дасан зохицох байдлыг хангахын тулд бодлогыг тогтмол хянаж, шинэчлэх шаардлагатай. Бодлогын байнгын аудит, шинэчлэлтүүд нь мэдээллийн технологийн динамик орчинд бодлогын нийцлийг үргэлжлүүлэн хангах ач холбогдолтой.

#### Илрүүлэлт 4: Төслийн чанарын удирдлага

Мэдээллийн технологийн аудитын арга зүйн хүрээнд 9 яамдад хийсэн үнэлгээнээс үзэхэд мэдээллийн технологийн шийдлийг хэрэгжүүлэх багийг бүрдүүлэх, ажиллуулахтай холбоотой томоохон эрсдэлүүд нийтлэг ажиглагдсан. Дээрх яамдад мэдээллийн технологийн шийдлийг хэрэгжүүлэх багийг ажлын хэсгийн зохион байгуулалтаар шийдэж байгаа нь төслийн хэрэгжилтийн чанар, хяналтад нөлөөлж байна. Түүнчлэн гүйцэтгэсэн ажлын чанарт хяналт тавих системчилсэн горимгүй, төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавихад учир дутагдалтай байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

#### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

##### Үр нөлөө:

- **Чанарын хяналтын асуудал:** Ажлын хэсгээр төслийг хэрэгжүүлэх нь мэдээллийн технологийн шийдлийн хэрэгжилтийн үйл явцын хяналт, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж, алдаа гарах, төслийн цар хүрээнээс

гажих эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- Үр ашиггүй үйл ажиллагаа: Хяналт, хяналтын горим тогтолцоо хангалтгүй байгаа нь үйл ажиллагааны үр ашиггүй байдалд хүргэж, төслийн саатал, зардал нэмэгдэх, төслийн үр ашиг, үр нөлөө буурахад хүрсэн байна.

#### Зөвлөмж:

##### 1. Бүтцийн хяналт, зохион байгуулалтын өөрчлөлт:

Одоо ажиллаж байгаа ажлын хэсгийн зохион байгуулалтын бүтцэд нэг бүрчлэн дүн шинжилгээ хийх шаардлагатай. Төслийн зорилгод хүрэхэд ажлын хэсгийн үр нөлөөг үнэлж, шаардлагатай тохиолдолд төслийн чанар, хяналтыг сайжруулах зорилгоор оновчтой зохион байгуулалтын бүтцийг бүрдүүлж, үүрэг хариуцлагыг илүү нарийвчлах шаардлагатай.

##### 2. Хяналтын системийг хэрэгжүүлэх:

Ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын чанарт хяналт тавих найдвартай тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Үүнд гүйцэтгэлийн тодорхой хэмжүүр, тогтмол үнэлгээ, тодорхойлсон асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх горим тогтолцоог багтаасан байх ёстой.

##### 3. Төлөвлөлтийг сайжруулах:

Төслийн цогц төлөвлөгөө, хэрэгжилтийн үе шат, байнгын хяналтыг багтаасан албан ёсны үйл явцыг хэрэгжүүлэх замаар төслийн төлөвлөлтөд тавих хяналтыг бэхжүүлснээр төслийг урьдчилан тодорхойлсон хугацаа, зорилтын дагуу хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

##### 4. Сургалт, хөгжил:

Мэдээллийн технологийн шийдлийг хэрэгжүүлэх багийнхны чадамжийг дээшлүүлэх сургалт, хөгжлийн ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр мэдлэг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, гүйцэтгэлийг үнэлснээр төслийн үр дүн, чанарын хяналтыг сайжруулах ач холбогдолтой.

##### 5. Байнгын сайжруулалт:

Мэдээллийн технологийн шийдлийг хэрэгжүүлэх багт гүйцэтгэлээ тасралтгүй сайжруулах зан үйл, хандлагыг төлөвшүүлэх, үйл явцын эрсдэлийг бууруулан боловсронгуй болгох, төслийн үр дүнг сайжруулахын тулд оролцогч талуудын санал хүсэлтийг шийдвэрлэх, хэрэгжилтийн дараах үнэлгээг хийж, асуудлыг бүртгэлжүүлэн, сайн туршлагыг хэрэгжүүлэх шаардлагатай.

#### Илрүүлэлт 5: МТ-ийн технологийн шийдлийн үнэлгээ

#### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

Мэдээллийн системийн төслүүд нь харилцан адилгүй үнэлгээтэй хэрэгжиж байгаа нь зардал, үр



ашгийн томоохон эрсдэл бий болгож байна. Төсөв, зардлын зөрүүтэй байдал нь ил тод, бодитой байдал хангагдахгүй байгааг харуулж байна. Яамд нийтээр мөрдөх мэдээллийн технологийн шийдлийн жишиг өртгийг тооцоолох стандарт, аргачлалгүй байгаа нь нөөцийг оновчтой бус хуваарилах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд мэдээллийн технологийн төслийн өртгийг тооцох арга зүйг стандартчилах хэрэгцээ нэн чухал байгаагаас гадна мэдээллийн технологийн төслүүдийн засаглалыг сайжруулах шаардлагатай байна.

#### Үр нөлөө нь:

- **Санхүүгийн менежментийн алдаа:** Өртөг тооцоолох стандарт аргачлал байхгүйгээс санхүүгийн менежментийн алдаа гарах эрсдэл нэмэгдэж, төсвийг хэтрүүлэн зарцуулах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл нэмэгдэж байна.
- **Нөөцийн хуваарилалтын үр ашиггүй байдал:** Зардал жигд бус байгаа нь нөөцийн хуваарилалт үр ашиггүй байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь төслийн үр дүнг бууруулахаас гадна хугацааны хоцрогдолд хүргэж байна.
- **Төсвийн хариуцлага тооцох механизм хангагдахгүй байх:** Мэдээллийн технологийн төслүүдийг хэрэгжүүлэх стандартчилсан аргачлал байхгүй байгаа нь төсвийн хариуцлага, ил тод, бодит байдлыг хангах зарчим алдагдаж байна.
- **Төсөл бүтэлгүйтэх эрсдэл:** Төсөв, зардлын хувьд зөрүүтэй харилцан адилгүй мэдээллийн технологийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд эрсдэл өндөр болж, төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг.

#### Зөвлөмж:

1. **Стандартчилсан арга зүйг боловсруулах:** Мэдээллийн технологийн шийдлийн өртөг тооцох нэгдсэн, аргачлалыг бий болгох шаардлагатай. Энэхүү аргачлал нь салбарын жишиг үзүүлэлт, төслийн нарийн төвөгтэй байдал болон бусад холбогдох хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой.
2. **Зардлын хяналтын механизмыг хэрэгжүүлэх:** Төслийн зардлыг хянах, удирдах горим тогтолцоо нэвтрүүлэх шаардлагатай. Төслийн зардлыг тооцоолох тогтсон аргачлал мөрдүүлэхийн тулд тогтмол хяналт, шалгалт хэрэгжүүлэх шаардлагатай.
3. **Хяналт, хариуцлагыг сайжруулах:** Хараат бус хяналтын зөвлөл болон зохицуулах чиг үүрэгтэй байгууллагаар стандартчилсан аргачлалыг мөрдөж ажиллахад хяналт, хариуцлагын механизмыг гүйцэтгүүлэх шаардлагатай.
4. **Ил тод байдлыг сайжруулах:** Төслийн зардал, аргачлал, үр дүнгийн талаарх мэдээллийг сонирхогч талууд, тэр дундаа олон нийтэд

хүртээмжтэй болгох замаар төсөв боловсруулах, өртөг тооцох үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

5. **Сургалт, чадамжийг бэхжүүлэх:** Төслийн өртгийн тооцооллыг гүйцэтгэх хүний нөөцийн үр чадварыг дээшлүүлэх, зохих аргачлалыг тууштай хэрэгжүүлэхэд чиглэсэн чадамжийг бэхжүүлэх сургалт хөтөлбөрүүдийг шаардлагатай.

#### Илрүүлэлт 6: МТ-ийн төслийн судалгаа

##### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

Шинэ технологи нэвтрүүлэхэд уламжлалт технологийн төлөвшилт хангалттай буюу төслийн урьдач нөхцөл бүрэлдсэн эсэхийг үнэлэх нарийн үнэлгээ хийгдээгүй, төслийн техник эдийн засгийн үндэслэлийг хангалттай тодорхойлоогүйгээс урьдчилж төлөвлөөгүй эрсдэл, нөөцийн үр ашгийн хуваарилалтын алдаа гарч байна. Түүнчлэн цахим гарын үсэг, цахим баримт бичиг, өгөгдлийн сангийн нэгтгэл, мэдээллийн систем зэрэг суурь элементүүдийн хөгжүүлэлт хангалтгүй байгаа тохиолдолд блокчэйн, зүйлсийн интернэт (IoT) зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилт дэвшүүлсэн нь дараах үр нөлөөг бий болгож байна.

#### Үр нөлөө:

- **Төслийн хэрэгжилт бүтэлгүйтэх:** Төслийн урьдчилсан нөхцөлийн талаар судалгаа хийгдээгүй байгаа нь урьдчилан тооцоолоогүй саад бэрхшээлтэй тулгарах, нөөцийг үр ашиггүй хуваарилахад хүргэж, урьдчилан тооцоолсон зардал нэмэгдэх, төслийн үр дүн оновчтой бус байх эрсдэлийг үүсгэж байна.
- **Технологийн эрсдэл:** Цахим гарын үсэг, цахим баримт бичиг, өгөгдлийн сангийн нэгтгэл зэрэг суурь технологийн төлөвшил хангалтгүй байгаа тохиолдолд блокчэйн, зүйлсийн интернэт (IoT) зэрэг дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх нь технологийн зөрүү үүсгэн, техникийн саатал бий болгох эрсдэлтэй байна.
- **Үйл ажиллагааны тасалдал:** Суурь элементүүдийн төлөвшил, хөгжүүлэлт харилцан адилгүй, хэсэгчлэн хангалтгүй байгаа нь одоо хэрэгжиж байгаа үйл ажиллагааг тасалдуулж, үндэсний хэмжээнд мэдээллийн технологийн орчны ерөнхий тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

#### Зөвлөмж:

1. **Урьдчилсан судалгааг гүйцэтгэх:** Салбарын хэмжээнд шинэ технологийг нэвтрүүлэхийн өмнө урьдчилсан нөхцөл бүрдсэн эсэхийг баталгаажуулах цогц судалгааг нэн тэргүүнд гүйцэтгэж хэвших шаардлагатай байна. Энэхүү

судалгаа нь одоо байгаа системүүдийн тасралтгүй ажиллагааг хангахын зэрэгцээ шинэ технологийг нэвтрүүлэх орчин хангалттай бүрэлдсэн эсэхийг баталгаажуулах суурь нөхцөл болно.

2. **Хугацаа ба нөөцийн төлөвлөлт:** Бодит хугацаа, нөөцийн хуваарилалтыг багтаасан төслийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулснаар нэвтрүүлэлтийн эрсдэлийг бууруулж, төслийн хэрэгжилтийн мөчлөгийн туршид нөөцийн оновчтой ашиглалтыг хангах нөхцөл болно.
3. **Технологийн бүрдүүлэлт хийх шаталсан зураглал гаргах:** Блокчэйн, зүйлсийн интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх тодорхой төлөвлөгөөний шаталсан зураглалыг бий болгон, эдгээр технологиудыг нэвтрүүлэхээс өмнө цахим гарын үсэг, өгөгдлийн санг нэгтгэх зэрэг үндсэн элементүүд бүрдэж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай байна.
4. **Эрсдэлийг бууруулах стратеги:** Боломжит бэрхшээл, тасалдлыг арилгахын тулд эрсдэлийг бууруулах стратегийг хэрэгжүүлнэ. Үүнд хэрэгжүүлэх үе шатанд урьдчилан тооцоолоогүй саатал, техникийн асуудлуудаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг багтаана.
5. **Оролцогч талуудын харилцааг удирдах:** Төсөлтэй холбоотой болзошгүй эрсдэлийн талаар гол оролцогч талуудад ил тод, нээлттэй мэдээлэх, эрсдэлийн нөлөөллийг бууруулахын тулд харилцааны төлөвлөгөө гаргах шаардлагатай.

## ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ БА ТҮРШИЛТ

**Илрүүлэлт 1,2:** Тест, сайжруулалт, чанарын баталгаажуулалт

Аудитын явцад салбарын хэмжээнд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг системийн туршилтын үр дүнд үндэслэн нэвтрүүлэх шийдвэр гаргах хууль эрх зүйн орчин бүрдээгүй, чанарын баталгаажилт хийгдээгүй нь тогтоогдсон. Зохицуулалтын тогтолцоо дутмаг байгаагаас төслийг туршилтын амжилтын үр дүнд үндэслэн нэвтрүүлэх шийдвэрийг гаргах үйл явц дутагдалтай байгаагаас төслийн үр дүн хэсэгчлэн хангагдахгүй байгаагаас, хууль эрхзүй, үйл ажиллагаа, нэр хүнд талаас сөрөг нөлөө үзүүлж байна. Илэрсэн эрсдэлийн үр дүнд үндэслэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцыг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх нэн чухал хэрэгцээг онцолж байна.

**Эрсдэлийн түвшин: “Дунд”**

**Үр нөлөө:**

1. **Чанарын баталгаажуулалт хийгдээгүй:** Зохицуулалтын эрхзүйн орчин бүрдээгүй байгаа

нь мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний найдвартай байдал, гүйцэтгэлийг эрсдэлд оруулж, чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг хангалтгүй болгох эрсдэлтэй байна.

2. **Шийдвэр гаргалт тодорхой бус байх:** Хууль эрх зүйн орчин дутмаг байгаа нь шийдвэр гаргах үйл явцыг тодорхой бус болгох, мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх нь зохистой эсэхийг үнэлэх, баталгаажуулах горимыг алгасаж байна.
3. **Нэр хүндэд сөргөөр нөлөөлөх:** Нэвтрүүлэлтийн шийдвэр гаргалтыг зохицуулах, чанарын баталгаажуулалт хийх хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаагаас мэдээллийн технологийн чанар, найдвартай байдлыг хангаагүйгээр хэрэглээнд нэвтрүүлдгээс шалтгаалж эцсийн хэрэглэгчдийн хүлээлтийг хангахгүй систем бий болж, сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж, захиалагч, гүйцэтгэгчийн нэр хүндийг унагах эрсдэлтэй байна.

**Зөвлөмж:**

1. **Эрх зүйн орчныг бий болгох:** Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцыг удирдан чиглүүлэх эрх зүйн иж бүрэн тогтолцоог боловсруулахын тулд хуулийн мэргэжилтнүүд болон бусад зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй.
2. **Чанарын баталгаажуулалтыг сайжруулах:** Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний найдвартай байдал, гүйцэтгэлийг үнэлэх стандарт журам, шалгуур үзүүлэлтийг бий болгох замаар чанарын баталгаажуулалтыг хангах шаардлагатай.
3. **Оролцогч талуудын оролцоог хангах:** Салбарын сайн туршлагыг хангах журмын төслийг боловсруулахын тулд хуулийн зөвлөхүүд, салбарын мэргэжилтнүүд, дотоод шийдвэр гаргагчид зэрэг талуудтай хамтран ажиллах.
4. **Эрсдэлийн удирдлагын протоколууд:** Мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн болон үйл ажиллагааны болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах зорилгоор эрсдэлийн удирдлагын үнэлгээг хийлгэж, протоколуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.
5. **Сургалт ба мэдлэг олгох:** Тогтоосон хууль эрх зүйн орчин, чанарын баталгааны стандартыг дагаж мөрдөхийн ач холбогдлын талаар холбогдох ажилтнуудад мэдлэг олгох сургалт, сурталчилгааны хөтөлбөрүүдийг зохион байгуулах шаардлагатай.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДЛАГА

**Илрүүлэлт:** Системийн нэвтрүүлэлт, дэмжлэг үйлчилгээ, үйлчилгээний удирдлага.

Төрийн үйлчилгээний мэдээллийн системд илэрсэн асуудлууд шалгагдагч байгууллагын үйл ажиллагаа, санхүү, хэрэглэгчийн сэтгэл ханамжид эрсдэлийг бий болгож байна. Интеграци, хууль эрх зүйн дэмжлэг, хэрэглэгчийн санал хүсэлтийн дагуу сайжруулалт хийх механизмаар дамжуулан эдгээр асуудлуудыг шийдвэрлэх нь төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, санхүүгийн хувьд тогтвортой, хэрэглэгчдэд төвлөрсөн мэдээллийн технологийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна. Эдгээр эрсдэлийг бууруулах, төрийн үйлчилгээг дэмжих мэдээллийн системийн урт хугацааны амжилтыг хангахын тулд яаралтай арга хэмжээ авахыг зөвлөж байна.

- 1. Төрийн байгууллагуудад мэдээллийн системийн интеграци дутмаг:** Төрийн үйлчилгээний мэдээллийн системүүд интеграци хийгдээгүй байгаа нь албан хаагчид олон системүүдэд ижил мэдээллийг давтан оруулж байгаа нь шаардлагагүй ачааллыг нэмэгдүүлж, мэдээллийн үнэн зөв, үр ашигтай байдал хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэн, үндсэн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- 2. Мэдээллийн технологийн үйлчилгээний төлбөрийг үйл ажиллагааныхаа орлогоос санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй:** Төрийн өмчит байгууллагууд үзүүлж буй мэдээллийн технологийн үйлчилгээний төлбөрөөсөө санхүүжих эрх зүйн орчин дутмаг байдгаас тоног төхөөрөмжийн элэгдэл, лицензийн зардлаа санхүүжүүлэхэд хүндрэл учирч, мэдээллийн технологийн үйлчилгээг тогтвортой байлгах, сайжруулах боломжгүй болох эрсдэл учирч байна.
- 3. Хэрэглэгчийн хүсэлт дээр үндэслэн системийг сайжруулах ажил хийгдэхгүй байна:** Дуудлагын төвд хандсан хэрэглэгчийн хүсэлтийн мэдээлэл дээр үндэслэн төрийн үйлчилгээний мэдээллийн системд сайжруулалт, өөрчлөлт хийгдэхгүй байгаа нь системийн хэрэгцээнд нийцэх байдлыг бууруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлж байна.

**Эрсдэлийн түвшин: “Дунд”**

**Үр нөлөө:**

- 1. Үйл ажиллагааны үр ашиггүй байдал:** Өгөгдөл, мэдээллийг салангид системүүдэд давхар оруулах нь үйл ажиллагааны үр ашиггүй байдал үсэхэд нөлөөлж, ажлын ачаалал ихсэх, өгөгдлийн менежментийн алдаа гарах эрсдэлийг үүсгэж байна.

- 2. Төрийн өмчит байгууллагуудын МТ-ийн санхүүжилт шийдэгдэхгүй байна:** Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлсэн төлбөрөөсөө үйл ажиллагааныхаа зардлыг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдал, өсөлтийн боломжийг хязгаарлаж байна.
- 3. Хэрэглэгчийн сэтгэл ханамжгүй байдал:** Хэрэглэгчийн санал хүсэлт дээр үндэслэн системийн сайжруулалт хийгдэхгүй байгаа нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг бууруулж, хувьсан өөрчлөгдөж буй үйлчилгээний шаардлагад системийн хариу үзүүлэх чадвар хөгжихөд дэмжлэг болж чадахгүй байна.

**Зөвлөмж:**

- 1. Интеграцийг хэрэгжүүлэх:** Өгөгдөл, мэдээлэл оруулах үйл явцыг оновчтой болгох, ажлын ачааллыг бууруулах, мэдээллийн үнэн зөв байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээний мэдээллийн системийг нэгтгэх цогц стратегийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.
- 2. Эрх зүйн орчныг дэмжих:** Төрийн өмчийн байгууллагуудыг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, үзүүлж буй мэдээллийн технологийн үйлчилгээний төлбөрөөс санхүүжих эрхийг олгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3. Хэрэглэгчийн санал хүсэлтийн механизмыг сайжруулах:** Дуудлагын төвөөс хэрэглэгчийн санал хүсэлтийн бүртгэлийг хүлээн авч, дүн шинжилгээ хийх бүтэцтэй үйл явцыг бий болгож, энэ мэдээллийг ашиглан төрийн үйлчилгээний мэдээллийн системд байнгын сайжруулалтыг хийх үйл явцыг хэрэгжүүлэх шаардлагатай.

## ӨГӨГДЛИЙН УДИРДЛАГА

**Аудитын илрүүлэлт:**

- Өгөгдлийн засаглал;
  - Өгөгдлийн стандартчилал;
  - Өгөгдөл бүрдүүлэлт;
  - Өгөгдлийн ашиглалт;
  - Өгөгдлийн архивлалт, устгал.
- **Үндэсний хэмжээнд өгөгдлийн стандарт байхгүй байна:** Аудитын явцад улсын хэмжээнд өгөгдлийн удирдлагын нэгдсэн зохицуулалт (Master Data Management) дутмаг байгаа нь ажиглагдсан. Үндэсний хэмжээнд баримтлах өгөгдлийн нэгдсэн стандарт байхгүй байгаа нь бүхий л салбарын төрийн байгууллагуудын өгөгдлийн формат, бүтэц, хэмжих нэгж зөрөх зэргээр өгөгдлийн боловсруулалтын шаардлагад

нийцэхгүй байх шалтгаан болдог. Ингэснээр төрийн болон хувийн хэвшлийн нийт салбарт харилцаа, хамтын ажиллагаатайгаар мэдээлэл солилцож, нэгдсэн, уялдаатай үндэсний өгөгдлийн сан бүрдүүлэх боломжгүй болж байна. Мастер өгөгдлийн удирдлага буюу олон салбарт ашиглагдах боломжтой үндсэн өгөгдлийн удирдлагыг хэрэгжүүлснээр үндэсний хэмжээнд хуваалцаж, хандалт хийх боломжтой өгөгдлийн нэгдсэн, үнэн зөв, баталгаатай хувилбарыг бий болгох явдал юм.

- **Өгөгдлийн засаглалын бодлого хангалтгүй:** Аудитын шалгалтаар үндэсний хэмжээнд өгөгдлийг зохицуулах цогц бодлого батлагдаагүй байгаагаас одоо ашиглагдаж байгаа хуулиудад ихээхэн цоорхой байгаа нь ажиглагдсан. Мастер өгөгдлийг үүсгэх, өөрчлөх, давхардлыг арилгах, устгах үйл ажиллагааг удирдахын тулд өгөгдлийн засаглалыг хэрэгжүүлэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хариуцагчийг тодорхойлох, чанарын удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэн, хариуцлага тооцох талаар тодорхой удирдамж байхгүй байгаагаас үндэсний хэмжээний эмзэг өгөгдлийн бүрэн бүтэн байдал, нууцлал эрсдэлтэй байна.
- **Нэгдсэн өгөгдлийн сан (Master database) бий болгоход чиглэсэн салбаруудын хамтын ажиллагааг зохицуулсан хууль журам байхгүй байна.** Тодорхой үйл явцад ашиглах, мэдээлэл авах зорилгоор ашиглах боломжтой нэгдсэн өгөгдлийн санг бий болгоход салбар хоорондын хамтын ажиллагаа, түүнийг зохицуулсан хууль, журам дутмаг байгаа нь аудитаар тогтоосон. Зохицуулалт байхгүй байгаа нь өгөгдлийн тусгаарлалтыг бий болгож, тодорхой сэдвээр цогц, нэгдсэн мэдээллийг боловсруулахад саад учруулж байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

**Үр нөлөө:** Өгөгдлийн удирдлагатай холбоотой хууль эрхзүйн орчин бүрдээгүй байна.

Өгөгдлийн эзэмшил, нууцлал, стандарттай холбоотой зохицуулалт үндэсний хэмжээнд байхгүй байгаа нь байгууллагуудын хооронд өгөгдөл эзэмших эрхийн маргаантай холбоотой хууль эрх зүйн болон зохицуулалтын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

- **Өгөгдлийн чанар ба нэгдмэл байдал:** Өгөгдлийг хянах, баталгаажуулах, дүн шинжилгээ хийх бодлого хангалтгүй байгаа нь өгөгдөл дээр үндэслэн шийдвэр гаргах үйл явц, байгууллагын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
- **Аюулгүй байдлын эрсдэл:** Хууль эрх зүйн орчин,

өгөгдлийн сангийн аюулгүй байдлын дотоод хяналт сул байгаа нь өгөгдөлд зөвшөөрөлгүй нэвтрэх, хадгалалт, хамгаалалт зөрчигдөх, хууль эрх зүйн сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байна.

- **Харилцаа, хамтын ажиллагаа хумигдах:** Нэгдмэл бус мэдээллийн стандарт нь салбар хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах, үндэсний нэгдсэн өгөгдлийн санг бий болгоход үйл явцыг саатуулж байна.
- **Үйл ажиллагааны үр ашиггүй байдал:** Программ хангамж хөгжүүлэлтийг хянах нэгдсэн горим тогтолцоо хөгжөөгүй, өгөгдлийг архивлах, устгах бодлого тодорхойгүй байгаа нь үйл ажиллагааны үр ашиггүй байдалд хүргэж, серверийн ачааллыг нэмэгдүүлж, өгөгдлийн санд зөвшөөрөлгүй хандалт хийх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

### Зөвлөмж:

#### 1. Үндэсний өгөгдлийн стандартыг хэрэгжүүлэх

Улсын хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн бүхий л салбарт өгөгдлийн удирдлагын хэрэгжилт, нийцтэй байдлыг хангах үүднээс Үндэсний мэдээллийн нэгдсэн стандартыг боловсруулж, батлахыг зөвлөж байна. Үүнд янз бүрийн эх сурвалжийн өгөгдлийн нэгэн жигд хэлбэр, бүтэц бий болгох, өгөгдлийн төрөл, хэмжилтийн нэгж, нэршлийг стандартчилах ажлууд хийгдэнэ. Өгөгдлийн нийтлэг стандарттай болсноор өгөгдлийн чанарын асуудалгүйгээр саадгүй нэгтгэн, боловсруулах боломжийг олгоно.

#### 2. Өгөгдлийг зохицуулах бодлого боловсруулж, өгөгдлийн засаглалыг хэрэгжүүлэх

Дээрх үл нийцлийг шийдвэрлэхийн тулд өгөгдлийн эзэмшил, хандалтын хяналт, аюулгүй байдлын арга хэмжээ зэрэг өгөгдлийн засаглалын зарчим, нууцлалыг хамгаалах арга хэмжээ, аюулгүй байдлын протоколуудыг багтаасан өгөгдлийн зохицуулалтын хатуу бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Ингэснээр өгөгдлийн амьдралын мөчлөгийн туршид чанар, бүрэн бүтэн байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлнэ.

#### 3. Нэгдсэн өгөгдлийн сан бүрдүүлэх хамтын ажиллагааг дэмжих

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд олон төрлийн өгөгдлийн багцыг нэгтгэсэн, ашиглагдах боломжтой өгөгдлийн санг бий болгохын тулд төрийн болон хувийн хэвшлийн бүхий л салбаруудын хамтын ажиллагааг бодлого тодорхойлогчийн зүгээс идэвхтэй дэмжихийг зөвлөж байна. Энэ ажлын хүрээнд өгөгдлийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв байдлыг сайжруулахад чиглэсэн, өөр өөр системүүд болон өгөгдлийн сангууд хоорондоо үр дүнтэй өгөгдөл солилцох боломжтой эсэхийг баталгаажуулах шаардлагатай бөгөөд ингэснээр төрөл бүрийн эх сурвалжаас авсан өгөгдлийг

саадгүй нэгтгэх боломжтой болох юм.

## ДАХИН СЭРГЭЭЛТИЙН НӨӨЦ

**Илрүүлэлт 1:** ҮДТ УТУГ-ын Дархан нөөц төвийн үйл ажиллагаа жигдрээгүй.

Үндэсний дата төвийн нөөц төв болох Дархан нөөц төв нь улсын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байгаа нь мэдээллийн технологийн удирдлагын дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах нөөц төвийн үүргээ биелүүлж чадахгүй байна.

**Эрсдэлийн түвшин: “Өндөр”**

**Үр нөлөө:**

- ҮДТ УТУГ-ын Дархан нөөц төв улсын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байгаа нь их хэмжээний эрсдэл дагуулж байна. Үндэсний Дата Төвд доголдол гарах, гэмтэл саатах үүссэн тохиолдолд нөөц төв улсын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байгаа нь нөөц төвөөр дамжуулан мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй болгож, мэдээллийн хүртээмж, үйлчилгээний тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

**Зөвлөмж:**

1. ҮДТ УТУГ-ын Дархан нөөц төвийг нэгдсэн сүлжээнд холбох найдвартай холболтыг бий болгож, тогтвортой ажиллах боломжийг хангана. Үндэсний Дата Төвтэй холбоотой гэмтэл, саатал гарсан тохиолдолд үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, тасралтгүй ажиллагааг хангах нөөц төвийн чадамжийг баталгаажуулахын тулд туршилтын үйл явцыг хугацаат ажлын цар хүрээнд хамруулах шаардлагатай.

**Илрүүлэлт 2:** Худаг сувагчлал дахь физик кабелийн ашиглалт хангалтгүй.

Нийслэлийн харилцаа холбооны дэд бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох худаг сувагчлал дахь физик кабелийн 73% буюу их хэмжээний физик кабелийн нөөц ашиглагдахгүй байгаа нь шууд нүүрлэх аюул биш ч ашиглалт хангалтгүй байгаа нь нөөцийн менежментийн үр ашиггүй байдлыг илтгэж байгаа бөгөөд цаашдаа шаардлагагүй зардал гарахад хүргэх эрсдэлтэй байна.

**Эрсдэлийн түвшин: “Дунд”**

**Үр нөлөө:**

- Хөрөнгө оруулалт, төсөв зарцуулсан нөөцийг дутуу ашиглах нь нөөцийг үр ашиггүй зарцуулалтыг бий болгож, нийслэлийн харилцаа

холбооны дэд бүтцийг хувьсан өөрчлөгдөж буй технологийн хэрэгцээ, мэдээллийн урсгалд дасан зохицоход эрсдэл учруулж байна.

**Зөвлөмж:**

1. Ашиглагдаагүй физик кабелийг үр дүнтэйгээр дахин хуваарилж, ашиглалтад оруулахын тулд одоогийн болон ирээдүйн харилцаа холбооны хэрэгцээнд тулгуурлан нарийвчилсан үнэлгээ хийх хэрэгцээ үүсэж байна. Харилцаа холбооны дэд бүтцийн нөөцийн ашиглалтыг оновчтой болгох идэвхтэй стратегийг хэрэгжүүлэх, цаг хугацааны явцад хэмнэлттэй, үр ашигтай байдлыг хангах чиглэлийг баримталж, технологийн дэвшил, өөрчлөгдөж буй шаардлагад нийцүүлэхийн тулд дэд бүтцийг тогтмол шалгаж, өөрчлөлт, сайжруулах боломжийг судлах шаардлагатай.

## БОДЛОГО, ЖУРАМ, СТРАТЕГИ

**Илрүүлэлт 1:** Цахим шилжилтийн үндэсний стратегийн баримт бичиг батлагдаагүй.

**Эрсдэлийн түвшин: “Өндөр”**

Цахим шилжилтийн талаар хуульчилсан үндэсний стратегийн баримт бичиг батлагдсан ч яамдууд болон харьяа байгууллагуудад мэдээллийн технологийн зорилтуудыг нэгдсэн бодлогоор ханган, үр дүнтэй, найдвартай хэрэгжүүлэх зохион байгуулалт дутагдалтай байна.

**Үр нөлөө:**

- Стратегийн удирдлага дутмаг байгаагаас мэдээллийн технологийн хүчин чармайлтууд талаар болох, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага хэрэгжихгүй, цахим шилжилтийн зарим санаачилгууд үр ашиггүй байдалд хүрч байгаа нь ажиглагдсан.

**Зөвлөмж:**

1. Цахим шилжилтийн санаачилга, хүчин чармайлтуудыг чухлын зэргээр эрэмбэлж, нэгдсэн удирдлагаар ханган, санхүүжилтийг шийдвэрлэхийн тулд үндэсний стратегийн баримт бичгийг яаралтай эрэмбэлж, хууль эрх зүйн зөвшөөрөл авах.

**Илрүүлэлт 2:** Төрийн энтерпрайс архитектур батлагдаагүй

**Эрсдэлийн түвшин: “Өндөр”**

Төрийн энтерпрайс архитектур байхгүй байгаа нь төрийн байгууллагуудын мэдээллийн системийг уялдуулах, нэгтгэх ажлыг хийх боломжгүй болгож байна.

**Үр нөлөө:**

- Салбарын хэмжээнд мэдээлэл солилцох, харилцаа хамтын ажиллагааг хангах боломжгүй, үйл явцын давхардал үүсэх, мэдээллийн технологийн дэд бүтцийн зохион байгуулалтыг оновчтой хийх боломжгүй эрсдэл үүсэж байна.

**Зөвлөмж:**

1. Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн үр ашиг, хоорондын уялдаатай байдлыг нэмэгдүүлэх үүднээс төрийн нэгдсэн архитектурыг хөгжүүлэх ажлыг төслийн аргазүйгээр гүйцэтгэх шаардлагатай байна.

**Илрүүлэлт 3: Мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээний бодлого, журам батлагдаагүй.**

Мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээн дээр үндэслэн эрсдэлийг бууруулах бодлого байхгүй байгаагаас МТ-тэй холбоотой болзошгүй эрсдэлийн талаар авах арга хэмжээ тодорхойгүй байна.

**Эрсдэлийн түвшин: “Өндөр”****Үр нөлөө:**

- Эрсдэлийн үнэлгээний системчилсэн үйл явцгүйгээр урьдчилан тооцоолоогүй аюул, халдлага зөрчилд өртөмтгий байдал нэмэгдэж, гэмтэл саатлын дараа хийгдэх сэргээлтийн төлөвлөгөөг тодорхойлоогүй тул төрийн үйлчилгээний мэдээллийн системүүдийн бүрэн бүтэн, найдвартай байдал, тасралтгүй ажиллагаа хангагдах баталгаа байхгүй байна.

**Зөвлөмж:**

1. Төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн технологийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлж, удирдах зорилгоор мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг журмыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Илрүүлэлт 4: Хууль, журмын нэр томъёоны зөрүүтэй байдал.**

Нийтлэг журам болон хуулийн нэр томъёоны хооронд зөрүү үүссэнээс болж мэдээллийн технологийн холбогдох журам, горимуудыг цахим орчинд хайж олох, ашиглахад будлиантай, тодорхой бус байдал үүсэж байна. Энэхүү төвөгтэй байдал нь хууль, журмын зүйл заалт мөрдөгдөхгүй байх, мэдээллийн технологийн орчны ерөнхий аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна

**Үр нөлөө:**

- МТ-ийн нийтлэг дүрэм, журмыг дагаж мөрдөхгүй байх эрсдэл нэмэгдсэнээр байгууллагад аюулгүй байдлын сул талыг бий болгож, кибер халдлага зөрчил, хууль эрх зүйн үр дагавар, өгөгдлийн эрх зөрчигдөх эмзэг байдлыг бий болгож байна.

**Зөвлөмж:**

1. Мэдээллийн технологийн хууль, журамтай холбоотой хууль эрхзүйн цахим мэдээллийн үнэн зөв байдлыг ханган холбогдох журамд заасан эрх зүйн нэршилд нийцүүлэх шаардлагатай байна. Үүнд нийтлэг журмуудыг [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) дээр тодорхой, үнэн зөв оруулсан байх, хэрэглэгчид саадгүй хандах, хайж олох, хэрэгжүүлэх боломжтой байна. Мөн холбогдох хууль, журмын зүйл заалт, шаардлагуудын өөрчлөлттэй байнгын уялдаа холбоог хангахын хянаж, шинэчлэх үйл явцыг хэрэгжүүлж хэвших шаардлагатай.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЦЭЭГ  
ТОДОРХОЙЛОХ, ЧИГЛҮҮЛЭХ, ХЯНАХ****Илрүүлэлт 1: Зохион байгуулалт****1. Салбарын хэмжээнд МТ хариуцсан нэгжийн удирдлагуудын чиг үүргийн ялгаатай байдал:**

Түүвэрт хамрагдсан яамнуудад МТ хариуцсан нэгжийн удирдлагууд харилцан адилгүй чиг үүрэгтэй байгаа нь мэдээллийн технологийн салбарыг удирдлага, зохицуулалтаар хангах суурь стандарт хэрэгжихгүй байхад хүргэж байна.

**Эрсдэлийн түвшин: “Дунд”****Үр нөлөө:**

- МТ-ийн удирдлагын чиг үүргийн төлөвшил нэгдсэн байдлаар тогтоогүй, олон янзын арга барилтай байх нь салбарын хэмжээнд мэдээллийн технологийн удирдлага, засаглалын стандартгүй байхад нөлөөлж, МТ-ийн удирдлагаас хүлээх албан хаагчид, оролцогч талуудын хүлээлт өөр байгаагаас үйл ажиллагааны үр ашиггүй байдал бий болж байна.

**Зөвлөмж:**

1. Мэдээллийн технологийн удирдлагын тогтвортой байдал, үр дүнтэй үйл ажиллагааг хангахын тулд төрийн байгууллагуудад МТ нэгж хариуцсан удирдлагын үүрэг, ажлын байрны чиг үүргийн суурь стандартыг тогтоох шаардлагатай байна.

**2. Шалгагдагч байгууллагуудад МТ-ийн нэгжүүд харилцан адилгүй зохион байгуулалттай байна.**

Шалгагдагч байгууллагуудад статистикийн дүн шинжилгээ хариуцсан нэгж, мэдээллийн технологийн нэгжүүдийг нэгтгэх байдлаар МТ хариуцсан нэгжийн бүтцийг хавсарсан байдлаар, бусад чиг үүргийн нэгжтэй нэгтгэх зэргээр харилцан адилгүй зохион байгуулж байгаа нь нэгжийн үндсэн үйл ажиллагааны цар хүрээг хэт томруулж, МТ-ийн үйл ажиллагаагаар дагнасан зохион байгуулалттай нэгжүүдтэй харьцуулахад үйл ажиллагааны тодорхой бус байдал, гүйцэтгэл чанаргүй байх нийтлэг сул талууд илэрч байна.

### Эрсдэлийн түвшин: “Дунд”

#### Үр нөлөө:

- МТ-ийн чиглэсэн үйл ажиллагааны чанар, зохицуулалт, нөөцийн ашиглалт алдагдах эрсдэл үүсэж байна.

#### Зөвлөмж:

1. МТ-ийн бүтцийн нэгжийн үр нөлөөг бодитоор үнэлж, үр ашиг, нөөцийн хуваарилалт, хариуцлагын тогтолцоог сайжруулах үүднээс нэгжийг бие даасан хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай.

### Илрүүлэлт 2: Мэдээллийн технологийн нийлүүлэлтийн удирдлага

**МТ-ийн үйлчилгээ үзүүлэгчдэд хариуцлага тооцдог, чанарт чиглэсэн өрсөлдөөнт орчин бүрдээгүй байна:** МТ-ийн үйлчилгээ үзүүлэгчид, бүтээгдэхүүн нийлүүлэгчдэд чанар дээр суурилсан хариуцлага, урамшуулал тооцох өрсөлдөөнт орчин бүрдээгүй байгаа нь МТ-ийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөгөө болон эцсийн үр дүн зөрөх, нийлүүлсэн технологийн бүтээгдэхүүн дээр чанарын үл тохирол гарах тохиолдол салбарын хэмжээнд нийтлэг байгаа нь ажиглагдсан.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Төслийн үр дүн оновчтой бус байх, төсвийн үр ашиггүй зарцуулалт, эцсийн хэрэглэгчийн хүлээлтийг хангахгүй мэдээллийн систем, чанаргүй МТ-ийн бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд тухайн үйлдэлд хариуцлага тооцох механизм, эрхзүйн зохицуулалт бүрдээгүй байгаагаас чанаргүй бэлтгэн нийлүүлэгчдэд хариуцлага тооцох боломжгүй болж, хохирлын хэмжээ үргэлжлэн нэмэгддэг.

#### Зөвлөмж:

1. Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгчдийн үнэлгээ, зэрэглэлийн тогтолцоог

нэвтрүүлж, чанарт чиглэсэн өрсөлдөөнийг бий болгож, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар хэрэглэгчдэд ил тод мэдээлэх замаар өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх хэрэгцээтэй байна. Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгчдийн гүйцэтгэлийг захиалагчаар үнэлүүлэн, бүртгэлжүүлэх нь чанаргүй нийлүүлэгчдийг зах зээлээс шахах, чанартай нийлүүлэгчдийг боломжит захиалагчдад таниулах ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл чанарын хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгосноор төсвийн арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулалтыг дэмжих ач холбогдолтой байна.

### Илрүүлэлт 3: Мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох

**IPv6 технологийн талаарх судалгаа:** Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой төлөвлөлт, судалгаа, хувилбарын харьцуулсан үнэлгээ хангалтгүй байгаа нь нэвтрүүлэлт, хэрэгжилтийг буруу хийгдэх эрсдэл үүсгэж байна. Тухайлбал, интернэт хаягжилтыг IPv6-д шилжүүлэх батлагдсан төлөвлөгөө байхгүй байгаа нь шилжилтийг зардал үр ашгийн хувьд өгөөжтэй эсэх, шилжилтийн хүрээнд хийгдэх технологийн өөрчлөлтийг санхүүжүүлэх төсөв нөөц хүрэлцээтэй эсэхэд эргэлзээг төрүүлж байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Мэдээллийн технологийн шинэчлэл, өөрчлөлтийг хэрхэн хийх үйл явцын төлөвлөгөө тодорхой бус байгаа нь төслийн саатал, үр ашиггүй байдалд хүргэдэг эрсдэлтэй. Интернэт хаягжилтыг IPv6-д шилжүүлэх ажлыг нарийн төлөвлөлтгүйгээр эхлүүлэх нь улсын хэмжээнд интернэтийн дэд бүтцийн нийцтэй байдал, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна.

#### Зөвлөмж:

1. Мэдээллийн технологийн төслүүдийг хэрэгжүүлэх явцад үнэн зөв мэдээлэл цуглуулах, төслийн ТЭЗҮ-ийг тодорхой гаргах, ил тод байдлыг хангах зорилгоор цогц судалгаа явуулах шаардлагатай. Монгол Улсын интернэт хаягжилтыг IPv6 хувилбарт шилжүүлэх төлөвлөгөө-г төслийн ТЭЗҮ, зардал үр ашгийн шинжилгээг нарийн гүйцэтгэсний үндсэн дээр холбогдох талуудаар батлуулах шаардлагатай байна.

## ТОХИРГООНЫ УДИРДЛАГА

### Илрүүлэлт: Өөрчлөлтийн удирдлага

Тохиргооны удирдлагын өнөөгийн байдалд үүрэг, хариуцлагын талаар нарийн тодорхойлж, нэгтгэсэн тогтолцоо байхгүй байна. Тагнуулын ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын хэлтсээс тохиргооны удирдлага, сүлжээ хангамжийн өөрчлөлт, шинэ программ хангамжид эрсдэлийн үнэлгээ хийж, зөвлөмж өгдөг ч эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хяналтын үйл явц байхгүйгээс зөвлөмжийн мөрөөр сайжруулалт хийгдэж байгаа эсэхийг хянах боломжгүй байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Үйл ажиллагааны үр ашиггүй байдал: Тодорхой үүрэг хариуцлагыг оноож өгөөгүй тохиолдолд биелэлтийг хангуулах механизм байхгүйгээс тохиргоо, өөрчлөлтийн удирдлагыг зохих түвшинд хүртэл хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байна.
- Аюулгүй байдлын сул тал: Кибер аюулгүй байдлын зөвлөмжийг хэрэгжүүлэх хяналтын үйл явц байхгүйгээс сүлжээ, программ хангамжийн аюулгүй байдлыг хангах ажил зохих түвшинд хүртэл хийгдэхгүй байгаа нь байгууллагын кибер аюулд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Тохиргооны удирдлага: Шалгагдагч байгууллагуудад тохиргоо, өөрчлөлтийн удирдлагын тогтсон чиг хандлага байхгүйгээс тохиргооны удирдлагад тавигдах шаардлага, стандартыг дагаж мөрдөхгүй байгаа нь хууль эрх зүйн үр дагавраас гадна байгууллагад хохирол учруулах, үр ашиггүй ажиллагааг бий болгох эрсдэлтэй байна

#### Зөвлөмж:

1. **Үүрэг, хариуцлагыг тодорхойлж, нэгтгэх:** Тохиргоо, өөрчлөлтийн удирдлагад оролцож буй албан хаагчдын эрх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлж, нэгтгэсэн засаглалын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.
2. **Хяналтын үйл явцыг хэрэгжүүлэх:** ТЕГ-ийн Кибер аюулгүй байдлын хэлтсээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах найдвартай хяналтын үйл явцыг боловсруулж, хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулалтыг хангах үүднээс хэрэгжсэн зөвлөмжийн байдлыг тогтмол үнэлж, тайлагнах шаардлагатай.
3. **Харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах:** Байгууллагын үйл явцуудыг оновчтой болгох, харилцааг үр дүнтэй байлгах үүднээс тохиргооны удирдлагын оролцогч талуудын харилцаа холбоо, хамтын ажиллагааг

идэвхжүүлэх шаардлагатай.

4. **Хяналтын автоматжуулалт:** Аюулгүй байдлын болзошгүй эрсдэлийг цаг тухайд нь тодорхойлох, хариу арга хэмжээ авах, тохиргооны өөрчлөлтийг бодит цагаар хянах, тайлагнах ажлыг хөнгөвчлөх автоматжуулалтын хэрэгслийг ашиглах талаар судалж, хэрэгжүүлэх шаардлагатай.
5. **Сургалт мэдээлэл:** Кибер аюулгүй байдлын зөвлөмжийг дагаж мөрдөхийн ач холбогдлын талаарх ойлголтыг сайжруулахын тулд тохиргоо, өөрчлөлтийн менежментэд оролцогч албан хаагчдад сургалт хийж, мэдээлэл олгох шаардлагатай.
6. **Тогтмол аудит:** Шинээр бий болсон үүрэг, хариуцлага, хяналтын үйл явцын үр нөлөөг үнэлэх зорилгоор дотоод аудитыг тогтмол хийж, өөрчлөлтийн удирдлагын аргагүйг улам боловсронгуй болгож, сайжруулахад аудитын үр дүнг ашиглах шаардлагатай.

## ГЭМТЭЛ СААТЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН УДИРДЛАГА

### Илрүүлэлт: Гэмтэл саатын шийдвэрлэлтийн удирдлага

Шаардлагатай мэдээлэл, өгөгдлийн нөөц, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг сэргээхийн тулд үйл ажиллагааны үйл явцуудыг эрсдэлд суурилан тодорхойлсон гэмтэл саатын шийдвэрлэлтийн төлөвлөгөөг бий болгох нь аливаа байгууллагын, ялангуяа улсын хэмжээнд салбарын бодлого тодорхойлох, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулдаг, үндэсний аюулгүй байдалтай холбоотой ажлын урсгалуудад мэдээллийн технологийг ашигладаг ЦХХХЯ-д зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа юм. ЦХХХЯ-д шаардлагатай тохиолдолд гэмтэл саатал, гамшгаас хамгаалах үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нэгж, албан тушаалтан, баримтжуулсан бодлого, төлөвлөгөө байхгүй болохыг аудитын явцад олж тогтоосон. Түүнчлэн алдаа зөрчлийн тохиолдлуудыг бүртгэлжүүлэн шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах үйл явц төлөвшөөгүй байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Өгөгдлийг нөөцлөх, сэргээх тогтсон журам байхгүй тул гэмтэл саатал, гамшгийн үед их хэмжээний өгөгдөл алдагдахад хүргэж, байгууллага төдийгүй салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлтэй.
- Гэмтэл саатал тохиолдсон үед мэдээллийн системийн үйл ажиллагааг хэвийн хадгалах, эргэн сэргээх тогтоосон протокол байхгүй тул удаан хугацаагаар сул зогсолт хийн, байгууллага/



салбарын үйл ажиллагааг алдагдуулж, нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

- Хууль, бодлого, журмын нийцэл хангагдахгүй байх.
- Сонирхогч талуудын итгэлийг бууруулж, байгууллага/салбар/гадаад түншүүдийн харилцаа, хамтын ажиллагааны нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Гэмтэл саатлыг шийдвэрлэх төлөвлөгөө болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө байхгүйгээс гэмтэл саатлын улмаас системийг дахин сэргээх DRP болон BCP байхгүй тохиолдолд нөхөн сэргээх хүчин чармайлт нь түр зуурын бөгөөд үр ашиггүй байж болно. Энэ нь удаан зогсолт, ажиллах хүчний зардал нэмэгдэх, шинэ техник хангамж эсвэл дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ зэргээс шалтгаалан нөхөн сэргээх зардал нэмэгдэхэд хүргэдэг.
- Үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө байхгүйгээс үйл явцын тасалдлыг шийдвэрлэхэд бэлтгэл муутай байж болох тул үйл ажиллагаанд шат дамжлагатай нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

#### Зөвлөмж:

Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн журам, төлөвлөгөөтэй (DRP, BCP) болох

1. Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн журмыг нарийвчлан тодорхойлсон, үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагын бүтэц зохион байгуулалттай байх ёстой бөгөөд энэ чиг үүргийг хянах хариуцлагатай албан хаагчдыг томилох шаардлагатай.
2. Гэмтэл саатлын шийдвэрлэлтийн төлөвлөгөөг тогтмол түршиж, шинэчлэх нь эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хэсэг болно.
3. Гэмтэл саатлыг шийдвэрлэлтийн төлөвлөгөө (DRP) болон үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө (BCP) байхгүй байгаа нь тухайн байгууллага болон салбарын хэмжээнд өгөгдөл, мэдээллийн алдагдал, санхүүгийн алдагдал, хууль эрх зүйн асуудал, нэр хүндэд хохирол учруулах зэрэг олон төрлийн эрсдэлд оруулж болзошгүй юм. Эдгээр эрсдэлийг бууруулах, гэнэтийн осол саатлын үед үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварыг баталгаажуулахын тулд эдгээр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхийг байгууллагад зөвлөж байна.
4. Асуудлын бүртгэлийг гүйцэтгэлийн үзүүлэлттэй уялдуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

## НИЙЛҮҮЛЭЛТИЙН УДИРДАГА

**Илрүүлэлт:** Худалдан авалт, бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн удирдлага дутагдалтай

- Бэлтгэн нийлүүлэгчийн үйлчилгээний удирдлага
- Худалдан авалтын удирдлага

Худалдан авалт ба бусдаар гүйцэтгүүлэх ажил (outsourcing)-ийн удирдлага хэрэгждэггүйгээс үр ашиг муутай, чанаргүй худалдан авалт хийгдэж байна.

#### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

Мэдээллийн системийг гаднын гэрээлэгчээр хөгжүүлэлт хийлгэж байгаа тохиолдолд байгууллагын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, өгөгдлийн эрх, кибер аюулгүй байдал, хөгжүүлсэн системийг өмчлөх эрх, зардал зэрэг заавал оруулах чухал элементүүдийг үйлчилгээний түвшний гэрээнд (SLA) тусгахгүй байгаа нь байгууллагад ихээхэн эрсдэл учруулж байна.

#### Үр нөлөө:

- Дээрх заавал байх ёстой элементүүдийн талаар тодорхой заалтыг тусгаагүйгээс байгууллага болон бэлтгэн нийлүүлэгчийн хооронд өгөгдлийн эрх, хөгжүүлсэн системийн өмчлөлийн талаар маргаан үүсэх, түүнчлэн гэнэтийн тасалдал, системийн доголдол, өөрчлөлт шинэчлэлийг шийдвэрлэх хариуцагчийг гэрээнд нарийн тусгаагүйгээс захиалагч байгууллага хохирох, төсвийн үр ашиггүй зарцуулалт бий болох эрсдэл үүсэж байна. Зардал үр ашиг, системийн шийдлийг сонгох хувилбарын үнэлгээ хийх үйл явц байхгүй байгаа нь энэ эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж, байгууллагыг оновчтой бус нийлүүлэгч сонгох, нийлүүлэгчээс чанаргүй, үр ашиггүй систем хүлээн авах эрсдэлийг мөн нэмэгдүүлж байна. Үйлчилгээний түвшний гэрээнд иж бүрэн заалт тусгаж өгөөгүйгээс МТ-той холбоотой үйл ажиллагааны тасалдал, санхүүгийн үр ашиггүй байдал, гэнэтийн зардал гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Худалдан авалтын нэгдсэн бодлого байхгүйгээс үүдэн дараах бэрхшээлүүд тулгарч байна:
- Худалдан авалтын тендерийг нэгдсэн байдлаар зохион байгуулагдахгүй, шалгагдагч яамд тус тусдаа зарласнаар цөөн тоо ширхэгтэй, бага үнийн дүнтэй тендер дээр нийлүүлэлтийн санал орж ирдэггүй, ирж байгаа нь чанаргүй байдгаас ТЕГ-ийн зөвшөөрөл гарахгүй тендер буцаагдаж үр ашиггүй ажиллагаа бий болж байна.
- Худалдан авалтын техникийн шаардлагыг

хэт дэлгэрэнгүй оруулах нь эргээд халдлага, зөрчлийн эрсдэлийг үүсгэж байгаа бол худалдан авалтын шаардлага тодорхой бус байх нь шударга өрсөлдөөн, ашиг сонирхлоос ангид байх худалдан авалтын журмыг хангаж чадахгүйд хүрч байгаа тул зохицуулалт шаардлагатай байна.

### Зөвлөмж:

1. Үйлчилгээний түвшний гэрээний төслийг сайжруулах: Үйлчилгээний түвшний гэрээ нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, өгөгдлийн эрх, аюулгүй байдлын арга хэмжээ, эцсийн бүтээгдэхүүний өмчлөх эрх, үйл ажиллагаа ба цалингийн зардлыг тодорхой тусгасан байх ёстой.
2. Шинжилгээний үйл явцыг хэрэгжүүлэх: Дотоод болон гадаад нийлүүлэгчдийн боломжит хувилбаруудыг харгалзан зардал үр ашгийн шинжилгээ, системийн шийдлийг сонгох үйл явцыг бий болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай. Ингэснээр мэдээлэлтэй шийдвэр гаргаж, нөөцийн ашиглалтыг оновчтой болгоно.
3. Худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах: Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах талаар цогц, нэгдсэн бодлогыг бий болгох шаардлагатай байна. Тус бодлогод хэт нарийвчилсан техникийн шалгуур үзүүлэлтүүд болон худалдан авалтын тодорхой бус шаардлагуудын аль алиныг тусгахаас сэргийлэх үүднээс техникийн шаардлагуудыг тэнцвэржүүлэх ёстой.
4. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах: Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах арга хэмжээг нэвтрүүлж хэвших шаардлагатай. Үүнд шударга өрсөлдөөнийг дэмжих, нэг талыг баримтлахаас урьдчилан сэргийлэх, кибер халдлага, зөрчлийн эрсдэлийг бууруулах зорилгоор худалдан авалтын тодорхой, хоёрдмол утгагүй шаардлагууд багтана.
5. Аудит ба нийцлийн үнэлгээг тогтмол хэрэгжүүлэх: Өөрчлөлтийн удирдлагыг дагаж мөрдөж байгаа эсэхийг үнэлэх, сайжруулах шинэ чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор тогтмол аудит хийж хэвших нь мэдээллийн технологийн худалдан авалт, бусдаар гүйцэтгүүлэх ажил (outsourcing)-ийн менежментийг өөрчлөлтийн удирдлагаар хангах ач холбогдолтой.

## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АУДИТ ХИЙХ ЗОХИЦУУЛАЛТ

**Илрүүлэлт:** Мэдээллийн аюулгүй байдлын аудитын зохицуулалт

- Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд болон төрийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагууд ЦХХХЯ-д бүртгэлтэй хуулийн этгээдээр хөндлөнгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх зохицуулалт байгаа ч тухайн мэдээллийн аюулгүй байдлын аудитын шалгуур, үр дүн, зөвлөмж, албан шаардлагын мэдээллийг баталгаажуулах мэдээллийн нэгдсэн систем байхгүй байгаа нь аудитын баталгаажуулалт хангагдахгүй байх эрсдэлтэй байна. Дээрх эрсдэлээс үүдэн аудитын үйл ажиллагаанд бодит цагийн хяналт тавих, аудитын эрсдэлийг удирдах боломжгүй нөхцөл үүсэж байна.
- Зөвлөх үйлчилгээ үзүүлснээс хойш хоёр жилийн хугацаанд тухайн байгууллагадаа аудит хийхийг хориглох журмын хяналтын механизм тодорхойгүй байгаа нь журмын хэрэгжилт хангагдах эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Мэдээллийн системээр кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг бүртгэлжүүлэх механизм байхгүй байгаагаас эрсдэлийг шийдвэрлэх, зөвлөмжийн биелэлтийг хянах боломжгүй байна. Аудитын тайлангийн чанарт тавигдах хяналт байхгүй, зөвлөх үйлчилгээ авсан байгууллагад 2 жилийн хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээд нь мэдээллийн аюулгүй байдлын аудит хийхгүй байх хоригийг хэрэгжүүлэх механизм тодорхой бус байгаа нь аудитын үйл явцын найдвартай байдлыг хангахгүй, кибер аюулгүй байдлын арга хэмжээний ерөнхий үр нөлөөг алдагдуулж болзошгүй байна.

#### Зөвлөмж:

##### 1. Мэдээллийн системд аудитыг бүртгэлжүүлэх:

Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд болон бусад төрийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх үйл ажиллагааг хөнгөвчлөх, баталгаажуулалтыг хангах, бодит цагийн хяналт хийх боломжтой, үр дүнтэй мэдээлэл цуглуулах ажлыг дэмжсэн нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлэх шаардлагатай.

##### 2. Чанарын хяналтын механизмыг бий болгох:

Аудитын тайлангийн чанарын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж, албан тушаалтныг тодорхойлж, аудитын дүгнэлтийн үнэн зөв, найдвартай байдлыг хангаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай.

##### 3. Хяналтын механизмыг баталгаажуулах:

Зөвлөх үйлчилгээ үзүүлснээс хойш хоёр жилийн дотор хуулийн этгээд тухайн байгууллагадаа мэдээллийн аюулгүй байдлын аудит хийхийг хориглосон заалтын хяналтын механизмыг тодорхой

болгож, хэрэгжилтийг Зөвлөмж 1-д дурдсан нэгдсэн мэдээллийн системээр хангуулах боломжтой байна.

#### 4. Журмын хяналтыг сайжруулах:

Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх зорилгоор үйл явцад тогтмол аудит хийн, тогтоосон дүрэм журмыг мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулна.

#### 5. Оролцогч талуудтай хамтран ажиллах:

Кибер аюулгүй байдлын цогц, үр дүнтэй арга барилыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох оролцогч талуудтай хамтран ажиллана. Удирдамж, дүрэм журмыг хэрэгжихүйц байдлаар батлах үүднээс салбарын мэргэжилтнүүдийн саналыг журмын төсөлдөө тусгах шаардлагатай байна.

## ХӨРӨНГИЙН УДИРДААГА

### Ирүүлэлт 1: Мэдлэгийн удирдлага хэрэгждэггүй.

Байгууллагын мэдлэгийг удирдах зохион байгуулалттай, системчилсэн арга зүй байхгүй байгаагаас байгууллага улсын төсвийг зарцуулж бий болгосон оюуны капитал болох төсөл хөтөлбөр, судалгааны үр дүнгийн тайлан, нэгтгэлийг шаардлагатай үедээ ашиглаж чадахгүй байгаа нь үйл ажиллагааны үр ашигт сөргөөр нөлөөлж байгаа нь тогтоогдсон.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Байгууллагын мэдлэг удирдлагын тогтолцоо байхгүй байгаа нь биет бус хөрөнгөө ашиглаж чадаагүйгээс үүдсэн үйл ажиллагааны алдагдал, давхардалд хүргэж байна.
- Мэдлэгийн нөөцөө үр ашигтайгаар ашиглахгүй байснаар оновчтой бус шийдвэр гаргах, инновацыг бууруулах, судалгаа шинжилгээний үр ашиггүй зардал гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

#### Зөвлөмж:

1. Зөвлөх үйлчилгээ, судалгаа, дотоод үйл ажиллагааны үр дүнд бий болсон мэдлэгийг бүртгэлжүүлэх, баримтжуулах, хуваалцах, ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээллийн системийг ашиглах, байгууллагын нөөц төлөвлөлтийн системд мэдлэгийн удирдлагын системийг нэгтгэх шийдэл, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### Ирүүлэлт 2: Мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлагын бодлого

ҮДТ УТҮГ нь ашиглалтын хугацаа дуусаж, үйлдвэрлэхээ зогсоосон 2008 онд үйлдвэрлэсэн

Cisco Nexus 7010 switch-ийг нөөцгүй, дангаар нь Монголын интернэтийн харилцан холболтын үйлчилгээнд ашиглаж байгаа нь төхөөрөмжийн элэгдэл, нөөц шийдэл байхгүй шалтгаануудаас үүдсэн үйл ажиллагаа, харилцаа холбооны тасралтгүй байдлыг хангахад ноцтой эрсдэл үүсгэж байна. Мэдээллийн технологийн хөрөнгийн менежментийн бодлого байхгүй нөхцөлд элэгдсэн, нэн чухал тоног төхөөрөмжийг зохих засвар үйлчилгээ, нөөцлөх шийдэлгүй ашиглаж байгаа нь ҮДТ УТҮГ-ын үйл ажиллагаанд буюу үндэсний хэмжээнд мэдээлэл, харилцаа, холбооны зохицуулалтад хөрөнгийн удирдлагын бодлого, чиглэл дутагдаж байгааг харуулж байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

Үндэсний дата төвд өндөр эрсдэлтэй, хуучирсан тоног төхөөрөмж ашиглах нь үйлчилгээний тасалдал, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, үйлчилгээний түвшний гэрээг биелүүлэх боломжгүй болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

#### Зөвлөмж:

1. Үйлдвэрлэгчээс тогтоосон тоног төхөөрөмжийн насжилтыг харгалзан, шаардлагатай бол акт тогтоон хуучирсан тоног төхөөрөмжийг цаг тухайд нь солих, шинэчлэлт хийх, чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нөөц шийдлүүдийг бий болгох зорилгоор мэдээллийн технологийн хөрөнгийн удирдлагын оновчтой бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийж, төхөөрөмжийн ашиглалттай холбоотой ноцтой эрсдэлийг бууруулахын тулд тоног төхөөрөмжийн шинэчлэлийн санхүүжилтийг нэн даруй шийдвэрлэх нь цаашид хохирлын цар хүрээ томрохоос сэргийлнэ.
3. Үйлчилгээний тасалдаас урьдчилан сэргийлэх, Үндэсний Дата Төвийн найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд өндөр эрсдэлтэй бүх тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээний идэвхтэй төлөвлөгөөг гаргах шаардлагатай.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Ирүүлэлт:** Хүний нөөцийн нөхөн дүүргэлт, шилжилт хөдөлгөөн, сургалт хөгжлийн удирдлага хангалтгүй байна.

- Хүний нөөцийн бодлого
  - Хүний нөөцийн сургалтын бодлого
- Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн зэрэг ажлын байрны эрэлт өндөр байгаа албан хаагчдыг салбарын хэмжээнд мэдээллийн технологийн нэгжүүдийн хооронд

зэрэг дэв, тусгай хангамжийн зөрүүгүйгээр сэлгэн ажиллуулах, харилцан солилцоог сайжруулах шаардлагатай байгааг аудитын дүгнэлтээр онцолж, “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх 2023-2026” төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь дээрх мэргэжлийн эрэлтийг хангах тодорхой алхам болж байна гэж дүгнэж байна. Түүнчлэн сургалт, хөгжлийн төсөлд хамрагдагчдын үүрэг, хариуцлагыг хангуулах тодорхой тогтолцоо байхгүй байгаа нь хүний нөөцийн ашиглалтын үр ашиггүй байдлыг харуулж байна. Эрэлттэй байгаа ажлын байрны чиг үүргийн дагуу мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдыг төрийн албанд томилон ажиллуулах эрх зүйн орчин шаардлагатай байгааг онцолж байна.

### Эрсдэлийн түвшин: “Өндөр”

#### Үр нөлөө:

- Сургалт, төсөлд хамрагдаж байгаа албан хаагчдаас чанар, үр дүнгийн хариуцлага шаардах тогтолцоо байхгүйгээс үр ашиггүй байдал, төслийн бүтэлгүйтэлд хүргэх эрсдэл гарч байна.
- Сургалт, төсөлд хамрагдсан албан хаагчдыг шаардлагатай ажлын байранд шууд томилох эрх зүйн орчин бүрдээгүй байгаагаас төрийн албанд шинээр бий болсон үр чадварын нөөцийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүйд хүрч байна.



#### Зөвлөмж:

1. “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх 2023-2026” сургалтын төсөлд хамрагдаж буй албан хаагчид эргээд төрд тогтвортой ажиллах хууль эрхзүйн нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх.
2. Сургалт, төсөлд хамрагдсан албан хаагчдын

үүрэг, хүлээлтийг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог тодорхойлж хэрэгжүүлэх.

3. Сургалтад хамрагдсан албан хаагчдыг төрийн албан тушаалд томилох, шинээр олж авсан үр чадвараа үр дүнтэй ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.
4. Мэдээллийн технологийн орчин болон төрийн салбарын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад дасан зохицох нөхцөл, үүрэг хариуцлага, хууль эрх зүйн орчныг тогтмол хянаж, өөрчлөлт, шинэчлэлийг цаг үетэй нь уялдуулан хийж хэвших шаардлага үүсэж байна.

### Хавсралт 3.3

#### Түүвэрт хамрагдсан байгууллагуудаас авсан судалгааны нэгтгэл

#### НЭГ. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай эсэх

Байгууллага	Хариулт	Он	Тушаал
БХБЯ	Тийм	2017	ТНБД-ын А/125 дугаар тушаал
БШУЯ	Үгүй	2023	БСШУС-н 488 дугаар тушаалын 3-р хавсралт
Сангийн яам	Тийм	2014	Сангийн яамны мэдээллийн технологийн цогц журмын 5-р бүлэг "Мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт"-д тусгаж өгсөн
ХНХЯ	Тийм	2012	ТНБД-ын "Мэдээллийн технологийн аюулгүй байдлын бодлого" тушаал
ЭЗХЯ	Үгүй	2018	Тус яам 2022 оны 01 сард байгуулагдсан.
ЭМЯ	Тийм	2019	ЭМС-ын А/396 дугаар "Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдлын журам" батлах тухай тушаал

Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын дагуу "Кибер аюулгүй байдлын дотоод журам"-ын төслийг 2 байгууллага боловсруулан, хянах, санал авах шатанд ажил явагдаж байгаа бол бусад 4 байгууллага "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-д нийцүүлэн шинэчлэн, батлах шаардлагатай байна.



Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгж болон ажилтантай эсэх

№	Байгууллага	Хариулт	Нэгжийн нэр	Хариуцсан мэргэжилтэн
1	БХБЯ	Үгүй	Статистик, мэдээлэл технологийн хэлтэс	Мэдээллийн аюулгүй байдлыг давхар хариуцаж байна
2	БШУЯ	Тийм	• Цахим бодлого, статистик мэдээллийн газар • Төрийн захиргаа, удирдлагын газар	Одоогоор хүн томилогдоогүй
3	Сангийн яам	Тийм	Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтэс	Одоогоор хүн томилогдоогүй
4	ХНХЯ	Үгүй	Мэдээлэл технологи, статистикийн хэлтэс	Мэдээллийн аюулгүй байдлыг давхар хариуцаж байна
5	ЭЗХЯ	Үгүй	• Төрийн захиргаа, удирдлагын газар • Инновацийн бодлогын газар	Мэдээллийн аюулгүй байдлыг давхар хариуцаж байна
6	ЭМЯ	Үгүй	Судалгаа, төлөвлөлтийн хэлтэс	Мэдээллийн аюулгүй байдлыг давхар хариуцаж байна

#### Мэдээлэл технологийн нэгжийн зохион байгуулалтын хувьд:

- Мэдээллийн технологийн чиг үүргийн бүтцийн хувьд салангид, ачаалал жигд бус (2);
- Мэдээлэл технологийн чиглэлийн дагнасан нэгжгүй (1);
- Статистик, мэдээлэл технологийн чиглэлийг хавсарсан үйл ажиллагаа явуулж буй (2).

#### Кибер аюулгүй байдлын хүний нөөцийн зохион байгуулалтыг хувьд:

- Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан орон тоо батлагдсан боловч одоогоор мэргэжилтэн томилогдоогүй (2);
- Мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг хавсран хариуцаж буй (4).

Түүвэрт хамрагдсан байгууллагуудын кибер халдлага, зөрчлийн талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны нэгтгэсэн үзүүлэлт



**Түүвэрт хамрагдсан байгууллагуудын кибер халдлага, зөрчлийн талаарх судалгааны дүнгээс үзвэл:**

- Түүвэрт хамрагдсан байгууллагуудаас кибер зөрчлийн бүртгэлтэй байгууллага 2, бусад нь бүртгэл хийгддэггүй гэж хариулсан байна.
- Түүвэрт хамрагдсан байгууллагууд нь албан ёсны эрхтэй галт хана /Firewall/ аюулгүй байдлын төхөөрөмж, хортой код илрүүлэх /Endpoint/ программ хангамжуудаар кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох хариу арга хэмжээ авч байна.
- Кибер халдлага, зөрчлийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, заавартай байгууллага байхгүй байна.
- Программ хангамжийн албан ёсны эрх худалдан авахад зарцуулах зардал, мөн кибер аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг 2024 оны төсвийн төсөлд санал өгсөн байгууллага 4 байна.
- Мэдээлэл технологийн чиглэлээр бусдаар ажил гүйцэтгүүлэхдээ нууцын гэрээ эсвэл ажил гүйцэтгэх гэрээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар тусгайлсан заалт оруулсан байгууллага 4 байна.

- Түүвэрт хамрагдсан байгууллагуудын нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах талаар тусгасан албан хаагчийн тоо 11 байна.


**ДҮГНЭЛТ: Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа**

Аюулгүй байдлын төхөөрөмж, хортой код илрүүлэх программ хангамж дээр илрүүлэлтээ хийж байгаа боловч, кибер халдлага, зөрчил илэрсэн тохиолдолд бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах, урьдчилан сэргийлэх, танин мэдүүлэх нэгдсэн арга хэмжээний тогтолцоо тодорхойгүй байна.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудын нийт албан хаагчдыг мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах талаар ажлын чиг үүрэгт иж бүрэн тусгаагүй байна. Мэдээлэл технологийн чиглэлээр бусдаар ажил гүйцэтгүүлэхдээ нууцын гэрээ эсвэл ажил гүйцэтгэх гэрээний тусгайлсан заалтаар оруулж байгаа боловч явцын хяналт, хэрэгжилтэд авсан арга хэмжээний бүртгэл, баталгаажуулалт мэдээлэл хангалттай бус байна.


**ХОЁР. Эрсдэлийн удирдлага**

Барилга, хот байгуулалтын яам



БХБЯ нь хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн журмыг боловсруулсан сайн талтай боловч, энэ нь нэг удаагийн үйл ажиллагаа бөгөөд хугацааны хувьд 2019 оны ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал ажиглагдсан. Үүнд:


- Эрсдэлийн үнэлгээний журам байгаа боловч, мэдээллийн технологийн эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалтгүй байна.



БШУЯ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн технологийн өнөөгийн нөхцөл байдал, мэдээллийн чанар, хэрэглээ, нууцлал, аюулгүй байдал мэдээллийн технологийн аудит, эрсдэлийн үнэлгээг хийлгэх хүсэлтийг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүргүүлсэн байна. Хүсэлтийн дагуу тус газраас ажлын хэсэг томилогдож, эрсдэлийн үнэлгээг 2022.10.11-11.08 хооронд БШУЯ, БЕГ, БМТТ, БЗС, БСҮХ, БҮТ-д хийсэн байна. Үнэлгээгээр маш өндөр 16, өндөр 57, дундаж 7 гэсэн эрсдэл дүгнэгдсэн байна. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд

мэргэжлийн байгууллагаар өргөн хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн сайн талтай боловч биелэлт 50 хувьтай байна. Ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал байна. Үүнд:


- Эрсдэлийн удирдлагын журам, эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалттай бус байна.



Сангийн яам нь 2022 оны 11 сард Домэйн удирдлагын систем, finance.gov.mn төрийн сангийн төлбөр тооцооны системд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэх хүсэлтийг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүргүүлсэн. Үнэлгээг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд хийж, 2 зөвлөмж өгсөн ба биелэлт 100 хувьтай байна. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд эрсдэлийн үнэлгээг тухайлсан

системүүдэд хийлгэж байгаа сайн талтай боловч ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал байна. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын журам, эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалттай бус байна.



ХНХЯ нь эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй бөгөөд ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал байна. Үүнд:

- Хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийн удирдлагын журам, эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын

дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.

- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалттай бус байна.




ЭЗХЯ нь 2022 оны 1 сард байгуулагдсан бөгөөд одоогоор хөндлөнгийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна. Эрсдэлийн бүртгэлийг хийж эхэлсэн байна. ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал байна. Үүнд:

- Хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийн удирдлагын журам,

эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.

- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалттай бус байна.





ЭМЯ нь нийт 51 харьяа байгууллагатай ба 2 байгууллага нь эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна. Нэгдсэн байдлаар мэдээлэл цуглуулж, нэгтгэгдээгүй. Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар ЭМС-н албан даалгавар 2023 оны 04 сард харьяа байгууллагуудад даалгасан боловч хэрэгжилтийн тайлан одоогоор нэгтгэгдэж гараагүй байна. ЭМЯ нь хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээг хэсэгчилсэн байдлаар хийлгэдэг боловч, баримжуулах тайлан мэдээллийг ирүүлээгүй байна. Ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын дүнд доорх асуудал байна. Үүнд:

- Хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийн удирдлагын журам, эрсдэл бууруулах төлөвлөгөө, гэмтэл саатлын дараах нөхөн сэргээх төлөвлөгөө, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
- Эрсдэлийн үнэлгээний үйл явц болон санхүүжилтийн тогтвортой байдал хангалттай бус байна.

**Дүгнэлт: Эрсдэлийн удирдлага**

- Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8.3-т заасан Кибер аюулгүй байдлын эрсдэлийн

үнэлгээ хийх журам, аргачлалыг ЦХХХЯ, Тагнуулын байгууллагын хамтран батлах бөгөөд журам батлагдаагүй, төсөл боловсруулагдаж байна.

- Түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагуудын хувьд эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо хангалттай бүрдээгүй. Тухайлбал, Эрсдэлийн үнэлгээг тогтмол, тогтвортой хийлгэх үйл явц бүрдээгүй. Эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, гэмтэл, саатал гарсан тохиолдолд авах арга хэмжээний зураглал, төлөвлөгөө тодорхойлогдоогүй байна.

**Зөвлөмж: Эрсдэлийн удирдлага**

ЦХХЯ, Тагнуулын байгууллага нь эрсдэлийн үнэлгээний журам, аргачлалыг боловсруулахдаа нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх чиглэлийг баримтлах ба урьдчилсан суурь судалгаанд үндэслэн, бүртгэл, мэдээллийн урсгал, хариу арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, дүн шинжилгээ мэдээлэх үйл явцыг тодорхой ойлгомжтой тодорхойлох; Журам, аргачлалын Монгол, Англи нэр томъёоны тайлбарыг тодорхойлолт хэлбэрээр, холбогдох хууль, журам дүрмийн үг хэллэгтэй нийцүүлж боловсруулах;

**ГУРАВ. Мэдээллийн технологийн үйлчилгээний удирдлага**



Мэдээллийн технологийн үйлчилгээний удирдлагын байдлыг түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагуудын ирүүлсэн мэдээлэл, ярилцлагын хүрээнд авч үзвэл:

1. Мэдээлэл технологийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад журам, дүрмийн үл тохирол гарсан үед тохиолдлыг бүртгэх, авах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай байна. БХБЯ, БШУЯ асуумжид тодорхойлогдсон гэсэн боловч бүртгэл, арга хэмжээ авсан байдлыг баримтжуулсан баримт ирүүлээгүй байна.
2. Системийн тохиргоо (system configuration)-ны баримт бичгийн бүрдэл, хадгалах, ашиглах үйл явцын бодлого, журам, дүрэм түүвэрт хамрагдсан шалгагдагч байгууллагуудад хангалтгүй байна. БХБЯ нь асуумжид байгаа гэж хариулсан боловч баримтжуулсан баримт бичиг ирүүлээгүй байна.
3. Түүвэрт хамрагдсан байгууллагууд мэдээллийн системийн хугацаат шинжилгээ хийдэг тогтолцоо хангалттай бүрдээгүй. БХБЯ нь хийдэг гэсэн боловч баримтжуулсан тайлан, авсан арга хэмжээний баримт ирүүлээгүй байна.
4. Системийн гэмтэл саатлын үеийн шийдвэрлэлтийн тайланг гаргадаг тогтолцоо хангалттай бүрдээгүй. БХБЯ нь гаргадаг гэсэн боловч баримтжуулсан тайлан, авсан арга хэмжээний баримт ирүүлээгүй байна.
5. Түүвэрт хамрагдсан байгууллагууд 100 хувь Кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан зориулалтын техникийн өрөөтэй байна. Сангийн яам нь 2022 оны 12 сард түвшний дата төвийг байгуулсан ба 32 зогсуур, 12 сервер, 120 VPS ажиллаж байна. БШУЯ нь улсын хэмжээний боловсролын байгууллагын нэгдсэн интернет сүлжээгээр хангадаг. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 2015-2017 онд Шинэ зууны боловсролын төслөөр 27 сүлжээний зангилаа төвийг байгуулан, дата төв ажиллаж байна.
6. Өгөгдөлд хандах эрхийн тохиргоог зохицуулах журамтай 4 байгууллага байна. Үүнд:
  - БХБ-ын сайдын 2017 онд баталсан “Мэдээллийн системийн администраторын журам”-д,
  - БШУ-ы сайдын 2022 онд баталсан “Мэдээллийн системийн нэвтрэх эрхийн зохицуулалт”-ын журамд,
  - Сангийн сайдын 2014 онд баталсан Сангийн яамны мэдээллийн технологийн цогц журмын 14-р хавсралтад,
- ЭМ-ийн сайдын 2019 онд баталсан “Цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдал”.
7. Өгөгдөлд хандах эрхийг зохицуулах журам байгаа боловч харьяа байгууллагуудаар мэдээллээ нэгтгэж, үнэлгээ хийж, түүний дагуу хэрэгжилтийг хангуулах ажлыг тогтворжуулах шаардлагатай байна. Бусад байгууллагууд гэрээний хэсэг болох системийн ажлын даалгаварт, эрхийн зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох байдлаар хэрэгжиж байна.
8. Системийн хэрэглэгчийн эрхийн тохиргоо, хэрэглэгчийн нэр, нууц үгийн бодлогыг баримтжуулж, албан хаагчдад таниулах арга хэмжээг дээр дурдсан эрхийн зохицуулалттай 4 байгууллагын журамд нууц үгийн дүрмийг тавьж өгсөн байна. Баримтжуулж бүртгэх, өөрчлөлтийг бүртгэх тогтолцоо бүрдээгүй байна. Харьяа байгууллагаар нэгтгэсэн мэдээ, үнэлгээ, хэрэгжилтийн тайлан аудитын явцад нотолгоог ирүүлээгүй байна. Бусад байгууллагууд гэрээний хэсэг болох системийн ажлын даалгаварт хэрэгцээ шаардлагын түвшинд тодорхойлох байдлаар хэрэгжиж байна.
9. Систем гүйцэтгэгч байгууллагын өгөгдлийн санд хандсан лог бүртгэл 3 байгууллагад байдаг гэсэн байна. Баримтжуулсан тайлан, арга хэмжээний баримт ирүүлээгүй байна. Бүхий л мэдээллийн системүүд дээр технологийн хувьд лог бүртгэл үүсэж байгаа боловч анализ хийж, нэгтгэсэн мэдээ, тайлан гаргадаг тогтолцоо хангалттай бүрдээгүй байна.
10. Түүвэрт хамрагдсан байгууллагуудад их өгөгдөл үүсэх боловч нийт өгөгдлийн өсөлтийг статистик дүн шинжилгээний хүрээнд л гаргаж байна. Технологийн хувьд өгөгдлийн сангийн өсөлтийн тооцоолол хангалтгүй байна. БХБЯ өгөгдлийн өсөлтийг тооцоолдог гэсэн боловч баримтжуулсан тайлан, мэдээ ирүүлээгүй байна.
11. Түүвэрт хамрагдсан байгууллагуудын ихэнх албан хаагч УБЕГ, ҮДТ УТҮГ, Нэвтрэлтийн нэгдсэн систем хэрэглэгч байгууллагууд нэвтрэлтийн эрхтэй байна. Түүвэрт хамрагдсан байгууллагын хүрээнд цахим гарын үсгийг нэвтрүүлсэн 4 байгууллага, нийт 52 хэрэглэгч хэрэглэж байна гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.
12. Мэдээллийн системийн нэвтрүүлэлтийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн зохион байгуулалтыг яамдын хувьд авч үзэхэд:

- Систем хөгжүүлэгч байгууллага гэрээний хүрээнд нэвтрүүлэлт, хөгжүүлэлтийн дараах тогтворжуулах ажлыг хариуцаж байна. Гэхдээ энэ үйл ажиллагаа нь олон системтэй, олон гүйцэтгэгчтэй байгууллагын хувьд тус тусдаа хариуцаж байгаа нь нэгдсэн зохицуулалт, бодлого хэрэгжүүлэх, хянахад хүндрэл учирч байна. Жишээ нь: ЭМЯ нь олон систем, программ хангамжийн гүйцэтгэгч байгууллагуудтай, харьяа байгууллагууд мөн системийн нэвтрүүлэлт, хөгжүүлэлт дагнан хэрэгжүүлдэг бөгөөд хяналт тавихад хүндрэлтэй тул Засгийн газарт Эрүүл мэндийн мэдээллийн технологийн төв байгуулах талаар санал хүргүүлсэн байна.
- БШУЯ, Сангийн яамны харьяа ТШЗ-ийн Мэдээлэл технологийн төв нь систем хөгжүүлэлт, туршилт, нэвтрүүлэлт, тогтворжуулах ажлыг хариуцаж байна. Бусад байгууллагуудын хувьд дээрх ажлуудыг дагнан хэрэгжүүлэхгүй байгаа тул үнэлэх боломжгүй байна.
- Яам болон харьяа байгууллагуудад ашиглаж буй дотоод үйл ажиллагааны программ хангамж, системийг тухайн байгууллагын бүтцийн нэгжүүд хариуцаж байна.



**ЦАХИМ ХӨГЖИЛ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**



**МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160  
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,  
Цахим шуудан: info@mddc.gov.mn,  
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.12.14 № 09/2580

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн тайлангийн төсөлтэй танилцаад, холбогдох санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>1/431</sup>..... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА  Б.БАТЦЭЦЭГ



4522007284



ЦХХХЯ-ны саналын дэлгэрэнгүйг  
QR кодыг уншуулж танилцана уу.

## “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг шийдвэрлэсэн байдал

ЦХХХЯ-наас ирүүлсэн 34 санал, тайлбарыг аудитын баг нягтлан үзэж, 13 саналыг хүлээн авч тухайн хэсэгт найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд 21 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн. Үүнд:

№	Шийдэл	Саналыг хүлээж авсан	Саналыг хүлээж аваагүй	Нийт
1	Тухайн хэсэгт найруулгын өөрчлөлттэй холбоотой	13	9	22
2	Холбогдох нотлох зүйлээр дэмжигдээгүй	-	4	4
3	Хамааралгүй тул тайлангаас хасах шаардлагагүй	-	5	5
4	Тайланд дурдсан асуудалтай агуулгын хувьд зөрчилдсөн асуудал байхгүй	-	3	3
Нийт		13	21	34

### Саналыг тусгасан байдал

№	Хамааралтай бүлэг/хэсэг	ЦХХХЯ-ны ирүүлсэн санал	ҮАГ-ын тайлбар
1	<b>1-р бүлэг Дүгнэлт хэсэг</b>	“...дүгнэлт, зөвлөмж авах тухай зохицуулалт хангалтгүй хэрэгжиж байна.” гэснийг ...дүгнэлт, зөвлөмж авах тухай зохицуулалт хангалтгүй байгаа нь нийтийн мэдээлэл хариуцагч нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.	...дүгнэлт, зөвлөмж авах тухай зохицуулалт хангалтгүй хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь нийтийн мэдээлэл хариуцагч нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.
		Үндэсний зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд НМИТБТХ-н 34 дүгээр зүйлд заасан Мэдээлэл хариуцагчийн нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар хүлээх үүргийн дагуу салбар тус бүр тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байгаа тул салбар тус бүрд зөвлөмж хүргүүлэх саналтай байна.	<b>Хураангуй хэсэгт:</b> Цаашид үндэсний зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд цогц шийдэлгүйгээр салбар бүрийн “хэт ашиг сонирхолд хөтлөгдсөн, өндөр зардалтай арга хэмжээ”-г хэрэгжүүлж байгаа явдалд анхаарч үүний эсрэг нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн үр ашигтай төлөвлөлтөд нийцсэн арга хэмжээг нэгдмэл удирдлагаар хангах ажлыг ЦХХХЯ болон Сангийн яам хамтран санал боловсруулж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.
2	<b>1-р бүлэг 1.114 дэх хэсэг</b>	Мөн тус хуулийн 29.1. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулна гэснийг салбар бүр хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.	<b>Тайлангийн зөвлөмж хэсэгт:</b> НМИТБТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасан мэдээлэл хариуцагч мэдээллийн цахим санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр бүртгүүлэх, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргуулах, мөн хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллах.
3	<b>1-р бүлэг 1.72, 1.73 дэх хэсэг</b>	“...бүтцийн түвшинд” гэсний дараа “мэдээллийн технологийн чиглэлд ЦХХХЯ-ны бүтцэд Цахим засаглалын хэлтэс, И-Монгол академи УТҮГ-т Салбар дундын зохицуулалтын газар ажиллаж байна.” гэж өөрчлөх.	1.72 ЦХХХЯ-ны зөвхөн Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах зохион байгуулалтын бүтцэд 2 албан хаагч салбар болон салбар дундын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээн ажиллаж байна. Үүнээс гадна ЦХХХЯ-ны бүтцэд Цахим засаглалын хэлтэс, И-Монгол академи УТҮГ-т салбар дундын зохицуулалтын газар ажиллаж байна; 1.73-аас холбогдох хэсгийг хассан.

4	<p><b>Зөвлөмж</b></p>	<p>“Өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, ашиглахтай холбоотой эрх зүйг орчинг бүрдүүлсэн хэдий ч хуулийн хэрэгжилтийг сайжруулах, түүнээс бий болох үр өгөөж, боломж, ач холбогдлыг Засгийн газрын бүх түвшинд болон иргэд, олон нийтэд таниулан сурталчлах” гэж өөрчлөн найруулах.</p>	<p>Өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах, түүнээс бий болох үр өгөөж, боломж, ач холбогдлыг Засгийн газрын бүх түвшинд болон иргэд, олон нийтэд таниулан сурталчлах</p>
	<p><b>1-р бүлэг Гарчиг</b></p>	<p>Нийтийн өгөгдлийн дэд бүтцийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай гэснийг “Өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай болгох.</p>	<p>Харилцаа холбооны болон бусад салбарын хуулийн уялдааг хангах, салбар дундын зохицуулалт, нийтийн өгөгдөл, мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай</p>
5	<p><b>1-р бүлэг 1.13 дахь хэсэг</b></p>	<p>ХХМХТХ-иар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж, НМИТБТХ-иар иргэний мэдээлэл авах эрхийн эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн гэх боловч төр, хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, шинжлэх ухааны байгууллага, олон улсын байгууллагын үйлдвэрлэж буй өгөгдөл, мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл хэлбэрээр олон нийтэд түгээж, эдийн засгийн эргэлтэд оруулахад мэдээлэл хариуцагч төрийн байгууллагуудын идэвх санаачилга дутагдаж байна.</p>	<p>Саналыг тусгасан.</p>
6	<p><b>1-р бүлэг 1.31 дэх хэсэг</b></p>	<p>Цахим хөгжлийн зорилт, арга хэмжээний талаарх бүхий л баримт бичигт туссан хэрэгжилтийг нэгтгэн хянаж, үнэлэх тусгайлсан чиг үүрэг болон дүрэм журам байхгүй. ЦХХХ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2022-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний ямар хэсгүүд нь журамд нийцэж байгаа нь ойлгомжгүй байна.</p>	<p>Ирүүлсэн тайлбар саналыг харгалзан дараах өөрчлөлтийг оруулав. Үүнд: Монгол Улсын урт, дунд, богино, хугацааны бодлогод тусгасан цахим засаглал, цахим хөгжлийн тухайлсан зорилт, арга хэмжээ болон бусад салбарын хөгжлийн бодлогыг дэмжсэн цахим хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтүүдийг нэгтгэн, салбар хоорондын уялдааг хангах, үнэлэх, хянах ажил хийгдэхгүй байна.</p>
7	<p><b>1-р бүлэг 1.58, 1.59, 1.60 дахь хэсэг</b></p>	<p>1.58, 1.59, 1.60 дахь хэсгүүдийг тус тус хасуулах санал ирсэн.</p>	<p>1.58, 1.59 дахь хэсэгт тус тус холбогдох өөрчлөлт оруулсан. Мөн 1.60 дахь хэсгийг хассан.</p>
8	<p><b>1-р бүлэг 1.99 дэх хэсэг</b></p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын хуулиар ил тод байлгах үүрэгтэй 68 төрлийн мэдээллийг өргөтгөн, 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, долоо хоног тутамд shilen.gov.mn платформоор дамжуулан “Шилэн индекс”-ээр зарлаж байгаа нь сайшаалтай хэдий ч тухайн шалгуур үзүүлэлтийг үнэлэх журмын зохицуулалтыг нарийвчлан, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.</p>	<p>Саналыг тусгасан.</p>
9	<p><b>2-р бүлэг 2.7 дахь хэсэг</b></p>	<p>Уг заалтыг хасах.</p>	<p>Тус арга хэмжээг ХХЗХ-ны санхүүжилтээр хийдэг тул төсвийн төсөлд санал хүргүүлэх шаардлагагүй гэж нэмсэн.</p>
10	<p><b>2-р бүлэг 2.37 дахь хэсэг</b></p>	<p>Уг заалтыг хасах.</p>	<p>Саналыг тусгасан.</p>
11	<p><b>2-р бүлэг 2.69 дэх хэсэг</b></p>	<p>Цахим Монгол зорилтын хүрээнд хэрэгжүүлж байгаа ямар арга хэмжээний гүйцэтгэл удаашралтай гэж үзэж байгааг хариуцсан асуудал нэг бүрээр байгууллагын нэршилтэй тодорхойлох шаардлагатай. Өөрөөр хэлбэл дүгнэлт хэт ерөнхий байгаа ба 2023 оны 12 дугаар сарын байдлаар Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах хэрэгжилтүүд нэмэгдэж байгаа.</p>	<p>Зорилтын хүрээнд хэрэгжих 86 арга хэмжээний явц, гүйцэтгэлийг үнэлэхэд 38 арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичигт заасан цаг хугацаанд хэрэгжсэн, харин 48 арга хэмжээ нь цаг хугацаандаа хэрэгжээгүй байна. Цаг хугацаандаа хэрэгжээгүй арга хэмжээнээс хүрэх түвшин, үр дүндээ хүрсэн 3, хэрэгжиж байгаа 26, хэрэгжээгүй 19 арга хэмжээ байна. Хавсралт 2.6-г нэмсэн</p>
12	<p><b>2-р бүлэг 2.70 дэх хэсэг</b></p>	<p>Уг заалтыг төсөв нь батлагдаагүй арга хэмжээнээс хасах.</p>	<p>Саналыг тусгасан</p>

13	<b>2-р бүлэг</b> <b>2.71 дэх хэсэг</b>	<p>Монгол Улсын хэмжээнд тоон гарын үсгийн тоо, хэрэглээний төрөл нэмэгдэж байгаа ч нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажил хийгдээгүйн улмаас үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж, олон улсын жагсаалтад оруулах боломжгүй байна. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх, Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэх төслийн саналыг боловсруулж Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 дугаар албан тоотойр 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг хүргүүлсэн боловч Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, ирэх оны төсвийн төсөөлөлд тусгагдаагүй байна.</p>	<p>Монгол Улсын хэмжээнд тоон гарын үсгийн тоо, хэрэглээний төрөл нэмэгдэж байгаа ч нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх ажил хийгдээгүйн улмаас үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж, олон улсын жагсаалтад оруулах боломжгүй байна. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 дугаар албан бичгээр 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг хүргүүлсэн боловч төсвийг батлаагүй байна.</p>
----	---	---	---

## Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал



### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/167

Улаанбаатар хот

#### Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дарга Л.Оюун-эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн албаны зөвлөл (Б.Баатарзориг), Үндэсний статистикийн хороо (Б.Батдаваа), Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Д.Амарбаясгалан), Сангийн яам (Б.Жавхлан), Хууль зүй, дотоод хэргийн яам (Б.Энхбаяр), Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), Эрүүл мэндийн яам (С.Чинзориг), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Х.Булгантуяа), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Б.Бат-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын баримт болон нотлох зүйлийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын менежер (П.Цэнгүүн)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

  
Д.ЗАНДАНБАТ




Z:\Тушаал\2023\Тушаал\ЕА-Ын А Тушаал\1225 ANUZG-1.Docx

0001011035



Монгол Улсын Ерөнхий аудиторовн  
2023 оны 12 дугаар сарын 25 ны  
өдрийн 12 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын  
хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн  
гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
Цахим хөгжил, харилцаа холбооны яам			
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4.1.5-д “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ” заасан зорилтын хүрээнд хэрэгжүүлэх “Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” арга хэмжээний хэрэгжилт, явцыг үнэлэхэд шаардлагатай /Төрийн нууцад хамаарах/ мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөөгүй;	1142/E0121107 ҮАГ-ХБТГ- 2023/21-ШТА-ГА	
2	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсээс арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 1 арга хэмжээний 7 худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй бүртгэл, мэдээллийг аудитын багт өгсний дагуу нотлох зүйлийг үнэлж Төрийн худалдан авах ажиллагааны газраас мэдээлэл авахад 19 арга хэмжээний 21 худалдан авах ажиллагаанд холбогдох мэдээллийг үнэн зөв, бодитой гаргаж өгөөгүй;		
3	Монгол улсын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын бодлогын хэрэгжилтийг хэмжих 8 багц 92 үзүүлэлтээс 42 үзүүлэлтийг тооцохгүй байгаа шалтгаан, тайлбарыг үзүүлэлт бүрээр гаргаж өгөөгүй;		
Байгаль орчин, аялал жуулчлалын яам			
1	Байгаль орчин аялал жуулчлалын яам нь Тайланд улсын “Камелеон Стратежиз” ХХК-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд аялал жуулчлалыг сурталчлах, идэвхжүүлэх зорилготой <a href="http://www.mongolia.travel">www.mongolia.travel</a> цахим платформ бий болгох, контент хөгжүүлэх ажлын гэрээг 2018.10.29-нд байгуулсан гэрээг эцэслэн дүгнээгүй, өр төлбөр бүрэн барагдаагүй байна. Үүнээс шалтгаалж тус платформын эрхийг шилжүүлж авч чадаагүй ба ашиглах, хөгжүүлэлт хийх боломжгүй байна.	1141/E0110132 ҮАГ-ХБТГ- 2023/21-ШТА-ГА	441.1 сая төгрөг
2	Байгаль орчин аялал жуулчлалын яам нь өмнөх <a href="http://www.mongolia.travel">www.mongolia.travel</a> платформд их хэмжээний хөрөнгө зарцуулсан боловч гэрээ эцэслэн дүгнэлгүй шинэ <a href="http://www.mongoliatravel.guide">www.mongoliatravel.guide</a> вэбсайтын ажлыг эхлүүлж “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ-тай 2022 оны 06 дугаар сард шууд гэрээ байгуулсан. Тус ТББ нь яамны зарим чиг үүргийг хэрэгжүүлэн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа сонгон шалгаруулалт хийлгүйгээр “Ворлд Плас” ХХК -тай шууд гэрээ байгуулсан. Тус яам нь “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ болон гүйцэтгэгч аж ахуйн нэгж хооронд байгуулсан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, ТББ болон гүйцэтгэгч компанид давуу эрх олгосон.		200.0 сая төгрөг





**Үндэсний аудитын газар**

Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3,  
Засгийн газрын IV байр  
Улаанбаатар хот 15160

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
[www.audit.mn](http://www.audit.mn)

(+976) 51-261745

(+976) 11-322071



Энэхүү тайлан нь Европын холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. ЕХ, НҮБХХ энэхүү тайланд гарсан тоо баримтын үнэн зөв эсэхийг баталгаажуулахгүй бөгөөд тоо баримтыг ашигласнаар гарах үр дагаврыг хариуцахгүй.